

Туршилтын Баталгаажуулалтын Тайлан: Монгол Улс

Төсөл: 2015 оны 11 сарын 24-ны өдөр

ОҮИТБС Олон Улсын Нарийн Бичгийн Дарга нарын Газар

Хараат бус хянагч: /тодорхойлно/

Товчлол

МБ	Монгол Банк
НТТХ	Нэгдсэн төсвийн тухай хууль
ИНБ	Иргэний нийгмийн байгууллагууд
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк
ОДХД	Олборлолтын Дэлхийн Хөтөлбөрт Дэмжлэг
ОУИТБС	Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга
ЭТТ	Эрдэнэс Таван Толгой
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ТЕХ	Татварын Ерөнхий Хууль
ОХИС	Олон Хандивлагчдын Итгэлцлийн сан
МБОИЗ	Монголын байгаль орчны иргэний зөвлөл
МУУҮА	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци
Төг	Монгол төгрөг
СЯ	Сангийн Яам
АМГ	Монгол улсын Ашигт малтмалын газар
ОТОБ	Олон талт оролцогчдын бүлэг
ОТОАХ	Олон талт оролцогчдын ажлын хэсэг
ҮЗ	Үндэсний Зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
БНЗИ	Байгалийн нөөцийн засаглалын институт
ГТГ	Монгол Улсын Газрын Тосны Газар
БХГ	Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТАН	“Төлсөн, Авснаа Нийтэл” Эвсэл
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
АЖ	Ажиллах журам

Агуулга

Товчлол	2
Хураангуй	4
Ерөнхий Дүгнэлт	4
Зөвлөмж	7
Хэсэг I – Олон Талт Оролцогч Талуудын Хяналт.....	13
Хэсэг III – Үр дүн ба нөлөөлөл.....	68
Хавсралт	83
Хавсралт А – Олон талт оролцогчдын бүлгийн гишүүдийн жагсаалт, холбоо барих хаяг.....	83
Хавсралт В – Оролцогч талуудын жагсаалт	87
Хавсралт С – Бусад хамааралтай баримт бичиг.....	90
Хавсралт D- ОУИТБС-ын тайлангийн нэгтгэл болон ил тод байдлын бүдүүвч	94
Хавсралт E – МОУИТБС болон Баталгаажуулалтын тайлангийн дэлгэрэнгүй мэдээлэл	95

Хураангуй

Монгол Улсын Засгийн газар 2006 оны 1 дүгээр сард Засгийн газрын 1-р тогтоол гаргаж, Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгыг (ОУИТБС) хэрэгжүүлэхээ албан ёсоор нийтэд зарласан юм. Олон Талт Оролцогчдын Ажлын Хэсэг нь (ОТОАХ) 2006 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улс нь ОУИТБС-ын нэр дэвшигчээр 2007 оны 09-р сард хүлээн зөвшөөрөгдсөн. ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн анхны Баталгаажуулалтын дараагаар, 2010 оны 10 сард Монгол улс ОУИТБС-ын "шаардлагыг бүрэн хангасан" дэлхийн дөрөвдөгч орноор шалгарав.

2015 оны 11 сард Монгол Улс ОУИТБС-ын стандартад нийцэж буй эсэх туршилтын баталгаажуулалт бөгөөд энэхүү тайлангаар туршилтын үр дүн болон үнэлгээг танилцуулсан. Олон улсын Ажлын Алба нь Монгол улсыг ОУИТБС-ын стандарттай нийцэж байгаа эсэх байдалд стандартын шаардлагыг ашиглан үнэлгээхийсэн. Үнэлгээг хараахан Олон Талт Оролцогчдын Бүлэг (ОТОБ) хянаагүй, чанарын шаардлага хангасан эсэхийг шалгаагүй ч, Ажлын албаныурьдчилсан үнэлгээгээр 1.4, 3.4, 3.5, 3.6, 3.9, 3.10, 4.1a, 4.1c, 4.1e, 4.2a-c, 5, 7.2 шаардлагууд хангагдаагүй байна гэж үзсэн. Эдгээрийн зарим нь "ажлын явц хязгаарлагдмал байгаагаас нийцээгүй" гэж үнэлэгдсэн байна. Анхаарч үзэх гол хүчин зүйл нь засгийн газар, аж үйлдвэр болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн засгийн газартай хийх санхүүгийн шилжүүлэг, төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр, мөнгөн бус орлого зэрэг мэдээллийн чанар шалгалт байна. Дэд шаардлагыг тус бүрээр засч залруулах арга хэмжээг дор санал болгож байна.

Ерөнхий Дүгнэлт

Монгол Улс нь ОУИТБС-ын тайлангийн хүрээнд хамгийн олон тооны компанийг хамруулснаас гадна, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх анхны улс орнуудын нэг байж ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч тэргүүлэгч улс болсон. Түүнчлэн байгаль орчны санд хувь нэмэр оруулаад зогсохгүй, орон нутгийн захиргааны нэгжийн хүрээнд тайлагнах, орон нутгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийг байгуулж, шинэ цахим тайлагналын платформоор дамжуулан ОУИТБС-ын өгөгдлийг илүү хүртээмжтэй хүргэх зэргээр тайлагналын хамрах хүрээг тэлсэн.

Улс орон нь 2007 онд ОУИТБС-ын нэр дэвшигч болсноор Засгийн газраас олон нийтийн мэдэгдэл хийх, холбогдох хууль тогтоомжгаргах зэргээр ОУИТБС-ыг дэмжсээр ирсэн. Мөн Ашигт Малтмалын Газар, Татварын Ерөнхий Газар гэх мэт байгууллагуудын төлөөллүүд нь Монгол улсын Олон Талт Оролцогчдын Ажлын Хэсгийг(ОТОАХ) удирдахад идэвхтэй хувь нэмрээ оруулж, ОУИТБС-ын тайланд зориулан мэдээллээр ханган, ОУИТБС-ын тайланг Засгийн газрын системд оруулахыг дэмжин ажиллаж байна.

Монгол улсад ОУИТБС-ын хэрэгжилтийг бэхжүүлэх бас нэг гол түлхүүр нь ОУИТБС-ын тайланд ОУИТБС-ын стандартаар шаардлагатай гэж үзээгүй ч тухайн орон нутагт өндөр ач холбогдолтой гэж үзсэн газруудыг хамруулахад оршсон. Тэр ч байтугай 2013 оны ОУИТБС-ын стандарт батлагдахаас өмнө, ОТОАХ нь компаниудын нийгмийн хариуцлагын зардал, байгаль орчны нөхөн сэргээлтийн санд оруулсан хувь нэмрийн талаарх мэдээллийг оруулсан байна. Тэр цагаас хойш энэ байдал нь үргэлжилж, улмаар бенефициар өмчлөл, болон гэрээний ил тод байдал дээр ажиллаж байна.

Аажмаар ажлын хэсэг нь гурван оролцогч талуудын бүлгийн дунд итгэлцлийг бий болгосон боловч, энэ нь ажлыг чиглүүлэгч гэхээс илүүтэйгээр хяналтын хүчээр хангасан. Харин энэ үүргийг гүйцэтгэгч нь ОУИТБС-ын Монгол дахь Ажлын алба бөгөөд ОБОАХ-ээс томилсон түр хорооны ажлыг зохицуулдаг. Эдгээр албан бус ажлын хэсэг нь ОУИТБС-ын тайлан зөвлөмжийн хэрэгжилтийг хянах болон тайлангийн загварыг шинэчлэх гэх мэт гол ажлуудыг хийж гүйцэтгэдэг байхад албан ёсны зөвшөөрөл, бүртгэл хөтлөлт зэрэг нь дутагдалтай байгаагаас ОУИТБС-ын

Ажлын алба өндөр хариуцлага хүлээж байна. Үндэсний зөвлөл ОТОАХ-ийн ажлыг дээд түвшинд хариуцдаг боловч үйл ажиллагаа нь ихэвчлэн дээд түвшиний гишүүдийн оролцоо сул, улс төрийн тогтворгүй өөрчлөлт зэргээс шалтгаалан үйл ажиллагаагаа хангалттай явуулж чадахгүй байна. Энэ нь одоо албан ёсны ОТОАХ-ийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарыг зарим нэг удирдлагын хариуцлагын нь чөлөөлөхийн тулд Монгол Улс дахь ОҮИТБС-ын хэрэгжилтийн зохион байгуулалтын бүтцийг цаг тухайд нь дахин авч үзэх хэрэгтэй юм шиг санагдаж болох юм.

Монгол улс нь 2012 оноос хойш эдийн засгийн огцом уналтын нөлөөллөөс болж 1500 гаруй компани, түүний 400 гаруй үйлдвэрлэгчийн хувьд байнга өөрчлөгдөж байдаг уул уурхайн татварын төвөгтэй хэргийг ОҮИТБС-т танилцуулж байна. Хэдийгээр ОТОАХ-ын сүүлийн жилүүдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд өндөр анхаарал тавьж, тайлангийн хамрах хүрээг 1100 компаниар тэлсэн ч зөвхөн тав нь Хараат бус хянагчаар хянагдсан байна. ОТОАХ

Энэхүү нэгтгэлд өгч буй ач холбогдол нь ОҮИТБС-ын Дүрмээс ОҮИТБС-ын Стандартад шилжих явцад гарч буй шаардлагатай байгаа үндсэн мэдээлэлтэй тэр бүртгээр байгаагүй. ОТОАХ нь ОҮИТБС-ын стандартын дагуу шаардлагатай үндсэн мэдээллийг бүрэн хамрах хүрээг гүнзгий харгалзан үзээгүй юм шиг харагдаж байгаа ч, хэрвээ Төрийн өмчит аж ахуйн нэгжийн иймэрхүү асуудлуудыг зөв хандлагаар зохистой авч үзэж чадвал энэ нь зөвхөн олон нийт төдийгүй хөрөнгө оруулагчид, бодлого боловсруулагчдын анхаарлыг ихээр татах болно. Энэхүү тайланд онцолсон ОҮИТБС-ын тайлан дахь гол ялгаа нь төрийн өмчит аж ахуйн нэгжийн (ТӨААН) эргэн тойрондох өгөгдлийн чанар, ил болгохтой холбоотой байна. ОҮИТБС-ын тайлангийн төслийг боловсруулахад оролцох ОТОАХ-ийн оролцоо нь ОҮИТБС-ын стандартын шаардлагын мэдээлэл бага байгаагаас хязгаарлагдмал байна. ТӨААН-д олгох зээл тойрсон зарим мэдээлэл нь улс төрийн хувьд эмзэг сэдэв байж болох ч, Ашигт Малтмалын Газар(АМГ)-аас гаргасан бүтээгдэхүүний тоо хэмжээ гэх мэт бусад олон нийтэд нээлттэй өгөгдөл олж авахад боломжгүй гэх зүйлгүй.

Монгол улс уул уурхайгаас ихээхэн хамааралтай байгаа нь салбарын менежментийн талаар төрийг уул уурхайн салбарын цаашдын хэтийн төлөв болон салбарт оролцуулах түвшинд хүртэл хүчтэй үндэсний мэтгэлцээн явагдаж байна. Энэ мэтгэлцээнд ОҮИТБС-дүүргийн (сумын) болон аймаг (аймгийн) түвшинд хүргэж буй үйл явдал болон семинараар дамжуулан хувь нэмэр оруулж байна. ОҮИТБС-ын тайлан гаргагч компанийн тоо нь тогтвортой нэмэгдэж байгаа ч, ОТОАХ нь энэхүү их хэмжээний мэдээллийг тодорхой бүлгүүдэд зориулан нэгтгэх зорилготой. ОҮИТБС-ын Ажлын албанаас нийт 12 сум болон 4 аймаг ОҮИТБС-ын тайлангийн хураангуйг боловсруулан гаргаснаас гадна, байршилд тулгуурлан компанийн төлбөрийг шалгах боломжийг хэрэглэгчдэд олгох, компаниудын лицензийн зураглалыг интерактив цахим тайлангийн порталд гаргасан байна. Иргэний нийгмийн олон байгууллага энэ хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож байна. ОҮИТБС-ын эхний тайлангаар чухал ач холбогдолтой алдаа, зөрүүг ил тод болгосон нь авилга авагчдыг яллахад хүргэсэн бөгөөд зөрүүтэй байдлын түвшин 2006 онд 4 тэрбум төгрөг байснаас 2013 онд 36 сая төгрөг болтлоо тогтвортойгоор удаан хугацаанд буурсан байна.

Олон нийтэд хандсан арга хэмжээ, зөвлөгөөний явцад орон нутгийн засаг захиргаанд шууд орж буй төлбөр, тусгай зөвшөөрлийн хуваарилалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн нөхцөл зэрэгт олон нийт оролцох сонирхол илэрдэг. Олборлох үйлдвэртэй аймаг, сум бүр засгийн газрын 2012 оны тогтоолоор ОТОАХ байгуулах шаардлагатай болсон. ОТОАХ-дгээр нь орон нутгийн ОҮИТБС-ын дэд зөвлөл нь бүх сумдад хараахан байгуулагдаагүй, ихэнх тохиолдолд сумын орлогын ашиглалтын талаар гурван талт хэлэлцүүлэг хийх газрууд болж байна. ОҮИТБС-ийн зүгээс уул уурхайн салбарын удирдлагын талаар хэлэлцүүлэг, мэтгэлцээнд зориулан гурван талт платформоор хангаж өгсөн байна. Үүгээр лиценз эзэмшигчдийн болон уул уурхайн орлого хэрхэн зарцуулагдаж байгаа талаарх мэдээлэлд олон нийт илүү нээлттэй хандах боломжийг олгосон.

Орон нутгийн хэмжээндөндөр ач холбогдолтой асуудал нь Улаанбаатар хотод үндэсний хэмжээнд хүрч чадаагүй байна. Энэ нь Үндэсний зөвлөл дээрхдээд түвшний шийдвэр гаргагчдын гишүүдийг үл харгалзан, ОҮИТБС-ын хэлэлцүүлэг, бодлого боловсруулах хооронд цөөхөн хэдэн уялдаа холбоо байгааг харуулж байна. Үүний нэгэн адил, үйлдвэрлэлболон иргэний нийгэм нь шинэчлэлийг дэмжих нь дуу хоолойн үндэс болж чадах үндсэн мэдээллийн хэсгээс илүүтэйгээр тохируулгынхэсэгт илүү анхаарлаа хандуулж байна. Олборлох салбарын засаглал нь олон нийтийн дунд ихээхэн сонирхолтой сэдэв болох Монгол шиг улс оронд ОҮИТБС-ын хэрэгжилт нь ихээхэн ач холбогдолтой боловч, олборлох салбарын засаглалын асуудлын талаар нотолгоонд суурилсан хэлэлцүүлгийгдэмжих өөрийн бүрэн боломжийн хувьд дутмаг хэвээр байна.

Цаашид, Засгийн газар болон компанийн системд ОҮИТБС-ын тайлагналыг нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой.Монгол Улсын цахим тайлагнах системийн хоёр дахь үе шат нь ОҮИТБС болон Засгийн газрын гол хэлтсүүд (ялангуяа татвар, уул уурхайг хамарсан), ОТОАХболон оролцогч талууд, ялангуяа Засгийн газрын хооронд мэдээллийн системийг автоматжуулах зорилготой бөгөөд төрийн олборлох салбарын өгөгдлийн хэвийн боловсруулалтад чанар баталгаажуулахнайджартай журмаар хангахад анхаарлаа хандуулах ёстой. ОҮИТБС-ын мэдээллийн боловсруулалтыг тогтмол гаргахыг тайлангийн салшгүй хэсэг болгож, аудитын циклд ОҮИТБС-ын тодруулгын гэрчилгээг нэгтгэх зэргээр үйлдвэрлэлийн хамрах хүрээг мөн авч үзнэ.

Зөвлөмж

Дараах тайланд ОТОАХ-ээс хэрэгжүүлж болохуйц тодорхой шинэчлэлд зориулсан зөвлөмжүүдийг багтаасан бөгөөд доорх жагсаалтад ОҮИТБС-ын дэд бүтцийн шинэчлэлийг дэмжих хэрэгсэл болгон ашиглахад Монгол Улсад тустай байж болох стратегийн зөвлөмжүүдийг үзүүлсэн билээ.

- Ажлын түвшний нэгжийн төлөөлөгчдийн тоог бууруулах болон ажлын түвшний нэгжийн уулзалтын давтамжийг нэмэгдүүлэх, бүх хэлэлцүүлгийг мэдээлэх, системтэй арга зүйн дагуу бичиж тэмдэглэх, зэргийг харгалзан үзэж ОҮИТБС-ын засаглалын институцийн бүтэц болон бүрэлдэхүүнийг дахин эргэж харах (үүнд түр ажлын хэсэг мөн хамаарна).
- Гурван талт оролцогчдын бүлэг нь ОҮИТБС-ээс олборлох салбарын эргэн тойронд байгаа ямар асуудалд хэрхэн яаж хувь нэмрээ оруулж туслах талаар илэн далангүй бас нээлттэй хэлэлцүүлэгт оролцох ёстой. Энэ нь ОҮИТБС-ын хэрэгжилтийн зорилго болон эдгээр зорилгод хүрэхэд туслах үйл ажиллагааны шинэчлэл рүү хөтлөж болох юм.
- ОТОАХ нь цаашид төрийн системд олборлох салбарын ил тод байдлыг нэвтрүүлэхийг хөхүүлэн дэмжиж, мөн өдөр тутмын үндсэн дээр ОҮИТБС-ын мэдээллийг тогтмол боловсруулах арга хэмжээ авч байх нь зүйтэй. 2016 оны эцэс хүртэл хэрэгжүүлэх цахим тайлангийн төслийн хоёр дахь үе шатны хүрээнд ОТОАХ нь ОҮИТБС-ын стандартын дагуу нийтэд ил тод болгох шаардлагатай ямар мэдээлэл аль хэдийн олон нийтэд нээлттэй болсон мөн олон нийтэд танилцуулаагүй ямар мэдээлэл байгаа зэргийг олж тодорхойлох судалгааны ажил явуулах шаардлагатай байна. Үүнээс гадна ОҮИТБС-ын илүүх мэдээллийг нээлттэй өгөгдлийн форматаар хангах боломжийг судалж болох юм.
- ОТОАХ нь 2015 оны санхүүгийн жилийг хамруулсан дараагийн ОҮИТБС-ын Тайлан бэлтгэхдээ засгийн газар болон компаниудын аль алинаас нь ОҮИТБС-ын мэдээлэл задруулах чанарын баталгааны гэрчилгээний заалтад тохирохуйц шийдлийг олох ёстой. ОТОАХ нь Монгол Улсын Ерөнхий Аудитор, Хараат бус хянагч, салбарын ОТОАХ-ийн гишүүдтэй нэн ялангуяа чанарын баталгааны эрүүл, бат бөх тогтолцоог бий болгох ажлын хүрээнд хамтран ажиллах ёстой. ОТОАХ нь жилийн эхнээс эхлэн өөрийн дараагийн Хараат бус хянагчийг захиалах буюу олж авах талаар бодолцох хэрэгтэй бөгөөд энэ нь тэдэнд мэдээлэл цуглуулах хангалттай хугацааг олгох болно.
- ОТОАХ нь ОҮИТБС-ын Тайлангаас зөвлөмж боловсруулахад илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх мөн холбогдон гарах дараагийн ажил болон хэрэгжилтийг батлах эсэх талаар авч үзэх ёстой.
- ОТОАХ-ын яриа хэлэлцүүлгийг ОТОАХ болон ҮЗ гишүүн бус оролцогч талуудын хийж буй үндэсний түвшний яриа хэлэлцүүлэгтэй уялдуулах, тэдний тавьж буй гол шаардлагууд хоорондын харилцан хамаарлыг сайжруулах зорилгоор олон нийтэд танилцуулан сурталчлах ажиллагаа болон оролцогч талуудын зөвлөлдөх механизмыг албан ёсоор бий болгох хэрэгтэй.
- Монгол улсын олон нийтийн мэдээллийн хэрэглэгчдийн тархалтыг харгалзан ОТОАХ нь өөрийн явуулж буй мэтгэлцээнд хүн амыг олноор нь татан оролцуулах өөр бусад арга хэрэгслийг эргэж хайх ёстой. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан онлайн хэлбэрээр мэдээлэл дамжуулах нь ОҮИТБС-тай холбоотой яриа хэлэлцүүлэг дэх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх мөн ОҮИТБС-ын мэдээлэл дамжуулж түгээх хурдыг нэмэгдүүлж өгнө.

Оршил

Гарын үсэг зурах үе шатны талаарх товч мэдээлэл

2005 оны 10 - р сард төсөв, эдийн засгийн талаар хэлэлцэх Улсын Их Хурлын (Монгол Улсын Их Хурал) Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар Монгол Улсыг Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачлага (ОУИТБС)-д гарын үсэг зурахыг дэмжиж, Монгол Улсын Засгийн Газарт (ЗГ) тус санаачилгад нэгдэхийг даалгасан. МУЗГ-аас Монгол Улсыг ОУИТБС-тай гарын үсэг зурахыг 2006 оны 01 дүгээр сарын 04 өдрийн Кабинетын хурлаар баталсан бөгөөд МУЗГ-аас албан ёсоор ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн тогтоол гаргаж, институцийн гүйцэтгэх ажлын хүрээг зааж өгсөн байна. 1-р тогтоол (2006)-д ОУИТБС-д хяналт тавих нэгжээр ОУИТБС-ын Үндэсний Зөвлөлийг байгуулах нь зүйтэй хэмээн тогтоож түүний бүтэц бүрэлдэхүүнийг заасан. Ерөнхий сайд асан Санжаагийн Баяр нь ОУИТБС-ын талаар өөрийн хэлсэн үг, ярилцлагуудад олонтоо дурдсан байдаг бөгөөд 1-р тогтоолын талаар олон тооны сонинд мэдээлсэн байдаг.

Ерөнхий сайдын ажлын албанаас гаргасан 1-р Тогтоолын дагуу Иргэний нийгэм нь ОУИТБС-ын Үндэсний Зөвлөл дээр төлөөлөлтэй байх ёстой гэж заасан. Үндэсний зөвлөлийн Ажлын удирдамжид "Засгийн газар, олборлох салбар, иргэний нийгмийн тэгш төлөөлөлтэй" байх ёстой гэж заасан байдаг. Цаашилбал, Монгол Улсын Засгийн газар, олборлох үйлдвэрлэл эрхэлж буй компаниуд, иргэний нийгмийн хооронд байгуулсан Харилцан Ойлголцлын Санамж Бичигт (ХОСБ) тууштай хамтын ажиллагаа байгуулахад Засгийн газрын хүлээх үүрэг, нийтлэг 9 эрх үүрэг, мөн оролцогч тал (Засгийн газар, иргэний нийгэм, компаниуд) бүрийн хүлээх 4 үүргийг жагсаан тодорхойлжээ.

Үндэсний Зөвлөлийн Ажлын удирдамжид (заалт 4) Үндэсний Зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд байх ёстой гэж заасан. Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ноён Б.Эрдэнэсүрэн нь Үндэсний Зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогдсон. Санамж бичгийн 10 дугаар зүйлээр ОТОАХ болон ОУИТБС-ын хэрэгжилтийг дэмжин ажиллах үүрэгтэй хараат бус нарийн бичгийн даргыг тодорхойлсон бөгөөд 2007 онд Нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулсан. Хэмжиж болохуйц зорилго, үйл ажиллагаа хэрэгжүүлэх хуваарь бүхий өртөгтэй ажлын төлөвлөгөөг 2008 оны 1 –р сарын 30-ны Үндэсний Зөвлөлийн хуралд өргөн барьж батлуулсан байна. Ажлын төлөвлөгөөг яам, агентлаг, ТББ-ыг оролцуулаад зургаан байгууллагын вэб сайт дээр байрлуулсан байлаа.

Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ерөнхий явц ба хэрэгжүүлэх зорилго

2015 оны ажлын төлөвлөгөөний¹ зорилтууд нь 2014 оны ажлын төлөвлөгөөнд² байсан члан ОУИТБС-ын 7 Тавигдах шаардлагуудтай ижил байна. Тиймээс энхүү ажлын төлөвлөгөөний зорилт нь олборлох салбарын үндэсний тэргүүлэх чиглэлийг тусгаагүй юм шиг санагдаж болох ч үүнд ОУИТБС-ын тайлан болон ОУИТБС-ын хэрэгжилтийн талаарх хяналт-шинжилгээний тайлан гэх мэт бусад үнэлгээнүүдэд тодорхойлсон тодорхой чадавхын хязгаарлалтыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг тусгаж өгсөн болно. Энэ үйл ажиллагаанд хууль эрх зүйн орчин, олборлох үйлдвэрлэл дэх төрийн өмчлөл, орлого зарлага, зарцуулалт болон орон нутгийн шилжүүлэг, дэд бүтцийн хөгжил зэргийн мэдээллийн санг бий болгох ажилбагтана³. ОУИТБС-ын өмнөх тайлангийн

¹ОУИТБС-ын 2015 оны ажлын төлөвлөгөө,
<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>

²ОУИТБС-ын 2014 оны ажлын төлөвлөгөө,
http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/EITIM_POA_2014en.pdf

³ОУИТБС-ын 2015 оны ажлын төлөвлөгөө (хуудас 1),
<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>

зөвлөмжийг шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэхээс гадна 2015 оны ажлын төлөвлөгөөний 4-р хэсэгт үндэсний түвшний чадавхыг бэхжүүлэх болон сургалтын үйл ажиллагаануудад 5-р хэсэгт орон нутгийн чадавхыг бэхжүүлэх болон явуулах сургалтын үйл ажиллагааг онцгойлон тусгасан байна.⁴ 2015 оны ажлын төлөвлөгөөнд мөн ОУИТБС-ын тайлан боловсруулахтай холбоотой үйл ажиллагаа болон 2014 оны ОУИТБС-ын Тайлангийн урьдчилсан судалгааны судалгаа хийх болон ОУИТБС-ын стандартын дагуу шаардлагатай үндсэн мэдээллийн эх үүсвэрийг бий болгохтой холбоотой бүхий л үйл ажиллагааг тусгасан байна. 2015 оны ажлын төлөвлөгөөний 9-р хэсэгт ОУИТБС-ыг бүрэн тайлагнахад учрах хууль эрх зүйн саад бэрхшээлийг даван туулах зорилго бүхий Ашигт Малтмалын Салбарын Ил Тод Байдлын тухай хуулийн төслийг батлах талаар тусгасан.

2013, 2014 болон 2015 онуудын ажлын төлөвлөгөөнд үйл ажиллагаа тус бүрийн дуусах тодорхой цаг хугацааг заасан. 2013 онд Нарийн бичгийн дарга нарын газраас хийхээр төлөвлөсөн 42 үйл ажиллагааны 33-ыг (нийт 80%) нь хийж дуусгасан бөгөөд "ОУИТБС-ын тухай хууль"-ийн төслийг батлуулах мөн телевизийн цуврал гаргах гол ажлууд хийгдээгүй гэсэн тайланг гаргасан байна.⁵ 2014 онд "ОУИТБС-ын тухай хууль"-ийн төслийг батлуулах, бүс нутгийн бага хурал зохион байгуулах, телевизийн нэвтрүүлэг гаргах зэрэг гол ажлууд саатсанаас үүдэн төлөвлөсөн 65 үйл ажиллагааны 42 нь биелэгдсэн (нийт 65%) гэж Нарийн бичгийн дарга нарын газраас мэдээлсэн байна.⁶ 2015 оны 11-р сарын 06-ны өдрийн байдлаар 2015 оны ажлын төлөвлөгөөний дагуу хийхээр төлөвлөсөн 50 үйл ажиллагааны 35 нь биелэгдсэн байна. Хараахан биелэгдээгүй үйл ажиллагаануудад ОУИТБС-ын Стандартын дагуу Баталгаажуулалт, "ОУИТБС-ын тухай хууль" батлагдсаны дараа хийхээр төлөвлөсөн үйл ажиллагаа, 2016 оны 03 сард хийхээр төлөвлөөд байгаа Зүүн бүс дэх ОУИТБС-ын Нээлттэй Өдөрлөг, орон нутгийн түвшин дэх зөвлөлийн сургалт зэрэг орно. Орон нутгийн түвшинд иргэний нийгмийн байгууллагуудад хийхээр төлөвлөсөн сургалт нь цаг хугацааны давчуу байдал мөн өвлийн улиралд энэ үйл ажиллагааг зохион байгуулахад тулгарах бэрхшээл зэргээс болж 2015 онд биелэгдэх төлөвгүй байгаа ба 2016 оны гуравдугаар сар хүртэл хойшлогдох магадлалтай байна.⁷

ОУИТБС-ын Тайлагналын явц

Монгол Улс нь 2006 оноос 2013 он хүртэл нийт найман удаагийн ОУИТБС-ын тайланг боловсруулан гаргасан бөгөөд одоогоор 2014 оны санхүүгийн жилийг хамарсан 9-дэх тайлангаа дуусгахаар ажиллаж байна. 2006 оны ОУИТБС-ын тайланд ердөө уурхайн 35 компаниудын мэдээлэл орж байсан бол 2013 оны санхүүгийн жилд газрын тос, байгалийн хий, нүүрс, уул уурхайн 1198 компаниудын талаар тайланд тусгасан байна. 2008-2011 оны хооронд Монгол улс нь хоёр жилийн хоцрогдолтойгоор ОУИТБС-ын тайланг гаргасан (жишээ нь: 2009 оны ОУИТБС-ын тайланг 2011 онд) байна. Гэхдээ ОТОАХ нь 2012 онд 2010, 2011 онуудыг хамарсан ОУИТБС-ын хоёр тайланг боловсруулан гаргаж түүнээс хойш ОУИТБС-ын тайлан мөн нэг жилийн хугацааны хоцрогдолтойгоор гаргадаг болсон байна (2013 оны ОУИТБС-ын тайлан нь 2014 оны 12 сард нийтлэгдсэн). Хараат бус хянагч нарын нэрс болон зардлыг Хавсралт Е –д жагсаасан болно.

ОУИТБС-ын тайлангийн анхны дөрвөн маягтыг 2007 оны 04 сарын Сангийн сайд болон Үндэсний

⁴ОУИТБС-ын 2015 оны ажлын төлөвлөгөө (хуудас 2-3),

<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActionPlan2015en.pdf>

⁵ОУИТБС-ын 2013-2014 оны жилийн үйл ажиллагааны тайланд мэдээллэсэн, 2014 оны 7-р сар (хуудас 15)

https://eiti.org/files/document/Mongolia_EITI_Activitie_report_2013_half_2014_half_last.pdf

⁶ОУИТБС-ын 2014 оны ажлын тайлан, 2015 оны 1-р сар (хуудас 13)

<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMWorkReport2014en.pdf>

⁷ОУИТБС-ын ажлын албаны тооцооллын дагуу.

Статистикийн хорооны дарга нарын хамтарсан тушаалаар баталж, 2008 оны 03 сард дахин хянаж, 2011 оны 01 сар мөн дахин 2014 оны 01 сард долоон маягт болгон нэмэгдүүлж, зохих нэмэлт, өөрчлөлтүүдийг хийн шинэчилсэн байна. Эдгээр өөрчлөлт шинэчлэлүүд нь Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн бүх бараа материалын төлбөр болон орлогын асуудлыг хамарсан бөгөөд тайлагнах ажлын явцыг сайжруулж өгсөн байна.

Засгийн газар, иргэний нийгэм ба аж үйлдвэрийн салбарын оролцооны тухай хураангуй

Одоогийн ОТОАХ болон Үндэсний Зөвлөл нь анх 2006 оны 05 –р сард батлагдаж, тогтмол шинэчлэгдсээр ирсэн Ажлын Удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг болно (хамгийн сүүлд 2012 оны 11-р сарын 28-ны өдөр шинэчлэгдсэн⁸).

ОТОАХ-ийн гишүүд нь жилд хоёроос гурван удаа уулздаг, харин Үндэсний Зөвлөлийн гишүүд жилд нэг удаа уулздаг. Эдгээр уулзалт хурлын протокол нь Монгол Улсын ОУИТБС-ын (ОУИТБС) цахим хуудсанд нийтлэгдсэн болно. ОТОАХ-ын хэд хэдэн түр хороодоос бүрдэх ба тэдэнд Ажлын удирдамж байдаггүйгээс гадна уулзалт хурлын протоколыг хөтөлдөггүй байна. ОТОАХ болон Үндэсний зөвлөлийн гишүүдийн жагсаалтыг Хавсралт А⁹-д оруулсан болно.

Монгол Улс дахь ОУИТБС-ын анхны үе шатуудад оролцооны түвшин нэлээд өндөр байдаг байсан. Сүүлийн үед, ялангуяа 2012 оноос хойш ОТОАХ болон Үндэсний Зөвлөлийн томилсон гишүүд тогтвортой бус болсоор байна. Нэн ялангуяа, иргэний нийгэм болон засгийн газар нь хуралд түр орлогчийг томилон оролцуулах хандлагатай болсон байгаа нь харагдаж байна. Үндэсний Зөвлөлийн чуулганы уулзалтыг тогтмол явуулахад байнгын улс төрийн өөрчлөлт нөлөөлж байна: 2011 оноос хойш Үндэсний зөвлөлийн хуралд удаа дараагийн Ерөнхий сайд болон Сангийн сайдууд оролцоогүй байна. ОТОАХ-н даргын суудал хэдэн сарын турш эзэнгүй байсны улмаас 2014 онд Үндэсний зөвлөл хуралдаж чадаагүй байна (2015 онд 2 удаа уулзалт хийсэн). Гэсэн хэдий ч олборлох асуудал дээр ажиллаж байгаа Засгийн газрын гол агентлагууд, (ихэвчлэн том) компаниуд, иргэний нийгмийн бүлгүүд нь ОУИТБС –ын ажилд ямар нэгэн байдлаар оролцож байна.

Олборлох Үйлдвэрлэлийн гол онцлогууд

Монгол улс нь дэлхийн хоёр дахь том зэсийн нөөц болон дөрөв дэх том нүүрсний орд газруудыг багтаасан дэлхийд эерх ашиглагдаагүй байгаа хамгийн том нөөцүүдэд эзэн сууж байгаа улс бөгөөд Монгол Улс нь алт, төмрийн хүдэр, цайр, уран, хайлуур жонш, газрын тосны асар их нөөцийг эзэмшдэг байна. Дэлхийн Банкны мэдээгээр Монгол Улс нь Аляскийн дайны хэмжээний ойролцоогоор 80 гаруй ашигт малтмалын 6000 гаруй ордтой хэдий ч ердөө 400 гаруй орд газарт хайгуул явуулж байгаа бөгөөд үүний 160 нь л үйлдвэрлэл явуулж байна. Уул уурхайн салбар нь улс орныхоо эдийн засгийг бүрдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг ба энэ нь 2013 онд ДНБ-ний 18.5%, төсвийн орлогын 17.5%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 58.7%, экспортын орлогын 90% -ийг бүрдүүлсэн байна.¹⁰ 2013 оны экспортын 88% -ийг ашигт малтмал болон түүхий газрын тос бүрдүүлсэн байна. Гол экспортын бүтээгдэхүүнд зэс, алт, молибден, нүүрс, төмрийн хүдэр, хайлуур жоншны баяжмал зэрэг орно.

2009 оноос эхлэн Хятад улс руу гаргах коксжих нүүрсний экспорт хурдацтай нэмэгдэхүд Монгол

⁸Үндэсний зөвлөлийн АУ нь МОУИТБС-ын вэбсайтад боломжтой

(http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/EITI_National_Council_TOR_in_English.pdf)

⁹Мөн тэдгээр нь МОУИТБС-ын вэбсайтад боломжтой

(<http://www.eitimongolia.mn/en/national-council> болон <http://www.eitimongolia.mn/en/working-group>).

¹⁰МОУИТБС –ын 2013 оны тайлан.

Улсын түүхий эдийн үнэ хэт өндөр хөөрөлтэй болсон байна. Орос-Монголын Хамтарсан Эрдэнэт үйлдвэрийг 1974 онд нээснээс хойш зэс нь Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүнбайсаар ирсэн бөгөөд 2006 оныг хүртэл ДНБ-ний бараг 40% -ийг бүрдүүлсээр иржээ.

Багануур болон Шивээ-Овоон төрийн- хагас- өмчит уурхайнуудын олборлосон түлшний нүүрсний гаралт нь дөрвөн томоохон дулааны цахилгаан станцуудын хэрэгцээг хангаж, 100,000 гаруй албан бус "нинжа" уурхайчид бага орлоготой гэр хорооллын оршин суугчдыг нүүрсээр ханган нийлүүлж байгаа бөгөөд 2000 оны дунд үеэс эхлэн Монголын Алт (МАК) болон Эм-Си-Эсгэх мэт Монголын уул уурхайн компаниуд боловсруулаагүй түүхий коксжих нүүрсийг Хятад руу экспортолж эхэлсэн бөгөөд улмаар 2009 оноос эхлэнтөмрийн хүдэр экспортолж эхэлжээ.

Бордоогийн уурхайн хөрс хуулалтыг зогсоож, эрдэс бодис тунгааж авахыг хориглосон хуулийн заалтаас үүдэнэлтны үйлдвэрлэл 2009-2011 оны хооронд 5703 кг болж хоёр дахин буурсан болгол төлөв нөөц нь дуусч буй Эрдэнэт уурхайгаас олборлон гаргажбуй зэсийн экспорт нь олборлолтоороо хоёрдугаар байр лууухран орж, 2012 онд аажмаар буурсаар 517,000 тонн болсон байна.

2008-2011 он хүртэл нүүрсний үйлдвэрлэл гурав дахин өссөн бөгөөд ихэнхийг нь Хятад улс руу экспортолсон байна. Энэ нь 2009 оноос Рио Тинтогийн дэмжлэгтэй Оюу Толгойн зэс алтны уурхайн 6.2 тэрбум ам.долларын олборлолттой хослуулснаар 2011 онд 17.3% мөн 2012 онд 12.3% болж дэлхийн эдийн засгийн өсөлтийг тэргүүлэхэд хүрсэн байна. 2012 оны 05 сарын Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалтын (ГШХО) эсрэг гэж тооцогдох шинэ хуулиуд нь түүхий эдийн үнийн уналттай давхцаж, Хятадын эрэлт удааширч, ГШХО унаж, өсөлтийг удаашруулсан байна.

Үүний зэрэгцээ Төрийн өмчит Эрдэнэс Таван Толгой (ЭТТ)-гоос тодорхойлсончлон 7.42 тэрбум тонн нүүрсний болон 1.4 тэрбум тонны коксжих нүүрсний асар их нөөц бүхий дэлхий дээрх олборлогдоогүй үлдсэн цөөхөн ордуудын нэг болох Таван Толгойн ордын нүүрсний ашиглалтын бодлогын талаар Монгол улсын засгийн газраас янз бүрийн тодорхойгүй мэдээлэл гаргаж эхэлсэн байна. 2011-2012 онд БНХАУ-руу коксжих нүүрсний экспортын оргил үед Засгийн газар нь хөрөнгө оруулагчдын байр суурийг ганхуулан тэднийг буцахад нөлөөлөх бодлого гаргасан байна. Энэ нь 2011 оны сүүлээр Япон, БНСУ-ын өгсөн шүүмжлэлийг үл харгалзан АНУ-ын Пибоди, Шинхуа, ОХУ-ын төмөр замын консорциумааршалгарсан Таван Толгойн Баруун Цанхийн хэсгийг ашиглах концессын гэрээгцуцалсан байна. Энэ нь төрийн өмчит ЭТТ-г гэрээт уурхайчдыг ашиглан Зүүн болон Баруун Цанхийн ихэнх хэсэг дээр ажиллах цорын ганц оператор компани болгож орхисон байна.

Оюу Толгой нь Эрдэнэтийн уламжлалт ноёрхолыг давж гарахын хэрээр дэд бүтцээр хязгаарлагддаг байсан зэсийн экспорт жилд ойролцоогоор 30% өсөн нэмэгдэж байна. Хайгуулын үйл ажиллагаа зэсийн лиценз дээр хамгийн идэвхтэй явагдаж байна. Үнийн уналтын хажуугаар төмрийн хүдэр гэх мэт металлургийн ашигт малтмалын Хятад руу гаргах экспорт өссөн байна. Засгийн газраастөрөөс зарцуулалт хийх замаар өсөлтийг тогтвортой барьж байгаа хэдий ч 2015 онд хийгдсэнтөсвийн хязгаарлалтууд болон төлөвлөсөн өсөлт зөвхөн 4%-тай байгаа зэргээс үүдэн Монголын эдийн засагт хүндрэл тулгарсаар байна.

2014 оны 01 сарын Уул уурхайн талаар төрөөс баримтлах бодлогыг баталснаар 2014 оны 6-7 саруудад Ашигт малтмалын тухай болон Газрын тосны тухай хуульд тодорхой өөрчлөлтүүдийг оруулав. Эдгээр зохицуулалтууднь лиценз олгох, уул уурхайн байгаль орчны асуудал зэрэгт түлхүү анхаарсан байна.2006 оны Ашигт малтмалын хуульд оруулсан 2014 оны 01 сарын нэмэлт өөрчлөлтөөр алтны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас алтанд 5% ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр мөн Монгол Банкнд (МБ) тушаасаналтны суурь 2.5% -ын рояалти үнэ дээр нь үнээс хамааран 0%-5%-ийн нэмэгдэл татвар ноогдуулахаар тогтсон. Монгол Улсын Засгийн газар

нь шинэчилсэн уул уурхай болон газрын тосны хуулиудыг хэрэгжүүлэх зэргээр олборлолттой холбоотой хэд хэдэн хууль тогтоомжийг шинэчлэх болон дахин нарийвчлан хянаж боловсруулах шатандаа явж байна.

Баталгаажуулах явцтай холбоотой тайлбар (зорилго, хугацаа, ажлын удирдамж гм.)

Баталгаажуулалт нь ОҮИТБС-ын нэгэн чухал элемент бөгөөд энэ нь санаачилгын статусын гол цөм болсон олон улсын стандарт юм. Үүний зорилго нь ОҮИТБС-ыг хэрэгжилтэд гарсан ахиц дэвшилд бие даасан үнэлгээ хийлгэн тухайн үйл явцыг үр дүнтэйгээр сайжруулахад ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг тогтоодог. Баталгаажуулалтын тайланд баталгаажигч буйулсад ОҮИТБС хэрхэн нөлөөлж байгаа, ОҮИТБС-ын стандартын дагуу хийгдэж буй үйл ажиллагааны хэрэгжилт, ОҮИТБС-ын хэрэгжүүлэх явцад сурсан сургамж, түүнчлэн цаашид ОҮИТБС-ын хэрэгжилтийн явцад оролцогч талуудаас гаргаж илэрхийлсэн аливаа асуудал, зөвлөмжийн талаар тайлагнадаг. Нэр дэвшигч улс орнуудын хувьд, баталгаажуулалт нь ОҮИТБС хэрэгжилтийн ахиц дэвшлийг хэмжиж тогтоож өгдөг. ОҮИТБС-ыг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлсэн улс орнуудын хувьд (Хэрэгжүүлэгч орнууд) баталгаажуулалт нь бүх ОҮИТБС-ын Шалгууруудыг хэрхэн биелүүлж байгаа талаарх бодит үнэлгээ болно.

2015 оны 10-р сарын 22-нд ОҮИТБС-ын Удирдах зөвлөл нь доорх зүйлийг баталсан болно:

1. 2015 оны хуваарьт таван баталгаажуулалтыг нэн даруй (Соломоны Арлууд, Гана, Монгол, СаоТоме ба Зүүн Тимор зэрэг улсад) туршилтаар хийх хэрэгтэй. Туршилтын үр дүн нь эдгээр орны статуст ямар ч нөлөө үзүүлэхгүй бөгөөд, харин ч баталгаажуулах арга зүйн талаар явагдаж байгаа хэлэлцүүлэгийг мэдээлэх үүрэгтэй байна. Баталгаажуулагчийн одоогийн ажлын удирдамжийн дагуу мэдээлэл цуглуулах болон оролцогч талуудын уулзалт хэлэлцүүлгийг хийх ажлыг нарийн бичгийн дарга нарын газар хариуцах бөгөөд хянуулахаар хэрэглэн хүлээн авч баталгаажуулах хороогоор дамжуулан Зөвлөлд тайлагнах үүрэгтэй хөндлөнгийн гуравдагч этгээдээр (Баталгаажуулагч) хянуулна.
2. 2016 оны 01 сарын 01-нд арван нэгэн баталгаажуулалтын ажлыг эхлүүлнэ (дээрх таван улс орнууд дээр + Киргизстан, Либериа, Нигер, Нигери, Норвеги, Тажикистан). 2015 оны 10-р сарын 27 –ноос 11-р сарын 17-ныг хүртэл баримт бичгийн суурь шалгалтыг хийсэн ба 2015 оны 11 сарын 3–наас 11-ний хооронд тус улсад айлчилж очсон. Айлчлалын үеэр 11 сарын 3–4-ны хооронд болсон ОҮИТБС-ын Монгол Улсын Үндэсний форумтай, мөн жил бүрийн 11 сарын 4-ний өдөр зохиогддог Евразийн бүс нутгийн Төлсөн Авснаа Нийтэл хурал, 11-р сарын 10-11-нд Монгол-Германы G7 Үр Дүнд Хурдан Хүрэх Түншлэлийн бага хуралтай давхацсан.

"Хэвийн" баталгаажуулалтын хяналт нь ихэвчлэн 15 долоо хоногийн туршид үргэлжилдэг. Хэрвээ бидний мэдэлд илүү их цаг байсан бол, бид илүү олон оролцогчдод зөвлөгөө өгч ярилцах мөн гол асуудалд илүү гүн гүнзгий дүн шинжилгээ өгч чадах байлаа. 2013 оноос 2015 он хүртэлх хугацаанд хийгдсэн хурал уулзалтуудын протоколыг орчуулахтай холбоотойгоор зарим баримт бичгийг хянахад саатал гарсан хэдий ч эдгээр сорилтуудыг айлчлалын үеэр орчуулагчийн тусламжтайгаар даван туулж чадсан.

I Хэсэг – Олон Талт Оролцогч Талуудын Хяналт

1. Тойм

Энэ хэсгээр ОУИТБС-ын үйл ажиллагааны явцад оролцогч талуудын оролцоо, улс орны ОУИТБС-ын хэрэгжилтийн орчин, ОТОБ-ийн үйл ажиллагаа, засаглал (ОТОБ), ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө зэрэгт тавих Засгийн Газрын хяналтын талаар авч үзнэ.

2. Үнэлгээ

2.1 ОУИТБС үйл ажиллагаанд тавих төрийн хяналт

Явцын баримтжуулалт

Монгол улс нь 2007 оны 09 сарын 27-нд Осло хотодболсон ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гурав дахь хурлаар ОУИТБС-ын Нэр Дэвшигч эхний 15 орны нэгээр батлагдсан. Монгол улсын Засгийн газар нь 2006 оны 01 сарын 3-ны өдрийн Засгийн Газрын 1-р тогтоолын дагуу ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээ албан ёсоор нийтэд зарласнаас хойш ОУИТБС-ыг дэмжин ажиллаж байна. Засгийн газар нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээ олон нийтэд хэд хэдэн удаа илэрхийлсэн бөгөөд хамгийн сүүлд гэхэд 2015 оны 11 сарын 03-ны өдөр болсон ОУИТБС-ын Үндэсний чуулган дээр Уул уурхайн сайд хэлсэн үгэндээ "ОУИТБС нь салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг татахад гол үүрэг гүйцэтгэх тул Монгол улс ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна" гэсэн юм¹¹. Монгол Улсын Ерөнхий сайд, ноён Чимэдийн Сайханбилэг, Үндэсний форумын товхимолд бичиж үлдээхдээ : "Монгол Улс ОУИТБС-ын үнэ цэнэ, үр ашгийг хүлээн зөвшөөрч, засгийн газрын эрх зүйн бүрэн мандат бүхий хуулийн төслийг боловсруулж үүнийгээ Улсын Их Хуралд өргөн барьсан" гэжээ.¹²

Монгол улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд хамтран ажиллах гарын авлагаар хангах Гурван талт хамтын ажиллагааны Санамж Бичигт 2006 оны 04 сарын 25-нд гарын үсэг зурсан.¹³ 2006 онд тухайн үед Монгол Улсын Ерөнхий сайд байсан Миеэгомбын Энхболдыг ОУИТБС-ын хэрэгжилтийг ерөнхийд нь удирдаж тэргүүлэх ОУИТБС-ын Үндэсний Зөвлөлийн даргаар томилсон юм. Тэр үед Ерөнхий Сайдын Ахлах зөвлөхөөр ажиллаж байсан Д. Батбаярыг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга болон Олон Талт Оролцогчдын Ажлын Хэсгийн (ОТОАХ) дарга, мөн Сангийн болон Уул уурхайн Сайд нарыг Үндэсний зөвлөлийн хоёр орлогч даргаар тус тус нэрлэв.

ОУИТБС-ын засаглалыг хариуцсан дээд түвшний удирдах бүлэг буюу Үндэсний зөвлөл, ОУИТБС-ын стандартын хэрэгжилтийн асуудал эрхэлсэн, шийдвэр гаргах эрхтэй дээд хэмжээний зохицуулах байгууллага буюу ОТОАХ-г төрийн өндөр албан тушаалтнууд төлөөлж байна. Үндэсний зөвлөлийн засгийн газрын гишүүдэд Ерөнхий сайд, Уул уурхайн сайд, Сангийн сайд, Аялал жуулчлал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайд, УИХ-ын Улсын төсвийн байнгын хороо, Монгол Улсын ерөнхий аудитор, Үндэсний статистикийн хорооны дарга, Авилгатай тэмцэх газрын дарга, Төв аймгийн Засаг дарга нар байна.¹⁴ ОТОАХ-н засгийн газрын гишүүнээр Монгол улсын Ерөнхий

¹¹ ОУИТБС-ын Үндэсний Форумын 2015 оны 11-р сарын 3-ны хурлын тэмдэглэлийг МОУИТБС-ын Монгол вэб хуудсанд 2015 оны 12-р сарын үед нийтлэх болно.

¹² ОУИТБС –ын 2015 оны 11-р сарын 3-ны Үндэсний Форумын товхимолыг харна уу

¹³ Санамж бичгийг МОУИТБС-ын вэбсайтаас харах боломжтой

(http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/MoU_Mongolia_EITI.pdf).

¹⁴ Үндэсний зөвлөлийн гишүүд болон тэдгээрийн холбоо барих мэдээллийн бүрэн жагсаалтыг Хавсралт А-с харна уу.

сайдын ахлах зөвлөх, Татвар болон Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын дарга нар, Ашигт Малтмалын Газрын дарга, Монгол улсын Газрын Тосны газрын дарга, Монгол улсын Авилгатай Тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, Сангийн яамны Стратегийн бодлого, Уул уурхайн яамны төлөвлөлтийн хэлтсийн дарга, Аялал жуулчлал, Байгаль орчин, Ногоон Хөгжлийн яамны байгалийн нөөцийн газрын дарга, Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч нарыг оруулав.¹⁵

Оролцогчдын санал

Хэд хэдэн засгийн газрын төлөөлөгчид засгийн газрын ОҮИТБС-ыг хэрэгжүүлэлтийн хүрээнд ОҮИТБС-ын стандартын дагуу шаардагдсан мэдээлэл нь үндэсний аюулгүй байдлын зорилгоор хаалттай байсан ч, үүнийг ИНБ-уудын шаардлагын дагуу ил тод болгосон нь "зоригтой" алхам байсан гэж тэмдэглэсэн байна. Хэдийгээр Засгийн газар ОҮИТБС-ыг дэмжих талаар хэд хэдэн удаа олон нийтэд мэдээлэл хийсэн боловч, үйлдвэрлэлийн салбарын зарим төлөөлөл ОҮИТБС-ыг "төсөл" хэмээн эндүүрэн засгийн газрын хэрэгжүүлэлтийн түвшингийн талаар асууж байсан. Хэд хэдэн хандивлагчид Уул уурхайн яам зэрэг засгийн газрын төлөөлөлтэй харилцаж байхад тэд ОҮИТБС-н талаар хэзээ ч дурдаж байгаагүй тухай тэмдэглэсэн. Хэдийгээр ИНБ-ууд нь үйл явцыг нухацтай чин сэтгэлээсээ авч үзэж байсан ч, харин Монголын эрх баригчид нь үйл явцыг хийх ёстой зүйл мэтээр харсан ойлголттой байсан.

Үнэлгээ

Бид энэ шаардлага хангасан байх ёстой гэж үздэг.

2.2 ОҮИТБС-ын үйл ажиллагаанд оролцогчдын оролцоо, орин

Явцыг баримтжуулах

Засгийн газрын оролцоо: Засгийн газар нь төрийн тогтолцоонд ОҮИТБС-ын баримталсан ил тод байдлыг суулгаж өгөх урт замыг туулсан юм. 2007 оны 03 сарын 28-ны өдрийн Засгийн газрын 80-р тогтоолоор ОҮИТБС-ын хэрэгжилтэд төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхой болгож өгсөн. Энэхүү тогтоолыг 2011 оны нэмэлтээр ОҮИТБС-ын Дүрмийн дагуу болон төрийн байгууллагын "чиг үүрэг болон даалгавар"-ыг тодорхой заасан 2012 оны 07 сарын 04-ны өдрийн Засгийн газрын 222 дугаар тогтоолоор шинэчилсэн болно. Гол хууль, эрх зүйн шинэчлэл нь 2011 оны 06 сарын 16-нд батлагдсан мэдээлэлийн ил тод байдал болон мэдээлэл олж авах Эрх Чөлөөний тухай хууль¹⁶, 2014 оны 07 сарын 1-ны Шилэн дансны тухай хууль¹⁷, 2015 оны 08 сарын 7-ны Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих хууль¹⁸ зэрэг хуулиуд орно.

Зарим нэг засгийн газрын агентлагууд нь ОҮИТБС-ын стандартын дагуу шаардлагатай мэдээллийг тогтмол ил тод болгож байна. Жишээ нь: Сангийн яамны Төсвийн газар нь улирал тутам нийт аж ахуйн нэгжийн болон ашигт малтмалын нөөц ашигласны орлогын албан татварын талаар мэдээлэл

¹⁵ Ажлын хэсгийн гишүүд болон тэдгээрийн холбоо барих мэдээллийн бүрэн жагсаалтыг хавсралт А-с харна уу.

¹⁶ <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/un-dpadm/unpan047231.pdf>

¹⁷ http://www.iaac.mn/pdf/law_en/8_on_glass_accounts.pdf

¹⁸ Хуулийн хураангуйг

<http://www.ashidadvocates.mn/files/publications/transparency%20law%20implementation%20rules.pdf> болон [http://www.ey.com/Publication/vwLUAssets/EY-mongolia-tax-amnesty-law-alert-2015003/\\$FILE/EY-mongolia-tax-amnesty-law-alert-2015003.pdf](http://www.ey.com/Publication/vwLUAssets/EY-mongolia-tax-amnesty-law-alert-2015003/$FILE/EY-mongolia-tax-amnesty-law-alert-2015003.pdf) -с харна уу.

гаргадаг бие даасан вэбсайтыг¹⁹ ажиллуулж байна.

Сангийн яам нь цахим тайлангийн вэб хуудас²⁰, түүнчлэн өөрийн вэб сайт дээр ил тод байдлын хэсгийг²¹ оруулсан байдаг. 2013 оны 2-р улирлаас эхлэн АМГ нь түүхий эд, экспорт, төсвийн орлого нэг бүрийн нийт үйлдвэрлэлийн талаар сар бүр тайлагнадаг болсноос гадна, 2014 оны эхнээс эхлэн тэд долоо хоног тутмын үндсэн дээр мэдээлэл гаргадаг болсон. Энэ мэдээлэл нь вэб сайтад гараагүй ч, Уул уурхайн яамнаас тогтмол гаргадаг хэвлэлийн хураангуйд танилцуулагдсан байна. Гэсэн хэдий ч Татварын Ерөнхий газар ОҮИТБС-ын тодруулгын дийлэнх нь ОҮИТБС-аас өмнө нийтлэгддэггүй гэдгийг тэмдэглэжээ.

2007-2010 он хүртэл Монгол улсад хэрэгжүүлэх ажлын санхүүжилтийг бүхэлд нь Дэлхийн Банкны Олон Хандивлагчдын Итгэлцлийн Сангийн (ОХИС) буцалтгүй тусламжаар 2006-2009 оны Төсвийн жилийг хамруулан санхүүжүүлсэн болно. 2010 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газар нь харьцангуй тогтмол хэмжээний санхүүжилтийг ОҮИТБС-ын Тайланд хуваарилсан: 2012 онд 201.1 сая төгрөг, 2013 онд 183 сая төгрөг, 2014 онд 220.1 сая төгрөг, 260 сая төгрөг. 2015 оны 11 сард 2015 оны төсвийн нэмэлт өөрчлөлтөнд заасан орлогын хязгаарлагдмал байдлын улмаас бодит байдалд хараат бус хянагчид хуваарилсан 169 сая төгрөгийг 2015 онд олгосон юм. ОХИС-ын санхүүжилтийг саяхны 2015 оны 2-р сард олгосон 280,000 ам.долларын буцалтгүй тусламжийн хамтаар нэгтгэлийн бус үйл ажиллагааны зардлуудыг нөхөхөд ашигласан ба 2015 оны 12 сар гэхэд зарцуулсан байх, эсвэл буцааж өгөх шаардлагатай²². 2015 оны 11 сарын 06-ны байдлаар, 153.000 ам.долларыг зарцуулсан байсан.²³ ОҮИТБС-ын Олон улсын Ажлын Алба Австралийн Засгийн газрын нэрийн өмнөөс 2014 оны 08 сард 46.450 ам.долларын эргэлтийн буцалтгүй тусламж олгосон байна. Энэ нь цагаа олсон тусламж байсан. Учир нь 2014 оны 2 сар гэхэд ОХИС-с олгосон 250,000 ам.долларын тусламжийг хэрэглэсэн байсан.

Нэгтгэлийн үе шатанд компани, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ихэнхи нь нэгтгэлд зориулсан тайлангийн мэдээлэл гаргаж өгсөн ч, зарим төвийн болоод орон нутгийн төрийн байгууллагууд мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөөгүй эсвэл бүр 2013 оны ОҮИТБС-ын тайланд мэдээллээр хангахаас татгалзсан байна. Жишээ нь: Гаалын Ерөнхий газар (нэгтгэлд мэдээлэл авах хүсэлтэд хариу удаан өгсөн), Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс;

- Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс;
- Баянгол дүүргийн татварын хэлтэс;
- Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс;
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс;
- Сонгинохайрхан дүүргийн өмч, газрын харилцааны хэлтэс;

Ялангуяа уул уурхайн яам болон АМГ нь хүрч ажиллах болон таниулах үйл ажиллагаа эрхэлдэг гол төрийн аж ахуйн нэгжийн хувьд төв болон орон нутгийн түвшинд зохион байгуулагддаг ОҮИТБС-ын нээлттэй өдрийн үйл ажиллагаанд тогтмол оролцдог.

¹⁹ <http://www.iltod.gov.mn/>, зөвхөн Монгол хэлээр байгаа.

²⁰ <http://119.40.100.204/EReport/>, зөвхөн Монгол хэлээр байгаа.

²¹ <https://www.mof.gov.mn/%D1%88%D0%B8%D0%BB%D1%8D%D0%BD-%D0%B4%D0%B0%D0%BD%D1%81%D1%88%D0%B8%D0%BD%D1%8D/?lang=en>

²² 2014 үйл ажиллагааны жилийн тайлан

²³ ОҮИТБС-ын ажлын албаны дагуу.

Компанийн оролцоо:

Борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн татварт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээний талаар тайланг санхүүгийн жилийн эцсийн нэг улиралд багтаан Засгийн газарт мэдээлэхийг компаниудаас шаардаж, ОҮИТБС-ын тайланг баталгаажуулах хэд хэдэн хууль эрх зүйн заалтуудыг баталсан болно. Эдгээрт:

- 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн²⁴ 48.10 заалтын дагуу олборлох үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь жил бүр улсын болон орон нутгийн засаг захиргаанд төлсөн өөрсдийн бүтээгдэхүүний борлуулалт, татвар, төлбөрийн хэмжээг дараа жилийн эхний улиралд багтаан олон нийтэд мэдээлэх шаардлагатай.
- 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн²⁵ 48.9 заалтын дагуу лиценз эзэмшигч нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай тайланг татварын албанд улирал дууссанаас хойш дараа сарын 20-ны дотор өргөн барих шаардлагатай.
- 2009 оны Цөмийн энергийн тухай хуулийн²⁶ 28.6.4 дугаар заалтын дагуу ураны лиценз эзэмшигч нь жил бүр улсад болон орон нутгийн төсөвт төлсөн төлбөр, борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ, татварыг олон нийтэд ил тод болгох шаардлагатай.
- 2014 оны Газрын тосны тухай хуулийн²⁷ 36.1 заалтын дагуу Гэрээлэгчээс хөрөнгө оруулалтын хэмжээ, гарсан зардал, төлсөн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, олборлосон болон борлуулсан тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, холбогдох төрийн байгууллагууд болон Газрын Тосны Хэрэг эрхлэх газарт төлсөн төлбөр, шагнал, үйлчилгээний ажлын хэмжээний талаарх мэдээллийг дараагийн жилийн эхний улирлын байдлаар гаргаж өгөх шаардлагатай. Гэрээлэгч нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан энэ мэдээллийг олон нийтэд мэдэгдэх шаардлагатай болно.
- Ашигт малтмалын тухай хуулийн дахин шинэчлэлтийн (2014 оны 07 сард батлагдсан) 66.1.2 дугаар зүйлд Уул уурхайн ашиглалтын хуулийн 48.1-48.10 зүйлийн дагуу тайлан мэдээлэл өгөөгүй бол компаниудад хариуцлага тооцохоор заасан. Торгуулийн хэмжээ нь хувь хүний жилийн хамгийн доод цалинг 20 дахин болон компаниудын хувьд 30-50 дахин их байна.
- 2014 оны 01 сард батлагдсан 2014-2025²⁸ он хүртэлх ашигт малтмалын салбарын төрийн бодлого нь ил тод, хариуцлагатай уул уурхайг дэмжиж байна.
- 2013 оны 10 сарын 3-нд гаргасан Хөрөнгө оруулалтын тухай хуулиар²⁹ Монгол Улсын Хөрөнгө Оруулалтын Байгууллагад компаниуд өөрсдийн бүртгэл хөтлөлтөө нийтэд нээлттэй болгох шаардлагатай.

Засгийн газар нь тусгай зөвшөөрөл олгох, гэрээ, худалдан авалт гэх мэт олборлох салбарын удирдлагын бусад үйл явцтай холбоотой заалтуудын ил тод байдлыг хангах үүднээс, мөн ОҮИТБС-

²⁴ http://www.charltonsmine.com/images/stories/Overseas_Law/Mongolia/minerallawsofmongolia.pdf

²⁵ http://www.charltonsmine.com/images/stories/Overseas_Law/Mongolia/minerallawsofmongolia.pdf

²⁶ <http://legal-policy.mn/uploads/files/1437032892-85658440.pdf>

²⁷ <http://english.pam.gov.mn/content/11370.shtml>

²⁸ <http://en.mongolianminingjournal.com/content/54797.shtml>

²⁹ <http://www.mram.gov.mn/pdac/law/en/2.pdf>

ын хууль эрх зүйн орчинг сайжруулахын тулд ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж эхэлсэн. Хуулийн төслийг 2014 оны 05 сард Хууль зүйн Яам баталж, 2014 оны 10 сард УИХ-д өргөн барьсан боловч, 2015 оны 11 сарын байдлаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулийн төслийг баталаагүй байна (*нөлөөллийн хэсгээс доор харна уу*).

Монголын уул уурхай, газрын тос, байгалийн хийн лицензийг эзэмшдэг компаниудын дийлэнх нь ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлд оролцож байгаа нь тэдний оролцооны нотолгоо мөн болно. 2013 оны ОУИТБС-ын тайлан нэгтгэлийн ажлын хүрээнд зөвхөн 250 компани багтсан байсан боловч 2013 онд лиценз эзэмшиж байгаа 1617 компанийн 1151 нь өөрсдийн материаллаг төлбөрийн талаар Засгийн газарт мэдээллэсэн байна. 2013 оны Тайлан Нэгтгэлийн ажлын хүрээнд хамрагдсан бүх компаниудын нэг нь ч өөрсдийн тайлангийн маягтуудыг гаргаж өгөөгүй.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын (2014) 66.1.2 зүйлээр Ашигт малтмалын тухай хуулийн 48.1-48.10 зүйлийн дагуу тайлан мэдээлэл өгөөгүй компаниудад арга хэмжээ авахаар заасан. Гэсэн хэдий ч компани нь “энэ хуулийн 48.1-48.10 заалтыг дагаж мөрдөөгүйгээс зөвхөн нэг удаа торгуулна” гэж заасан нь компаниудад өөр шалтгааны улмаас торгуулсан тул ОУИТБС-ын тайлангийн дагуу тайлагнаагүйгээс болж торгуулахаас зайлсхийх боломжийг олгож байгаа юм. ОУИТБС-ын үйл ажиллагааны явцын мэдээлэл гаргаж өгөөгүйгээс торгуулсан компаниуд болон тайлагнасан компаниудын нэрсийг 2013 онд ОУИТБС-ын Ажлын Алба өдөр тутмын сонинд нийтэлжээ.

Иргэний нийгмийн оролцоо: Нээлттэй Нийгэм Форум, “Хил Хязгааргүй Алхам” ТББ, Байгалийн Засаглалын Хүрээлэн, “Хонгор Нутгийн Дуудлага” хөдөлгөөн, “Хариуцлагатай уул уурхайн санаачлага” ТББ, “Ариун Суварга” хөдөлгөөн, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, “Ил Тод Байдлын” сан зэргийг оролцуулсан Монгол улс дахь уул уурхайн асуудлуудад төвлөрөн ажиллаж байгаа ТББ-ын хүчтэй, идэвхтэй сүлжээ байдаг. Мөн 2015 онд Байгалийн Засаглалын Хүрээлэнгийн зүгээс Улаанбаатар дахь салбарыг нээлттэй гэрээ порталыг үүсгэн хөгжүүлэх болон сургалт явуулах чиглэлээр дэмжлэг үзүүлсэн байна.

Илэрхийлэх: ОУИТБС-ын асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой өөрийгөө хязгаарлах эсвэл өөрт ногдуулсан хязгаарлалтыг ямар ч нотлох баримт байдаггүй.

Монгол улс нь бүс нутагт дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хувьд хамгийн өндөр чансаанд ордог. Дэлхийн Фрийдом Хаусын /Freedom House/ "чөлөөт" зэрэглэлд: 2015 оны байдлаар нийт эрх чөлөө 1.5, улс төрийн эрхийн төлөө 1, иргэний эрх чөлөөгөөр 2 оноо авсан ба энэ нь мөн өмнөх хоёр жилтэй ³⁰ ижил байсан юм (1 хамгийн сайн, 7 хамгийн муу зэрэглэл). АНУ-ын "Төрийн департамент 2014 оны Монгол дахь Хүний эрхийн тайландаа"³¹ авилга, шүүх засаглал болон гэр бүлийн хүчирхийлэлийн гадаад нөлөөлөл зэрэг хүний эрхийн тулгамдаж буй асуудлуудыг дурдсан. Бидний хийсэн хэлэлцүүлгээс харахад эдгээр нь амьдрал дээр ИНБ-уудын олборлох салбарын засаглалын асуудлыг илэн далангүй ярилцах чадварт саад хийгээгүй байна. Төлсөн, Авснаа Нийтэл (ТАН) эвслийнхэнтэй хийсэн манай хэлэлцүүлэгт, ОУИТБС-тай холбоотой олон нийтийн хэд хэдэн шүүмжлэл гарч байсныг тэмдэглэсэн. Жишээ нь: 2015 оны хаврын улиралд, засгийн газраас Хятад, Японы хөрөнгө оруулагчидтай (Шиххуа, Сумитомо) Таван Толгойн талаар гэрээг олон нийтийн амралтын өмнөхөн³² байгуулах гэсэн оролдлогыг ТАН эвсэлийнхэн шүүмжилж, ОСИТБС-ын

³⁰ <https://freedomhouse.org/report/freedom-world/2015/mongolia>

³¹ <http://www.state.gov/j/drl/rls/hrrpt/2014/eap/236460.htm>

³² УИХ үнэт цаасны олон нийтийн хяналтыг багасгах үүднээс бүх нийтийн баяруудаас өмнө хууль батлахаар оролддог хэмээн ИНБ-с гомдол гаргасан.

хүрээнд Засгийн газар иймэрхүү хэлэлцээрийг ил тод хийх шаардлагатай байсан гэж үзэж, олон нийтэд мэдэгдэл хийсэн (гэхдээ энэ нь ОҮИТБС-ын стандартын шаардлага биш). Энэхүү үйл явдлын дараа Засгийн газар гэрээг үргэлжлүүлэн байгууллаагүй. Ерөнхийдөө ОҮИТБС-ын үйл ажиллагааны явцын тухай шүүмжлэл нь ОТОАХ болон Үндэсний зөвлөлийн хуралдаанаас гарсан гэж тэмдэглэсэн бөгөөд аль ч тохиолдолд тухайн хурлын протоколь олон нийтэд нээлттэй байгаа юм.

Үйл ажиллагаа: ОҮИТБС-ын хэрэгжилтэнд оролцох Иргэний Нийгмийн үйл ажиллагаанд хориг тавьсан, саатуулсан хууль эрх зүйн, зохицуулалтын, захиргааны болон бусад саад, эсвэл эрхийг хязгаарласан зүйл байхгүй. Фрийдом Хаусын зэрэглэлээс харахад цуглаан хийх болон эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хуулиар ажигладаг ч гэсэн практикт эдгээр нь засгийн газрын оролцоогүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг байна. ТАН эвслийнхэнтэй хийсэн манай хэлэлцүүлгээр хүний үндсэн эрхэд заналхийлсэн ямар ч аюул байхгүй байсан гэдгийг тэмдэглэж, Монгол улс нь ардчилсан эрх чөлөөний бат бөх уламжлалтай болохыг тэмдэглэсэн. Өгсөн мэдэгдэл нь үнэн зөв байсан ч хүний нэр төрийг гутаах нь Монгол улсад гэмт хэрэгт тооцогддог. Харин ОҮИТБС дахь оролцоотой холбоотой ТББ-ын эсрэг нэр төр гутааснаас зарга үүсгэгдсэн (амжилттай эсвэл амжилтгүй) тодорхой жишээг бидэнд гаргаж өгөөгүй.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ИНБ-уудыг ихээхэн шүүмжлэх хандлагатай байдаг. Мөн ИНБ-ууд нь ихэвчлэн "нэр төрөө гутаалгаж" зовдог гэж байсан ч, ийм олон нийтийн маргаан, мэтгэлцээн нь ИНБ-уудын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд саад болоогүй гэдгийг бас хүлээн зөвшөөрсөн байна. ИНБ-уудын протокол (мөн Баталгаажуулалтын гарын авлага, сонгогчдын тойргийн удирдамжийн аль аль нь) хараахан Монгол хэлнээ орчуулагдаагүй байгаа боловч 2015 оны 11 сард ИНБ-уудын гаргасан хүсэлтийн дагуу ОҮИТБС-ын Ажлын Алба орчуулгын үлдсэн хэсгийг шуурхай хийхээр төлөвлөж байна.

Эвсэл, холбоо: ОҮИТБС-т холбогдох иргэний нийгмийн бүлгүүд нь өөр хоорондоо болон ОТОАХ, Үндэсний зөвлөлийг шууд бусаар төлөөлөх орон нутгийн ТББ-ууд болон олон улсын бүлгүүдтэй чөлөөтэй хамтран ажилладаг. 2006 онд байгуулагдсан, 2015 оны 11 сарын байдлаар 29 гишүүнтэй гэж тоологдох Монгол Улсын Төлсөн, Авснаа Нийтэл Эвсэл нь 2013 онд өөрийн блогоос³³ вэб сайтад³⁴ шилжсэн (зөвхөн Монголд) бөгөөд ихэвчлэн цахим шуудангаар дамжуулан өөрийн гишүүдтэйгээ харьцдаг. ТУЗ нь долоон гишүүнтэй, гурван гишүүн тутмын нэг нь жил бүр солигдож байна. Эвсэл нь жилд дөрвөн удаагийн уулзалт хийдэг. 2015 он 11 сарын байдлаар гэхэд гурван удаа хуралдсан байна. 2008 онд байгуулагдсан, ойролцоогоор 700 гаруй гишүүнтэй гэж тоологдох Монголын Байгаль Орчны Иргэний Зөвлөл (МБОИЗ)³⁵ нь 2015 онд ТББ-ын сүлжээнээс төлбөрт суурилсан гишүүнчлэлийн бүтэцтэй болсон. МБОИЗ нь өөрийн гэсэн вэб сайттай³⁶ ч, гишүүдтэйгээ харьцах түүний харилцаа холбооны гол суваг нь цахим шуудан болно. ТАН болон МБОИЗ хоёрын хоорондын ажил төрлийн харилцаа холбоо нь ойр дотно байдаг бөгөөд давхар гишүүнчлэлтэй байх хэд хэдэн тохиолдол байдаг. ТАН нь орон нутгийн түвшинд МБОИЗ-ийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэхэд тусалдаг болно. ТАН нь энэ хоёр байгууллагын (ТАН болон МБОИЗ) аль алиных нь нэг хэсэг биш ТББ-уудыг ОТОАХ болон Үндэсний Зөвлөлийн гишүүн

³³ <https://sites.google.com/a/eiti.mn/tan-evsel/info-in-english-1/info-in-english>

³⁴ <http://pwyp.mn/>

³⁵ МБОИЗ-н вэбсайт <http://www.mecc.mn/> боловч сүлжээний алдааны улмаас 2015 оны 10-р сараас ажиллахгүй байгаа

³⁶ <http://www.mecc.mn/>

болохын төлөө ажиллахыг дэмжин, хүрч ажилласан ч нэг ч байгууллаг нэр дэвшигчээр бүртгэгдээгүй.

Оролцоо: ОҮИТБС-ын төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд Иргэний Нийгмийн оролцоо нь ОТОАХ-ийн уулзалт, ИНБ-уудын форум, ухуулах гэх мэтийн үйл ажиллагаанд оролцох замаар явагдаж байна. ОТОАХ болон Үндэсний зөвлөлийн хурлын³⁷ тэмдэглэлд ИНБ-ууд өнгөрсөн жилүүдэд идэвхтэй оролцоотой байгаа бөгөөд олборлох үйлдвэрлэлийн салбартай холбоотой асуудалд иргэний нийгмийн өргөн хүрээнд хамруулах боломжтойг дурдсан. ТАН эвсэл нь ТАН болон МБОИЗ эвслийн аль нэгий гишүүн бус төрийн бус байгууллагад хүрч сурталчилан ажиллаж байгаа хүчин чармайлтаа онцолсон.

Сүүлийн жилүүдэд ТАН эвсэл нь ОТОАХ болон Үндэсний зөвлөлд суудал авах бусад ТББ-уудыг (эмэгтэйчүүдийн ба ардчиллын ТББ-ууд болон бусад) урьсан гэж тэмдэглэсэн ба энэ нь ОҮИТБС-ын стандартын дагуу тодруулгын хүрээнд шаардлагатай байсан. Гэсэн хэдий ч эдгээр ТББ-ууд сонирхохгүй байгаа нь ТАН-д ОТОАХ-т 9 суудал, Үндэсний зөвлөлд 8 суудалтай байгаа шалтгаан болсон.

Олон нийтийн шийдвэр гаргалтанд хандах: Зарим нэг иргэний нийгмийн байгууллагууд хууль тогтоогчид тэдний бүх зөвлөмжийг бүрэн бүтнээр хүлээн зөвшөөрдөггүй гэж гомдоллож байгаа хэдий ч, ОҮИТБС-ын үйл ажиллагаа нь олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулж байгаа, олон нийтийн шийдвэр гаргахад нөлөөлөх зэргийг тэд шалгаж, ийм нөхцлөөр хангах чадвартай. Төлсөн Авснаа Нийтэл Эвслийн хэн шийдвэр гаргах явцад нөлөөлөх боломжгүй бөгөөд голдуу лиценз олгох гол нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн гэрээ хэлэлцээрийн хүрээнд ажиллах боломжтой байсныг дурджээ. Тодорхой жишээ гэхэд “ТАН нь 2015 оны эхээр Таван Толгойн гэрээний ажлыг амжилттай зогсоосон” нь гэж иш татсан байна (*дээр дурдсаныг харна уу “илэрхийлэх” хэсэг*). ИНБ-ууд нь шийдвэр гаргахад амжилттай нөлөөлсний жишээ болгож 2006 оны Ашигт малтмалын тухай хуульд 48.10 дугаар зүйлийг оруулахад өөрсдийн үүргийг ийг дурдсан. Тэд мөн орон нутгийн зөвлөлүүдэд зориулсан ажлын нөхцөл, даалгаврын загвар боловсруулах ажилд идэвхитэй оролцсон (*орон нутгийн зөвлөл хэсгийг доор үзнэ үү*). Сүүлийн үед иргэний нийгмийн байгууллагынхан Гацууртын төслийн өргөтгөл буюу шинэ алтны уурхай хөгжүүлэх Сентерра Гоулдын төлөвлөгөөт гэрээг УИХ батлахыг зогсооход гол үүрэг гүйцэтгэсэн гэж мэдэгдэж байгаа юм. УИХ-ын шинэ төслүүдийн талаар шийдвэр дүгнэлт гаргахад олон нийтийн зөвлөмж хяналт шаардлагатай гэж үзээд 2015 оны 07 сард Олон Нийтийн Хяналтын тухай хуулийг баталсан. МБОИЗ нь бас парламентын хэлэлцүүлэгт олон нийтийн хувь нэмрийг оруулдаг сүүдрийн "ногоон" парламентын үйл ажиллагаа явуулдаг.

Оролцогчдын санал санал

Засгийн газар ихэнх төлөөлөгчид ОҮИТБС-ын үйл ажиллагааны явцыг тодорхойлохоос илүү ОҮИТБС-ын үйл ажиллагаанд тайлангийн загварыг хүргүүлснээр өөрсдийгөө оролцож зөвлөлдсөн гэж ойлгодог. ОТОАХ-ийн Засгийн газрын гишүүд нь 2015 оны 11 сарын 3-4-ны өдрүүдийн Үндэсний чуулга уулзалтанд оролцсон хэдий ч, хүрч ажиллах, ухуулах арга хэмжээ эсвэл бага хуралд оролцоогүй тухай дурджээ. Сангийн Яам нь ОҮИТБС-ын оролцогч 35 төрийн аж ахуйн нэгжийн ОҮИТБС-ын тайлангийн нэгтгэлд харьцуулалт (ихэвчлэн цаасаар) хийхэд голлох үүрэг гүйцэтгэсэн боловч, 2015 онд цахим тайлагнах систем нэвтэрч эхэлснээр бүх мэдээллэгч аж ахуйн нэгжүүд өөрсдийн тайланг системд шууд оруулдаг болсон. Засгийн газрын хэлтэс тус бүр нь ОҮИТБС-ын тайлан хариуцсан томилж, тайланг засгийн газрын бүх агентлаг хооронд боломжтой

³⁷ 2014 оны 10-р сарын 10-ны ОҮИТБС-ын 2013 оны тайлангийн маргаан болон Харилцаа холбооны стратеги, ажлын төлөвлөгөөний 2014 оны 3-р сарын 11-ний хэлэлцүүлгийг харна уу.

болгох компанийн нэг дугаартай болох саналыг засгийн газрын зарим төлөөлөгчид гаргасан. Гаалийн ерөнхий газраас ОТОАХ болон Үндэсний зөвлөлийн уулзалтанд төлөөлөгч оролцож байгаагүйг үйлдвэрлэлийн салбарын нэгэн төлөөлөгч дурдсан.

Компаниудыг тайлангаа тушаахыг хүчлэх эрхгүй болохыг салбарын төлөөлөгчид дурдаж байсан ч, аль болох оролцогчдыг нэмэгдүүлэх үүднээс МУУҮА гишүүн биш бусад компаниудтай хамтран ажиллах хүсэл, эрмэлзэлтэй байгаагаа салбарын зарим төлөөлөл тэмдэглэв. Аж үйлдвэрийн хэд хэдэн гишүүд 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн хэрэгжилт нь компаниудын төрд төлөх төлбөрийн хэмжээг олон нийтэд ил тод болгосон тул үр дүнтэй биш байсан гэжээ. Салбарын зарим төлөөлөгчид МУУҮА нь ОҮИТБС-тай ажлын хэсэг байгуулснаар ОТОАХ эсвэл Үндэсний зөвлөлийн биш компаниудтай зөвлөлдөх илүү боломжтой болно гэж үзсэн. Улаанбаатар хотод суурилсан иргэний нийгэм нь ОҮИТБС-ын тайлангийн өгөгдлөөр хангаснаас өөр ОҮИТБС-ын үйл ажиллагаанд компанийн оролцоо байхгүй гэсэн ойлголттой байв. Зөвлөлдсөн бүх ИНБ-ууд ОҮИТБС-ын тайланг Засгийн газрын тайлангийн тогтмол элементийн нэг адил, заавал болон автоматаар хийж байх ёстой гэж үзсэн.

МБОИЗ нь засгийн газрын яамд төлбөртэй ажил хийж байсныг (5 орчим жилийн өмнө) салбарын зарим төлөөлөл дурдсан боловч ТАН-ийн төлөөлөгчид энэ нь ОТОАХ-ийн бусад оролцогчдоос ИНБ-ын бие даасан байдалд нөлөөлөөгүй гэж үзжээ. Нилээд хэдэн ИНБ-ууд одоогоор УИХ-р (Их Хурал) хэлэлцэгдэж буй ТББ-ын ил тод байдлын тухай хууль нь 2015 оны 08 сард баталсан эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн дагуу компаниудад олгох татварын өршөөлтэй харьцуулахад давхар стандартыг илэрхийлсэн гэж тайлбарлаж байна. Санал болгож буй ТББ-ын тухай хууль нь албан татвараас чөлөөлсөн байдлыг шалгаж тогтоох, Татварын ерөнхий газарт (ТЕГ) жилийн санхүүгийн тайлангаа гаргаж өгөөгүй аливаа ТББ-ыг татан буулгахад чиглэсэн. Энэ нь татвар төлөлтийн алдаанаас болж ТЕГ-ыг зорин ирж буй компаниудыг өршөөлд оруулсан. Эдийн Засгийн Ил Тод байдлын тухай хуультай харьцуулахад давхар стандарт гэж шүүмжилж байсан юм. Гэсэн хэдий ч манай зөвлөлийн хэд хэдэн хандивлагчдын дурьдсанаар бол ТББ-ын өөрсдийн албан татвараас чөлөөлөгдөх статусыг зөвтгөх шаардлага нь хэвийн зүйл учраас ийм компаниуд нь цаашид татвараа төлөх ёстой болно. ТББ-ын тухай хуулийн төслийн бас нэг заалт нь ИНБ-ыг татан буулгах асуудлаас зайлсхийхийн тулд хуучин үүсгэн байгуулагч бүх гишүүдийн гарын үсгийг цуглуулахыг шаардаж байгаа нь хуучин ТББ-ын үүсгэн байгуулагч гишүүд олдохгүй байж болох бэрхшээлийг учруулж байна. Хэрвээ энэ хуулийн төсөл батлагдвал Монгол улсад байгаа 11,000 ТББ-уудын ойролцоогоор 50% нь татан буугдах эрсдэлд орно гэсэн тооцоолол байдаг тухай бид сонссон. Ямартай ч хандивлагчдын ихэнх нь ИНБ-уудын өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлэх нөхцөл сайн хэдий ч, хэд хэдэн ИНБ болон ихэнх хэвлэл мэдээллийн байгууллагынхан улс төрчид, бизнес эрхлэгчидтэй холбоотой гэж тэмдэглэсэн байна. Нэг анхаарах зүйл нь үнэн зөв мэдээлсэн тохиолдолд ч гэсэн нэр төр гутаахыг Монгол улсад эрүүгийн гэмт хэрэгт тооцдог нь хувь хүний цензурт нь нөлөө үзүүлж болно. Нэр төр гутаахтай холбоотой олон тохиолдол гарч байсан хэдий ч, ИНБ эсрэг тодорхой нэр төр гутаахтай холбоотой хэргийн талаар (амжилттай эсвэл биш) ОҮИТБС-д холбогдох тайланд дурдаагүй байсан гэдгийг тэмдэглэсэн байна.

Үнэлгээ

Бид энэ шаардлагыг хангасан байх ёстой гэж үзнэ. Засгийн газар, компани, иргэний нийгэм нь ОҮИТБС-ын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд идэвхтэй, үр дүнтэй болоод бүрэн оролцож байна. Ялангуяа бүс нутгийн түвшинд оролцогч талууд нь олон нийтийн хэлэлцүүлэг дэмжих, хүрч сурталчилах ажилд оролцож байна. Засгийн газар хэрэгжүүлэх санхүүжилтийг олгосон. Иргэний нийгмийн ОҮИТБС дахь оролцоог хангах таатай орчин бий болсон, мөн компаниудыг ОҮИТБС-ын үйл ажилагаанд оролцохоос

урьдчилан сэргийлсэн ямар ч хууль эрх зүйн саад, тогтор харагдахгүй байна. ОҮИТБС-ын үйл ажиллагаанд өөрсдийн оролцоог сайжируулахын тулд ОҮИТБС-ын олон нийтэд хүрэх асуудал дээр өөрсдийн хүчээ бэхжүүлэхээр хоёр ИНБ-ууд ажиллаж байна. ТАН эвслийн шинэ вэб сайт³⁸ хамгийн сүүлд 2015 оны 03 сард шинэчилэгдсэн (зөвхөн Монгол хэлээр) хэдий ч, 2015 оны ТАН-н ажлын төлөвлөгөөг агуулаагүй байна (2013 оны, 2014 оны ажлын төлөвлөгөө орсон). Бид МБОИЗ нь засгийн газрын нэрийн өмнөөс урьд жилүүдэд (Байгаль орчин болон Уул уурхайн яамд) төлбөртэй ажил хийсэн гэж ойлгосон боловч, энэ нь ИНБ-уудын ОТОАХ-ийн бусад оролцоот бүлгүүдээс хараат бус байдалтай зөрчилдөөгүй гэж ойлгож байна.

2.3 ОТОБ засаглал болон гүйцэтгэх үүрэг

Явцын баримтжуулалт

ОТОБ Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон гишүүнчлэл: Монгол Улсын ОҮИТБС-ын хэрэгжилтийг хоёр байгууллага болох Үндэсний зөвлөл болон ОТОАХ удирдана. Үндэсний зөвлөл нь улс төрийн дэмжлэг авах, ерөнхий хяналт тавих үүргийг гүйцэтгэдэг бол ОТОАХ баталсан өдөр тутмын ажлын ихэнхийг Ажлын алба гүйцэтгэн явуулна. Аль аль нь байгууллагын болон оролцоот бүлгүүдтэй зөвлөлдөх хурлын протоколоос харахад ОТОАХ нь шийдвэр гаргах явцыг хариуцаж, гарсан шийдвэрийг Үндэсний зөвлөлөөр батлуулдаг байна. Ийхүү бидний ОТОБ-ийн засаглалын үнэлгээ нь ОТОАХ-д илүү чиглэсэн.

МОҮИТБС-ын Үндэсний зөвлөл нь 2006 оны 01 сарын 04-нд байгуулагдсан бөгөөд 2015 оны 03 сарын байдлаар Хавсралт А-д заасан 30 гишүүнээс бүрдэнэ. Энэ нь мөн түүний дарга болох Ерөнхий сайд ноён Чимэдийн Сайханбилэгийг оролцуулаад засгийн газрын 10 гишүүд, Уул уурхай, Санхүү, Аялал жуулчлал, Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам, УИХ-ын Улсын төсвийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий Аудитор, Үндэсний статистикийн хороо, Авлигатай тэмцэх газар, Төв аймгийн Засаг дарга зэрэг төлөөлөлийг багтаасан болно.

ОҮИТБС-ын ОТОАХ нь 2006 оны 03 сарын 31-нд байгуулагдсан бөгөөд 2015 оны 03 сарын байдлаар байдлаар Хавсралт А³⁹-д заасан 33 гишүүнтэй. Энэ нь Ерөнхий сайдын Ахлах зөвлөх Б.Дэлгэрмааг (ОТОАХ-ийн дарга) оролцуулаад засгийн газрын 11 гишүүн, Үндэсний Зөвлөлийн нарийн бичгийн дарга, түүний дотор Үндэсний зөвлөлд суудалтай засгийн газрын бүх хэлтсээс ажлын түвшний төлөөллийг багтаасан. Үндэсний Зөвлөлийн Ажиллах журмын 25-р заалт нь анх 2006 оны 05 сарын 12-нд нийтлэгдсэн бөгөөд Үндэсний Зөвлөлийг Уул уурхайн яамны Кабинетын нарийн бичгийн дарга болон засгийн газрын удирдлагын эрх мэдлийн дагуу байгуулсан байна.⁴⁰

МОҮИЛТБ-ын ОТОАХ-ийн бүрэлдэхүүнийг Ажиллах журамд тодорхойлж, Үндэсний Зөвлөлөөр 2006 оны 05 сарын 12 –ны өдөр батлуулж, хамгийн сүүлийн нэмэлт өөрчлөлтийг 2012 оны 11 сарын 09-нд оруулсан⁴¹. 2007 оны 03 сарын 28-ны өдөр гаргасан засгийн газрын 80-р тогтоолоор ОҮИТБС-

³⁸ <http://pwyp.mn/>

³⁹ Үндэсний зөвлөл болон Олон талт оролцогчдын ажлын хэсгийнхний нэрс, холбоо барих мэдээлийг МОҮИТБС-ын (<http://www.eitimongolia.mn/en/national-council> болон <http://www.eitimongolia.mn/en/working-group>) вэбсайтаас харах боломжтой. Мөн Хавсралт А-с харах

⁴⁰ Үндэсний зөвлөлийн ажиллах журмыг МОҮИТБС-ын вэбсайт (http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/EITI_National_Council_TOR_in_English.pdf) –с харах боломжтой.

⁴¹ Ажлын хэсгийн ажиллах журмыг МОҮИТБС-ын вэбсайт (http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/ToR_of_MSWG_Mongolia_EITI.pdf) –с харах боломжтой.

ын үйл ажиллагаанд оролцдог засгийн газрын төлөөлөгчдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагын чиг үүргийг тогтоосон.⁴² Монгол улсын ЗГ, компани, ТББ-уудын эвсэл хоорондын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх түншлэлийн харилцан ойлголцлын гурван талт санамж бичгийг 2007 оны 04 сард байгуулсан нь ОҮИТБС-д оролцож буй талуудыг тогтоож өгсөн.⁴³ Анх аль аль нь байгууллагын гишүүдийг 2012 он хүртэл Ерөнхий сайдын захирамжаар нэр дэвшүүлж байсан ч, Засгийн газрын 222 дугаар тогтоолоор Ерөнхий сайдыг Засгийн газрын төлөөллийг нэр дэвшүүлэх эрхтэй болгож, үйлдвэрлэлийн салбарынхныг нэр дэвшүүлэх эрх мэдлийг Уул Уурхайн Үндэсний Ассоциацид, иргэний нийгмийг нэр дэвшүүлэх эрхийг “Төлсөн Авснаа Нийтэл” болон Монголын Байгаль Орчны Иргэний Зөвлөлд шилжүүлсэн болно. ОТОАХ-ийн Ажиллах журамын 4-р зүйлээр засгийн газрын тогтоолоор баталсан гурван тойргийн тэнцүү "гурван талт" төлөөллийг шаарддаг.⁴⁴ Засгийн газрын тойрогт ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга нар орно. ТББ-ын гишүүнчилэл, эсвэл засгийн газрын болон компаниудын төлөөллийн албан тушаалын шалгуурыг хамарсан ямар ч заалт ОТОАХ-ийн Ажиллах журамд байхгүй байна. Үндэсний Зөвлөлийн Ажиллах журмын 7-р зүйлд нэн ялангуяа ТАН эвсэл, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн хуралд иргэний нийгмийн болон олборлох үйлдвэрлэлийн салбарын уул уурхай, газрын тосны компаниудын болон тэдний гэрээлэн гүйцэтгэгчийн ахлах төлөөллүүдээс оролцохыг шаарддаг боловч, ОТОАХ-ийн Ажиллах журамд зөвхөн Үндэсний Татварын Ерөнхий Газрын дарга, МУУҮА-ийн Гүйцэтгэх Захирал болон "ТББ-ын эвслийн зохицуулагч" нарыг нэрлэсэн байна. Эдгээр ахлах төлөөлөгч бүр нь ОТОАХ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх үүрэгтэй.

Засгийн газрын хувьд Засгийн газрын 222 тогтоолоор зөвхөн ОҮИТБС-ын хоёр байгууллагуудын дээрхи төлөөлөгчдийн албан тушаал болон агентлагуудыг нэрлэсэн байна. Тиймээс эдгээр албан тушаалд шинэ томилгоо хийсэн үед бие даасан төлөөлөгчид нь албан ёсоор ОҮИТБС-ын Ажлын Албанд мэдэгдэлгүйгээр өөрчилөгддөг (үйлдвэрлэлийн салбарын болон иргэний нийгмийн төлөөллийн хүлээн зөвшөөрсөн журамтай зөрчилдөж байна).

Хайгуул, үйлдвэрлэл, гэрээлэгч компаниудын дунд 120 орчим гишүүдтэй Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн ерөнхийлөгч нь олборлох үйлдвэрлэлийн салбараас гишүүн нэр дэвшүүлэх үүрэгтэй. Энэ гишүүнчлэлийн бараг тал хувь нь гэрээлэгч компаниуд, эдгээр нь Монголд идэвхтэй лиценз эзэмшигч ойролцоогоор 1000 гаруй компани байдаг. МУУҮА нь гишүүн бус компаниудын ОҮИТБС-ын тайлан нэгтгэлд оролцох оролцоог сайжруулахын тулд өөрийн гишүүнчлэлээс гадууролон нийтийн сурталчилгаа явуулж байна. МУУҮА нь 2012 он хүртэл Үндэсний зөвлөл болон ОТОАХ-д салбарын төлөөлөлийг нэр дэвшүүлэх бүрэн эрхтэй байсан боловч, харин дараа нь Ажлын Алба нь Монгол Улсын Газрын тосны газар (ГТГ)-тай зөвлөлдсөний үндсэн дээр газрын тос, байгалийн хийн хоёр компанийг (Петро Чайна Дачин Тамсаг болон Петроматад) Үндэсний зөвлөл ба ОТОАХ-н гишүүн болохыг урьсан. Петро Матад нь Газрын тосны хайгуулын болон Үйлдвэрлэгчидийн Холбоо (ҮХ) даргаар анх уригдсан юм. Ажлын хэсгээс хамаарч Петро Матадын гишүүнийг Петро Матадын буюу Үйлдвэрлэгчдийн Холбооны аль нэгийг нь төлөөлснөөр ангилсан. Үйлдвэрлэлийн салбарт нэр дэвшүүлэх үйл явцыг удирдах ямар ч бичгэн хэлбэрийн дүрэм журам байхгүй байна. Оны нэгдүгээр сарын сүүлийн лхагва гаригт болсон жилийн тайлангийн

⁴² МОУИТБС-ын вэбсайт (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/80%20-%202007.03.28.pdf>) -с Монгол хэлээр харах боломжтой.

⁴³ Санамж бичгийг МОУИТБС-н вэбсайт (http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/MoU_Mongolia_EITI.pdf) -с харах боломжтой

⁴⁴ http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/ToR_of_MSWG_Mongolia_EITI.pdf

хурлын үеэр МУУҮА нь гишүүдээс сонирхолоо илэрхийлэхийг хүссэн. Хангалттай танилцуулга дутмаг байсан хэдий ч, МУУҮА нь ихэвчлэн боломжит нэр дэвшигчийг сонгож, том болон дунд хэмжээний болон баялгийн өөр төрлүүд олборлолог компаниуд хоорондын тэнцвэрийг бий болгохыг эрмэлзэж байна. МУУҮА нь ОУИТБС-н Ажлын Албаны хамтаар тодорхой гишүүдийн хурлын оролцоо байнгын давталттайгаар муу байгааг гэрчлэх юм бол тэднийг солих болно. Хамгийн сүүлд доорхи Уул уурхайн салбарын төлөөлөгчид байсан (газрын тос, байгалийн хийн төлөөлөгчид) 2012 оноос хойш өөрчлөгдөөгүй байсан нь:

- 2012 оны 09 сар: Үндэсний зөвлөл болон ОТОАХ-ийн уул уурхайн 9 компани.
- 2014 оны 02 сар: Үндэсний зөвлөл болон ОТОАХ-ийн уул уурхайн 9 компани.
- 2014 оны 06 сар: ноён Н.Алгаа нь МУУҮА Гүйцэтгэх захирлаас Ерөнхийлөгчид томилогдож байх үеэр Үндэсний зөвлөл болон ОТОАХ-т тус бүр нэг өөрчлөлт.
- 2014 оны 12 сарын: Үндэсний зөвлөлийн нэг гишүүний өөрчлөлт.

Монголын Алт Олборлогчдын Холбооны ОТОАХ-н төлөөлөл болох ноён М.Бүрэнтогтох 2015 онд Холбоон дэх албан тушаалаа орхисон ч ОТОАХ-т түүний орлогч 2016 оны 01 сард томилогдох хүртэл хэвээр байсан.

Иргэний нийгмийн оролцооны хувьд ТАН болон МБОИЗ эвсэлүүд нь ИНБ-уудын төлөөлөлийг ОТОАХ-д нэр дэвшүүлэх үүрэгтэй. Томилолтын хамгийн урт хугацаа эсвэл хугацааны хязгаарын талаар ямар ч заалт Ажиллах журамд байхгүй. МБОИЗ нь энэхүү 2 байгууллага тус бүрт хоёр суудалтай байхад, ТАН нь Үндэсний зөвлөлийн 8 суудал, ОТОАХ-ийн 9 суудал хянадгийг Засгийн газрын тогтоол 222-р мэдэгдсэн. Үндэсний зөвлөл болон ОТОАХ-д ИНБ-уудын төлөөллийг сонгоход ТАН болон МБОИЗ-д ямар ч бичигдсэн дүрэм байхгүй байна. ТАН эвслийн дүрмээр бол ОУИТБС-ын байгууллагад нэр дэвших тухай гишүүдийн хурлаар хэлэлцсэн байх ёстой ба ТАН Монголын Зөвлөл нь хоёр жил тутамд нэг удаа шинэчлэгдсэн байх ёстой гэжээ.⁴⁵ ТАН нь давхар сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулдаг: эвсэл нь тодорхой "Олборлох салбарын талаар мэдлэгтэй хүн"⁴⁶ томилдог ба үүний зэрэгцээ албан бус сонгуулийн үйл явцад гишүүдийг хоёр төрлийн хооронд ямар ч хуваагдалгүй томилдог. МБОИЗ-ийн нэр дэвшүүлэх журам нь Сүлжээний ТУЗ-ийн гишүүдгүйгээр МБОИЗ-ийн гүйцэтгэх захирлын шийдвэрээр гурван жил тутамд нэг удаа сонгогдож шийдвэрлэсэн байна. Гэхдээ ямар ч албан ёсоор нэр дэвшүүлэх журам байдаггүй. ТАН нь Үндэсний зөвлөлийн болон ОТОАХ-т өөр өөр гишүүдтэй байхад, МБОИЗ-ийн хувьд нэг ижил гишүүн байна. ТАН эвсэл нь хоёр байгууллагын өөрийн төлөөллийг ойролцоогоор хоёр жил тутамд нэг удаа өөрчилсөн:

- 2013 оны 05 сар: Үндэсний зөвлөлийн бүх 8 гишүүд болон ОТОАХ-ийн 9 гишүүд
- 2015 оны 07 сар: хоёр байгууллагын тус бүр дээр гурван гишүүн

ОУИТБС-ын хоёр байгууллагын МБОИЗ-ийн төлөөлөгчид хэд хэдэн удаа өөрчлөгдсөн. Гүйцэтгэх захирал нь төлөөлөгчийн өөрчлөлтийн талаар албан ёсоор ОУИТБС-ын Ажлын Албанд мэдэгдэх шаардлагатай байдаг боловч (2015 оны 11 сард) хамгийн сүүлийн үеийн өөрчлөлтийг мэдэгдсэн албан бичигт Ерөнхийлөгч нь (Гүйцэтгэх Захирлаас өөр байр суурь) гарын үсэг зурсан байсан нь тогтоосон журам бага зэрэг хазайсныг илтгэнэ. Хамгийн сүүлийн үед гарсан өөрчлөлтүүд нь:

⁴⁵ <https://drive.google.com/file/d/0B-z15B6VRn2jQk5EX3RJVjFqVFU/view>

⁴⁶ “Төлсөн авснаа нийтэл” эвсэлтэй хийсэн уулзалтаас.

- 2014 оны 11 сар: хоёуланд нь гишүүд өөрчлөгдсөн
- 2015 оны 01 сар: хоёуланд нь гишүүд өөрчлөгдсөн
- 2015 оны 11 сар: нэг гишүүн өөрчлөгдсөн

Ажиллах журам: ОТОАХ-ын Ажиллах журмыг хамгийн сүүлд 2012 оны 4-рулиралд хянаж, 2012 оны 11 сарын 9-нд ОТОАХ баталсан байна.⁴⁷ Ажиллах журамд оруулсан гол залруулга нь ОТОАХ-ийн хурлыг ээлжлэн даргалах заалт байв. Ээлжлэн даргалах явдал 2014 онд үргэлжилж байхад 03 сард ОТОАХ нь МУУҮА-ийн Алгаагаар удирдуулж, дараа нь Д.Нэргүй, 10 сард Уул уурхайн яамны Стратегийн төлөвлөлт, бодлогын хэлтсийн уул уурхайн хэлтсийн дарга үргэлжилүүлсэн. Гэсэн хэдийч 2014 оны 12 сард ОТОАХ-ийн даргаар Ерөнхий сайдын зөвлөх Б. Дэлгэрмаа томилогдсоны дараа, ээлжлэн даргалах явдлыг зогсоож (2015 оны 05 болон 10 сард), бүгдийг нь Хатагтай Дэлгэрмаа даргалсан.

ОТОАХ-ийн Ажиллах журмын 8-44 дугаар зүйл нь дотоод засаглалын дүрэм, журмын талаарх мэдээллийг өгнө. ОТОАХ Ажиллах журмын 9-р зүйлд уулзалтыг даргын зөвшөөрлөөр зарлах хэдий ч уулзалтын давтамж эсвэл уулзалтын хуваарийг урьдчилан мэдэгдэхтэй холбоотой ямар ч заалт байхгүй байгааг харуулсан. Уулзалтыг даргын зөвшөөрсний дагуу зарлан хуралдуулж байгаа болон тэдний эзэнгүй үед Ажлын хэсгийн болон Үндэсний зөвлөлийн аль алиных нь гишүүн нь томилогдсон хүн нь удирдана гэсэн байна. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралд бэлтгэх болно. ОТОАХ-ийн Ажиллах журмын 13 дугаар зүйлд хэлэлцэх асуудал, шаардлагатай материалыг хурлаас өмнө дор хаяж дөрвөн хоногийн өмнө тараана гэж шаарддаг.

ОТОАХ-ийн Ажиллах журмын 16-р зүйлд хурлын ирцэд тавих шаардлагыг оруулсан. Хурлыг гишүүдийн олонхи нь оролцсон байгаа үед л эхэлнэ. ОТОАХ-ийн Ажиллах журмын 18-р зүйлд ОҮИТБС-ын Ажлын албаны гишүүн эсвэл ОТОАХ-ийн нарийн бичгийн дарга нар хурлын тэмдэглэл бэлтгэж, гарын үсэг зурж, баталгаажуулсан байх шаардлагатай. ОТОАХ-ийн Ажиллах журмын 3 болон 8.4-р зүйлд шийдвэр гаргахад хамааруулсан дараах боломжуудыг олгодог. Үүнд: ОТОАХ ямар ч шийдвэрийг зөвшөөрч болох арга замыг заасан бүлэг, төлөөлөгчдийн тэргүүн хоорондын гэрээ, түүний дотор түр ажлын хэсэг шинжээчээр судлуулж хянуулах шаардлагатай асуудлыг багтаана. Зөвшилцөл хангалтгүй байгаагийн улмаас шаардлагатай саналаар шийдвэр гаргахыг зөвшөөрсөн ямар ч заалт байхгүй. Ажиллах журмын 8.4-р зүйлд ОТОАХ-ийн гишүүд урьдчилан хэлэлцэх болон нэмэлт сэдвүүдээр бичгээр санал оруулж болох ба саналаа өөрсдийн тойргоор хянуулах ёстой гэж заасан байдаг.

Ажиллах журмын 12, 25, 28 зүйлүүд нь тайлагнах үйл явцыг хянах шаардах үүрэг хариуцлагын эрх багтана. Ажиллах журамд ОТОАХ нь иргэний нийгмийн бүлэг, компанитай хүрч ажиллах үйл ажиллагаа эрхлэхийг шаардсан ямар ч заалт байхгүй. Гэсэн хэдий ч, ОҮИТБС-ын вэб сайт бол хүрч үйлчлэх нь ОҮИТБС-ын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм гэдгийг илрэл юм. Ажиллах журамд оролцогч талуудын бүлэг тус бүрийн төлөөлөл нэр дэвшүүлэх үйл явцаас болон албадлагын ямар ч саналаас бие даасан, чөлөөтэй байх явдлыг хангах ямар нэгэн тодорхой хамгаалах заалт оруулаагүй байна. Төлөөллийн олонхийг хангах ямар ч заалт байхгүй. ОТОАХ-ийн гишүүд өөрсдийн үүргээ гүйцэтгэх чадамжтай байх тухай ямар ч тодорхой дурдсан зүйл байхгүй байна.

ОҮИТБС-ын стандартын шаардлага биш боловч, ОТОАХ-ийн ажиллах журамд засаглалын баримт бичгийн аль нэг болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ёс зүйн код, нэг иш татсан заалт

⁴⁷ Сэдэв V (хуудас 15-17) ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн 10-р хуралдааны тэмдэглэл (2012 оны 11-р сарын 28), http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_10_2012.11.28.pdf

оруулаагүй. Эцэст нь хэлэхэд, бүлгийн гишүүд нууц мэдээллийг хэрхэн хадгалах болон зохицуулах талаар ямар ч заалт байхгүй.

2015 оны 01 сарын 13-ны Үндэсний зөвлөлийн хурлаар 2015 онд үйл ажиллагаа явуулж байгаа ажлын таван бүлэг 2013 оны ОҮИТБС-ын тайланд зориулан тодорхой зөвлөмж гаргасан байхад ОТОАХ-ийн Ажиллах журамд ялангуяа тодорхой сэдвээр буцаж ОТОАХ-т мэдээллэдэг түр ажлын хэсэг байгуулах талаар тодорхой дурьдсан зүйл байхгүй. Гэсэн хэдий ч эдгээр түр хороонд зориулсан Ажиллах журам байхгүй. Мөн тэдний гишүүдийн жагсаалт олон нийтэд олдохуйц бэлэн байдаггүй. Бодит байдал дээр эдгээр түр хорооны хурлын протоколыг зөвхөн ОҮИТБС-ын Ажлын албаны хүсэлтээр гаргаснаар авах боломжтой боловч, тэд Ажлын албанд хэзээ ч хүсэлт тавьж байгаагүй гэж ойлгож байна.

Ирц: Үндэсний зөвлөл нь 2006 он болон 2015 оны 06 сарын хооронд 13 удаа уулзаж байсан, ОТОАХ нь 2013 онд гурван удаа, 2014 онд хоёр удаа, 2015 онд хоёр ч удаа уулзаж байсан болно.⁴⁸ ОТОАХ-ийн Ажлын хэсгийн уулзалт анх хэрэгжилтийн эхний жилүүдэд МУУҮА оффист зохион байгуулагддаг байсан боловч, дараа нь ИНБ-ууд үйлдвэрэлгчдийн зохион байгуулсан уулзалтанд муу оролцогийг харгалзан, байршлыг Уул уурхайн яам руу нүүлгэсэн байна. Хэд хэдэн Үндэсний зөвлөлийн хуралд ҮЗ, засгийн газрын төлөөлөгч бусад төлөөлөгчдөд ирц шилжүүлэх хандлагатай байсан, эсхүл биечлэн оролцох үед зааварчилгаа авах муу хандлагатай байсныг иргэний нийгмийнхэн тэмдэглэж байна.⁴⁹

Бодит байдал дээр Үндэсний зөвлөл болон ОТОАХ-ийнхуралдаанд ИНБ-уудын оролцоо ч бас өөрчлөгдөх хандлагатай байна. ТАН эвслийхэн энэ уян хатан байдлаараа бахархдаг бөгөөд бүх ТАН төлөөлөгчид хурлын өмнө өөрсдийн байр сууриа хүлээн зөвшөөрч ингэснээрээ хэлэлцүүлэгт тогтвортой байдлыг хангадаг гэж тэмдэглэжээ. ОҮИТБС-ын хурлын өмнө аливаа төлөөлөгчид ОҮИТБС-ын Ажлын албанд урьдчилан мэдэгдэх шаардлагатай ойлголт ерөнхийдөө байхгүй байна. Үндэсний зөвлөлийн Ажлын журамд заасны дагуу: бүх оролцогч талын гурван бүлэг ийм мэдэгдэл шаардлагатай биш гэж эрс мэдэгдсэн. Бодит байдал дээр ОҮИТБС-ын Ажлын алба ирц батлахын тулд уулзалтын өмнөхи өдөр нь Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүх гишүүд рүү залгадаг. Үндэсний зөвлөлийн хурлаар ОҮИТБС-ын вэб сайт дээр ОТОАХ болон ҮЗ аль алиных нь ирцийн бүртгэлийн хуудсыг олон нийтэд нээлтэй тавих боломжийн талаар хэлэлцэж байсан ч энэ хэзээ ч хэрэгжээгүй билээ (ялангуяа 2012 оны 11 сар 28-нд болсон ҮЗ-ийн 10-р хурал). Ажлын Алба нь эксел хэлбэрээр бүх уулзалтанд оролцогчдын ирцийн бүртгэлийн хуудсыг хөтөлсөн боловч, эдгээр онлайнаар хэвлэгдсэн бол энэ нь олон нийтийн дайралтанд өртөх магадлалтай нь санаа зовоож байна гэж бидэнд хэлсэн юм.

Орчуулга: Англи хэлнээс Монгол хэл рүү хийх орчуулгын ажилд зарим нэг онцгой бэрхшээл учруулж байна. Монгол хэлний ижил үг болох урамшуулал/дэмжлэг, дэвшүүлэх/сурталчилах, хариуцлага/ хариуцлага (accountability) гэх мэт үгнүүд нь утгаасаа хамаарч Англи хэлээр хэд хэдэн утгын хүрээнд илэрхийлэгдэж байна. Тиймээс хариуцлага нь компанийн нийгмийн хариуцлагыг хүлээх гэсэн утгатай адилтгаж болно. 2014 онд НҮБ хариуцлага гэсэн Монгол үгийг оноосон засаглалын тайлбар толийг боловсруулсан. Гэсэн хэдий ч энэ үг нь ховор хэрэглэгддэг бөгөөд ихэнхи Монголчууд олноор мэдэхгүй хэвээр байна. Үүнтэй адил үг, ил тод нь Монгол хэлээр гурван үгээр орчуулсан байна. Илүү өргөн утгаар нь Монголд зохицуулалт хомсоос болж Монгол шинэ үгс

⁴⁸ 2015 оны 11-р сарын байдлаар.

⁴⁹ Жишээлбэл 2012 оны 11-р сарын 28-нд болсон Үндэсний зөвлөлийн 10-р хуралдааны үеэр шинэчилсэн Үндэсний зөвлөлийн санамж бичгийн хэлэлцээрийн дагуу. Сэдэв V (хуудас.15-17) МОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн 10-р хуралдааны хурлын тэмдэглэл (2012 оны 11-р сарын 28), http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/NC_10_2012.11.28.pdf

олноор хурдан бий болж байна. Засгийн газар гол үгсийн үг үсгийн алдаа, утгыг тодруулах тусгай хороо байгуулан ажиллаж байна. Адам Смит Интернэйшналь нь ОҮИТБС-ын стандартын орчуулгыг Монгол хэл рүү нь хөрвүүлсэн. ОҮИТБС-ын Стандартын Монгол хувилбар нь зөвхөн А5 28 хуудас байгаа нь бага зэрэг санаа зовоож байна. Зөвхөн шаардлагуудыг орчуулснаас биш Баталгаажуулалт гарын авлага, ИНБ-уудын Протоколыг орчуулаагүй, гэхдээ ОҮИТБС-ын Ажлын алба эдгээр орчуулгыг дуусгах төлөвлөгөөтэй гэдгийг бид ойлгох байна.

Оролцогчдын санал

ОҮИТБС-д оролцож буй бүх гурван оролцоот бүлгүүдийн хэд хэдэн төлөөлөл нь Үндэсний Зөвлөл бол билэг тэмдгийн нэгж, Уул уурхайн яамны сайд нараас бусад өндөр тушаалын албан хаагчдын ирц муу байсан гэж тэмдэглэсэн байна. Сүүлийн гурван жилд нь Сангийн сайд болон Ерөнхий сайдын аль нь Үндэсний зөвлөлийн хуралд оролцож байгаагүй гэж тэмдэглэсэн байна. Бүх оролцогч талууд үзэж буйгаар ОТОАХ нь ОҮИТБС-ын хэрэгжилтийг үр дүнтэй удирдах, шийдвэр гаргах байгууллага юм. Бүх ИНБ-ууд нь ОТОАХ-ийн гаргасан шийдвэрийг Үндэсний зөвлөл батлах л үүрэгтэй байгааг дурдсан. Бичиг баримтыг байнга урьдчилан явуулдаг ч хэд хэдэн засгийн газрын төлөөлөгчид нь цаг хугацааны давчуу байдал болон ажлын ачааллын улмаас тэд хувь нэмрээ оруулах боломжтой биш байсан гэж тэмдэглэсэн.

Бодит байдал дээр ОҮИТБС-ын Ажлын алба нь ихэвчлэн уулзалтын хуваарийг урьдчилан нэг долоо хоногийн өмнө гаргаж, төслийн хөтөлбөр болон хэлэлцэх асуудал, баримт бичиг урьдчилан и-мэйлээр наад зах нь дөрвөн өдрийн өмнө илгээж байна. ОҮИТБС-ын тайлангийн төслийг хатуу хэвлэмэл хувилбараар уулзалтаас өмнө урьдчилан наад зах нь дөрвөн хоногийн өмнө явуулсан байх ёстой, үүнийг биелүүлэх шаардлагатай. Хэдэн ИНБ-ууд нь хурлын хэлэлцэх хэргийн төсөлд нэмэлт хийх нь хүнд хэцүү байсан гэж тайлбарласан хэдий ч энэ боломжтой гэж үзсэн учраас тохиролцсон байсан. Гол шалтгаан нь хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан гурав хоногийн өмнө илгээсэн гэж байсан бөгөөд энэ төлөвлөсөн зүйлсийг хэлэлцэхэд шаардлагатай бүх материалыг цуглуулахад хангалттай хугацаа өгөөгүй юм. Гэсэн хэдий ч ИНБ-ууд нь хурлаар хэлэлцэх асуудлыг явуулахаас өмнө баримт бичгийг бэлтгээд бэлтгээд явуулж болох ч, ИНБ-уудын хязгаарлагдмал чадавхи нь хэцүү сорилт болсон гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Хэд хэдэн үйлдвэрлэлийн салбарын төлөөлөл нь Үндэсний зөвлөл, мөн ОТОАХ-н Ажлын хэсгийн аль аль нь зөвшилцөл дээр тулгуурласан шийдвэр гаргах сорилттой байсан ч, тус бүр нь олон тооны гишүүдтэй (10, 11 тус тус) байсны улмаас үр дүнтэй ажилласан гэдгийг тэмдэглэсэн ба АМГ болон Татварын Ерөнхий газрын гэх мэт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн төлөөллийн тоог бууруулж байх ёстой гэжээ. Үндэсний зөвлөл, мөн ОТОАХ Ажлын хэсгийн аль аль нь зөвшилцөл дээр тулгуурласан шийдвэрийн Ажиллах журмын заалтыг бодит байдал дээр хүндэтгээгүйн учраас олон ИНБ-ууд нь Засгийн газар болон үйлдвэрлэлийн салбарын эсрэг гомдол гаргав. Практикт Үндэсний зөвлөлийн санал авах заалт байхгүй байгаа хэдий ч, үйлдвэрлэлийн салбар болон иргэний нийгмийн аль алиных нь төлөөлөгчид санал өгөх нь бүх оролцогч талуудын гурван бүлгээс дэмжсэн саналын шаардлагагүйгээр практикт хийгдэж байсан гэж тэмдэглэжээ.

"ОҮИТБС-ын тухай хууль" төслийн нэг хэсэг болгож санал болгож буй өөрчлөлтийг хэрэгжүүлэхийг нэрлэсэн ба эдгээрт Үндэсний зөвлөл болон ОТОАХ-ийг нэг нэгж болгон нэгтгэх, мөн Ажлын албаны нэмэлт үүрэг, биелэлтийн бүрэн чадавхийг оролцуулсан. Цөөн ИНБ-ууд нь улс төрийн байнгын өөрчлөлтийн нөлөөнөөс болж ОҮИТБС-ын хуралдаанд засгийн газрын төлөөлөгчдийн тогтвортой бус ирцийн тухай онцлон тэмдэглэв. ИНБ-уудын оролцогчдын байнга өөрчлөлт нь мөн тэмдэглэсэн байсан ба оролцооны тасралтгүй дутагдалаас болж бухимдал байсан нэг ялангуяа төрийн албан хаагчид. Салбарын хэд хэдэн төлөөлөл ИНБ-ууд нь байнга ОҮИТБС-ын уулзалт дээр байнга ирц эргүүлэх хандлагатай гэж үзсэн ба энэ нь мэдээлэлсэн хэлэлцүүлгийг дэмжээгүй. Гэсэн хэдий ч ИНБ-уудын хэд хэдэн төлөөлөгчид иргэний нийгмийн оролцоо сүүлийн

жилүүдэд эрс сайжирсан гэж тэмдэглэжээ. Оролцогчдын хэлэлцүүлгийн хувьд бидний уулзсан орон нутгийн зөвлөлүүд нь янз бүрийн иргэний нийгмийн төлөөллийн бүлэг Үндэсний зөвлөлийн болон ОТОАХ-ийн ИНБ-уудын төлөөлөгчид тэдэнтэй зөвлөлдөх хандлагатай байдаггүй гэжээ. Радио телевизийн ахмад гишүүн нь ОТОАХ, Үндэсний зөвлөл, болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн гишүүдийн хооронд ямар ч бодит зөвлөлдөх механизм байгаагүй гэж мэдэгдсэн.

Ихэнх ИНБ-ууд нь ОТОАХ-ийн уулзалтыг Уул уурхайн яаман дээр зохион байгуулж, мөн хэлэлцүүлэгт цаг давчуу байгаа талаар санаа зовж байгаагаа илэрхийлсэн бөгөөд хэлэлцүүлгийг Нээлттэй Нийгэм Сан дээр хийж болохыг тэмдэглэсэн байна. Хэд хэдэн ИНБ-ууд нь Үндэсний зөвлөлийн хурлыг Ерөнхий сайд бус харин үнэн хэрэгтээ Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын Ахлах Зөвлөх хатагтай Б. Дэлгэрмаа даргалж байсан гэж тэмдэглэсэн байна. Өмнө нь Үндэсний зөвлөлийн хурлыг Ерөнхий Сайд нээж байсан бол, дараа нь түүний орлогч дарга, Уул уурхайн сайдад шилжүүлсэн нь өмнөхи нөхцөл байдалтай зөрчилдөж ялгаатай байна (гурван жилийн өмнөхи).

Үнэлгээ

Тайлан тэнцэл дээр бид энэ заалтыг хангасан байх ёстой гэж үзнэ. ОТОАХ байгуулагдсан ба ямар ч ятгалагагүйгээр оролцогч тус бүрээс өөрийгөө томилсон төлөөлөгчдийг багтаасан байна. Гэсэн хэдий ч ОТОАХ-ийн иргэний нийгмийн нэр дэвшүүлж байгаа механизм нь ТАН болон МБОИЗ эвслийн гаднахи гишүүдийг сонголтыг хязгаарласан боловч, ингэснээр оролцох дуртай байсан гишүүн бус ТББ-г хязгаарлаж байна гэсэн ямар ч нотолгоо байхгүй юм. ОТОАХ-ийн Ажиллах журамд ОҮИТБС-ын стандартын шаардлагуудыг тусгасан боловч зарим оролцогч практикт нэн ялангуяа санал авахтай холбоотой тодорхой хазайлт байгааг онцолсон. Нийтлэг янз бүрийн төлөөлөгчид оролцсон төлөөлөгчдийн хамт ОТОАХ-ийн гишүүдийн ирц тогтворгүй байдаг. Гэсэн хэдий ч ОТОАХ үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулахын тулд өөрсдийн дотоодод нэр дэвших болон журмуудын танилцуулгыг коджуулахыг оролцогч тус бүрээс асууж, хүсэж болох юм. ОТОАХ нь Үндэсний зөвлөл болон ОТОАХ-ийг нэгтгэх, түүний гишүүдийн тоог бууруулах, байнга уулзаж байх "ОҮИТБС-ын тухай хууль"-ийн төслийн заалтыг УИХ-ын хуулийг бүрэн батлахыг хүлээлгүйгээр хэрэгжүүлэхийг шаардаж болно (улиралд нэг удаа, хууль тогтоох саналын дагуу).

2.4 Ажлын Төлөвлөгөө

Явцын баримтжуулалт

ОҮИТБС-ын 2015 оны Үйл ажиллагааны (ажлын) төлөвлөгөө нь ОҮИТБС-ын вэб сайт дээр байгаа юм⁵⁰. Үүнийг ОТОАХ ба Үндэсний зөвлөлийн 2014 оны 10-р хуралдаанаар, 2015 оны 01 сарын 13-ны өдрийн 12-р хуралдаанаар баталсан байсан⁵¹. 2015 оны ажлын төлөвлөгөөний⁵² зорилго нь 2014 оны ажлын төлөвлөгөөнд⁵³ байсан 7 ОҮИТБС-ын шаардлагатай ижил байна. Тиймээс ажлын төлөвлөгөөний зорилго нь олборлох салбарын үндэсний тэргүүлэх чиглэлийг тусгаагүй болно.

⁵⁰ Англи хэлээр (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>) болон Монгол хэлээр (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015mn.pdf>).

⁵¹ МОҮИТБС-ын 2015 оны 1-р сарын 13-нд хийсэн 12-р хуралдааны хурлын тэмдэглэл, (вэбсайтад зөвхөн Монгол хэлээр боломжтой, http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/UZ_12_2015.pdf)

⁵² МОҮИТБС-ын 2015 оны ажлын төлөвлөгөө, <http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>.

⁵³ МОҮИТБС-ын 2014 оны ажлын төлөвлөгөө, http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/en/EITIM_POA_2014en.pdf

2015 оны ажлын төлөвлөгөө ОТОАХ-ийн хурлаар хэлэлцэгдэж байсан нь тодорхой бус байна. 2014 оны ажлын төлөвлөгөөг Монголын Зөвлөх Компани Ай Си Жи дөрвөн жилийн харилцаа холбооны төлөвлөгөөний зураг боловсруулж, ОТОБ өөрийн хурлаар 2014 оны 03 сарын 11-нд баталсан байсан гэж тэмдэглэсэн байдаг.⁵⁴ ОТОАХ нь өөрийн 2014 оны 03 сарын 11-нд хурлаар баталахаас өмнө 2014 оны ажлын төлөвлөгөөнд тодорхой элементүүдийг нэмсэн.⁵⁵ ОҮИТБС-ын Ажлын Албаны газар нь голдуу ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж, дараа нь ОТОАХ-ээр хэлэлцүүлж, нэмэлт, өөрчлөлт оруулсны дараахь хурлаар баталуулдаг байна. 2015 оны ажлын төлөвлөгөө нь хэмжигдэхүйц, цаг хугацааны үүрэг үйл ажиллагааг багтаасан байхаас гадна, мөн хэрэгжүүлэх нь тодорхой хугацаа, хариуцах тал (ууд), хамтран зохион байгуулагчдыг тодорхойлох, санхүүжилтийн эх үүсвэр (үүд) болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд зэрэг багтана. Энэ нь ОҮИТБС-ын Тайланд тодорхойлсон тодорхой чадавхийн хязгаарлалтыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хамтаар ОҮИТБС-ын зөвлөмжийн хэрэгжилтийн талаар хяналт-шинжилгээний тайлан гэх мэт бусад үнэлгээг багтаана. Үүнд хууль эрх зүйн орчинд бий болгох мэдээллийн сан, олборлох салбар дахь төрийн өмчийн, орлого зарлага, зарлагын болон орон нутгийн шилжүүлэг, дэд бүтцийн байгууламж зэрэг багтана.⁵⁶

Өмнөх ОҮИТБС-ын тайлангийн зөвлөмжийг шийдвэрлэхийн тулд 2015 оны ажлын төлөвлөгөөний дөрөв дэх хэсэг нь үндэсний хэмжээнд чадавхийг бэхжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд төвлөрч харин тав дахь хэсэг нь орон нутгийн хэмжээнд чадавхийг бэхжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд төвлөрнө.⁵⁷ 11 сарын 3-4-ны өдрүүдэд болсон Үндэсний Форумын зорилгын нэг нь харилцаа холбоо, хүрч ажиллах болон орон нутгийн хэрэгжүүлэх гэх мэт гол салбаруудад чадавхийг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулан, 2016 оны ажлын төлөвлөгөөнд оруулах саналыг дэмжих явдал байсан юм.⁵⁸

2015 оны ажлын төлөвлөгөөнд бас 2014 оны ОҮИТБС-ын тайлангийн урьдчилсан судалгаа хийх, мөн ОҮИТБС-ын тайлангийн ажилтай холбоотой үйл ажиллагаа, ОҮИТБС-ын стандартын дагуу шаардлагатай үндсэн мэдээллийг эх үүсвэрийг бий болгохтой холбоотой бүхий л үйл ажиллагаа орно. 2015 оны ажлын төлөвлөгөөний 9 дэх хэсэгт ОҮИТБС-ын тайланг биелүүлэхэд гарах зохицуулалтын саад бэрхшээлийг даван туулах зорилготой байгаа Ашигт малтмалын салбарын Ил Тод Байдлын тухай хуулийн төслийг батлан гаргахалдэранхаарна. Ажлын төлөвлөгөө нь үйл ажиллагаа тус бүрээр санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон боловч, ОҮИТБС сайт дээр нийтэлсэн 2015 оны ажлын төлөвлөгөөний хувилбарт үйл ажиллагааны зардал буюу нийт төсвийг оруулаагүй байна. 2014 оны ажлын төлөвлөгөө нь зардлуудын Монгол хувилбарыг багтаасан бол, харин Англиар байгаагүй. Энэ орхигдуулах шалтгаан нь (ОТОАХ эсвэл Үндэсний зөвлөл тохиролцсон) “Ай Си Жи” компани нь Ажлын Албанд харилцаа холбооны үйл ажиллагааны төсвийг тодорхой харилцаа холбооны үйл ажиллагаа явуулах гэрээлэгчийн тендерт орох хэлэлцээ хийх эрх мэдлийг хадгалахын тулд нийтэлж болохгүй гэж зөвлөсөн байсан. Бид одоо Ажлын

⁵⁴МОҮИТБС-ын олон талт ажлын оролцооны 2014 оны 3-р сарын 11-нд хийсэн хуралдааны хурлын тэмдэглэл (Вэбсайтад Зөвхөн Монгол хэлээр байгаа, http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/AH_35_20150312.pdf)

⁵⁵<http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMWorkReport2014en.pdf>

⁵⁶МОҮИТБС-ын 2015 оны ажлын төлөвлөгөө (хуудас 1), <http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>.

⁵⁷МОҮИТБС-ын 2015 оны ажлын төлөвлөгөө (хуудас 2-3), <http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMActioPlan2015en.pdf>.

⁵⁸Үндэсний форум, 2015 оны 11-р сарын 3. Хурлын тэмдэглэлийг удахгүй оруулах болно.

Албаны газар 2014 оны ажлын төлөвлөгөөг үйл ажиллагаа тус бүрийн бүрэн өртгийн хамтаар дахин нийтлэхээртөлөвлөж байгаа гэдгийг ойлгоно.

2015 оны ажлын төлөвлөгөөнд ОТОАХ нь бенефициаль өмчлөгчид зориулан ОУИТБС-ын Тайланг дэлгэрэнгүй ил тод тайлагнах, гэрээний тодруулга, (үйл ажиллагааны нэг, гэрээний ил тод байдлын мэдээллийн сан бий болгох, бенефициаль өмчлөгчийн хамрагдсан), орлого зарлага, орон нутгийн шилжүүлэг, зарцуулалт, (үйл ажиллагааны тав, эдгээр төлбөрийн мэдээллийн сан бий болгох) зэргийг тодорхой анхаарсан. 2013 оны, 2014 болон 2015 оны ажлын төлөвлөгөөнд үйл ажиллагаа тус бүрийн дуусах тодорхой цаг хугацааг оруулсан.

2013 онд Ажлын Албаны газар төлөвлөсөн 42 үйл ажиллагааны 33 нь биелэгдсэн (нийт 80%), "ОУИТБС-ын тухай хууль" төслийн дэмжлэг болон телевизийн нэвтрүүлгийн цувралын ажлаас болж үндсэн үйл ажиллагаа нь дуусаагүй байсан гэж мэдээлсэн байна.⁵⁹

2014 онд Ажлын Алба нь төлөвлөсөн 65 үйл ажиллагааны 42 нь биелэгдсэн (нийт 65%) , гол биелэгдээгүй ажлууд нь "ОУИТБС-ын тухай хууль" төслийг батлах, бүс нутгийн бага хурал зохион байгуулах, телевизийн нэвтрүүлэгийн хөтөлбөр байсан гэж мэдээлсэн байна.⁶⁰

2015 оны 11 сарын 06-ны байдлаар 2015 оны ажлын төлөвлөгөөнд төлөвлөсөн 50 ажлын 35-ыг дуусгасан байна. Хараахан дуусгаагүй байгаа үйл ажиллагаа нь ОУИТБС-ын стандартын дагуу Баталгаажуулалт, "ОУИТБС-ын тухай хууль" батлагдсаны дараа хийхээр төлөвлөсөн төлөвлөгөөт ажлууд, зүүн бүс нутгийн ОУИТБС-ын Нээлттэй Өдөр, орон нутгийн зөвлөлүүдийн сургалт зэрэг болох боловч эдгээрийг 2016 оны 03 сар гэхэд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Цаг хугацааны хувьд боломжгүй мөн өвлийн улиралд энэ үйл ажиллагааг зохион байгуулах бэрхшээлтэй холбоотойгоор Орон нутгийн түвшинд 2015 онд хийхээр төлөвлөсөн иргэний нийгмийн сургалт биелэгдэхгүй гэж тооцогдож байгаа ба энэ нь 2016 оны 03 сар хүртэл хойшилогдох магадлалтай.⁶¹ 2016 ажлын төлөвлөгөөг Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны (ГОУХАН) техникийн туслалцаатайгаар дуусгаахаар төлөвлөж байна.

Оролцогчдын санал

Бидэнтэй зөвлөлдөж байсан оролцогч талуудын төлөөлөгч тус бүрийн бараг хагас нь 2015 оны ажлын төлөвлөгөөг бүрэн нарийвчлан уншаагүй байсан. Гэхдээ тэд ОТОАХ-ийн даргын албан бичгээр дамжуулан баталсных нь дараа өөрсдийнх нь тодорхой хэлтэст нөлөөлсөн гэх ажлын төлөвлөгөөний элементийн талаар мэдээллийг авсан гэж тэмдэглэсэн байна. Хэд хэдэн салбарын төлөөлөгчид ажлын төлөвлөгөө хэрхэн боловсруулсан байсныг сайшаахгүй болон хүрч болох зорилго руу хөтлөх авч явуулбал зохих арга хэмжээний цуврал гэхээсээ илүү хүсч байгаа зүйлсийн жагсаалтыг тэмдэглэсэн байсныг тэмдэглэсэн.

Үйлдвэрлэлийн салбарын болон ИНБ аль аль нь төсвийн ил тод байдлын дагаж мөрдөх арга хэрэгсэл болгон үзэж, ОУИТБС-ын үйл явц гэж юу болох талаар ихээхэн өөр өөр үзэл баримтлал тэнд байсан гэж байхад ба харин ИНБ нь шинэчлэлийн Засгийн газрын оролцох тавцан гэж ойлгожээ гэж тэмдэглэж байна. Бид зөвлөлдөж байсан хэдэн оролцогчдын аль ч бүлэг яагаад

⁵⁹МОУИТБС-ын 2013-2014 оны үйл ажиллагааны жилийн тайланд мэдээллэсэн, 2014 оны 7-р сар (хуудас 15)
https://eiti.org/files/document/Mongolia_EITI_Activitie_report_2013_half_2014_half_last.pdf

⁶⁰МОУИТБС-ын 2014 оны үйл ажиллагааны жилийн тайлан, 2015 оны 1-р сар (хуудас 13)
<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMWorkReport2014en.pdf>

⁶¹МОУИТБС-ын ажлын хэсгийн тооцооллоос.

Монгол улс ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа юм гэж асуусныг дурдсан байв. Засгийн газрын нэг төлөөлөгч Монгол улс дэлхийн уул уурхайн салбарын дунд бага зэрэг алдартай болоод байсан үедээ хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх арга хэрэгсэл болгон 2006 онд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхээр шийдсэн гэж тэмдэглэсэн байна. Хэд хэдэн ИНБ-ууд нь Монгол улс ядуурлыг бууруулах, иргэд нь байгалийн баялгийг ашиг тусыг бүрэн хүртэх гэж ОҮИТБС-ыг хэрэгжүүлсэн гэж тэмдэглэсэн байна. Жилийн үйл ажиллагааны тайлан нь ажлын төлөвлөгөөн дэх үйл ажиллагааны биелэлтийг тоймлон үзүүлдэг хэдий ч ИНБ-уудын төлөөлөгчийн нэг нь ОҮИТБС Ажлын Албаны газрыг өөрийн санхүүгийн тайлангаа ҮЗ эсвэл ОТОАХ-т жилд нэг удаа танилцуулах болон Ажиллах журамд өөрчлөлт оруулахыг шаардсан.

Үнэлгээ

Бид энэ шаардлага нь ямар нэгэн ахицгүй бөгөөд хангагдаагүй гэж үзэж байна. Жилийн ажлын төлөвлөгөө олон нийтэд хүртээмжтэй, цаг тухайд нь гаргаж байгаа хэдий ч, түүний гол чанар нь хэд хэдэн арга замаар ОҮИТБС-ын шаардлагын 1.4-тэй нийцээгүй байна. ОҮИТБС-ын хэрэгжүүлэх гол зорилго нь олборлох салбарын үндэсний тэргүүлэх чиглэлийг тусгаагүй мөн үйл ажиллагаа нэг бүрт гарах тодорхой зардлыг оруулаагүй байна. Гэсэн хэдий ч ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн ямар нэгэн саатал нь яриад байгаа хууль эрх зүйн болон санхүүгийн хязгаарлалтаас болсон юм шиг харагдаж байна. ОТОАХ нь 2016 оны ажлын төлөвлөгөөг шинэчилэн, үндэсний тэргүүлэх зорилтуудыг болон яагаад Монгол улс ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа талаар асуудлыг тусгасан ОҮИТБС-ын Ажлын Төлөвлөгөөний төсөл боловсруулж эхлэх нь зүйтэй.

Хүснэгт 1 – Нэгтгэсэн үнэлгээний хүснэгт : ОТОБхяналт

ОҮИТБС шаардлага	Гол үр дүнгийн тойм	ОҮИТБ нийцсэн Баталгаажуулагчийн санал
ОҮИТБС-ын ахиц дэвшлийн талаар Засгийн Газрын хяналт (#1.1-1.2)	Засгийн газар ОҮИТБС-ыг дэмжиж, үүрэг хүлээн ажиллаж байна. Холбогдох засгийн газрын төлөөлөл ОТОАХ-ийн нэг хэсэг болсон	Шаардлага хангагдсан

Оролцогчдын оролцоо болон тэдний ОҮИТБС-ын үйлажиллагаанд оролцох орчин (#1.3 (#1.3))	Засгийн газар, компани, иргэний нийгэм нь ОҮИТБС-ын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж оролцож байна. Оролцогчид хүрч ажиллах, олон нийтийн хэлэлцүүлгийг дэмжих ажилд оролцдог. ОҮИТБС-ын ажилд иргэний нийгмийн оролцоог хангах таатай орчин бий болсон, ОҮИТБС-д компанийн оролцоог хориглох ямар ч хууль эрх зүйн саад тогтор болох зүйл байхгүй байна	Шаардлага хангагдсан
ОТОВ засаглал болон гүйцэтгэх үүрэг (#1.3)	ОТОВ нь хангалттай төлөөлөл болон бүх оролцогч талуудаас бүрдэнэ. ОТО-АХ-ийн Ажиллах журам нь ОҮИТБС-ын стандартын шаардлагад нийцэхүйц практикт ихээхэн дагаж мөрддөг, шийдвэр гаргах болон санал хураалтыг багтаасан байна. ОТОАХ нь жилд 3 удаа уулздаг, хэд хэдэн түр хороо тодорхой ажил хийдэг боловч уулзалтуудын хурлын протокол хөтлөгдөөгүй байна	Шаардлага хангагдсан
Ажлын Төлөвлөгөө (#1.4)	ОТОАХ нь олборлох салбарын үндэсний тэргүүлэх чиглэлтэй уялдаатай зорилтуудыг тохиролцож чадахгүй байна. ОҮИТБС-ын вэб сайтад нийтэлсэн ажлын төлөвлөгөөнд үйл ажиллагааны зардал багтаагүй байна. Хэрэгжүүлэлт зөв зам дээр өргөн хүрээнд явж байгаа ч тодорхой саатал нь байж болох юм шиг харагдаж байна.	Ахиц сайтай байгаа ч, шаардлага хангагдаагүй
Нийтүнэлгээ: Ахиц сайтай байгаа ч, шаардлага хангагдаагүй		

Баталгаажуулагчийндүгнэлтбазөвлөмж:

1. ОТОАХ нь ОҮИТБС-р дамжуулан хэрхэн үндэсний болон тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан үр дүнтэй хэлэлцүүлгийг хийх талаар авч үзэх нь оролцогчдын идэвхтэй оролцоог нэмэгдүүлнэ.
2. МУУҮА, ТАН эсвэл МБОИЗ гишүүн бус оролцогчдыг төлөөлөлд оруулахад шаардлагатай нэр дэвшүүлэх, төлөөллийн дотоод журмаа боловсруулахыг оролцогч бүрээс ОТОАХ нь асуух.
3. Уулзалт зөвлөлгөөнд оролцсон хэд хэдэн салбарын санал болгосноор ОТОАХ нь Үндэсний зөвлөл болон ОТОАХ-ийг нэгтгэх, түүний гишүүний тоог бууруулах "ОҮИТБС-ын тухай хууль"-ийг УИХ бүрэн батлахыг хүлээлгүйгээр түүний заалтыг хэрэгжүүлэх талаас нь харах. Үүний үр дүнд хурал, уулзалтыг илүү ойр давтамжтай зохион байгуулна (улиралд нэг удаа, хууль тогтоох саналын дагуу).
4. ОТОАХ нь 2016 оны ажлын төлөвлөгөөг олборлох салбарын үндэсний тэргүүлэх чиглэлийг тусгаж, шинэчлэх хэрэгтэй.
5. ОТОАХ нь тайлангийн нэг загвар, чадавхийг бэхжүүлэх байдлыг хангах үүднээс ОҮИТБС-ын тайлан хариуцсан нэг ажилтанг хэлтэс тус бүрт томилон ажиллуулах боломжийн талаар төрийн байгууллагатай зөвлөлдөх.
6. ОТОАХ болон Үндэсний зөвлөлийн гишүүн бус компаниудад илүү зөвлөгөө өгөх үүднээс ОҮИТБС-ын ажлын хэсэг байгуулж болох юм.
7. Зөвхөн төлөөллийн ихэнх нь ирсэнийг бүрэн ирцэд тооцох биш оролцогчдын бүлэг бүрээс хэд хэдэн төлөөлөл ирснийг ирц бүрдсэнээр тооцдог байхаар ОТОАХ-ийн Ажиллах журамд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Мөн энэхүү шинэчилсэн Ажиллах журмаар ОТОАХ болон МОҮИТБС-ын Ажлын албаны үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгөх хэрэгтэй.

Хэсэг II – ОҮИТБС-ын мэдээллийг ил болгох тухай⁶²

Гэрээ байгуулах, лиценз олгох

1.1 Танилцуулга

Энэ хэсэгт олборлох салбарын эрх зүйн тогтолцоо, лиценз олгох явц, гэрээ, хэлцэл, давуу эрхтэй бенефициар эзэмшил болон төрийн байгууллагуудын оролцоо зэрэгт холбогдох ОҮИТБС-ын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулав.

1.2 Үнэлгээ

Эрх зүйн тогтолцоо (#3.2)

Явцын баримтжуулалт

2013 оны Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын (ОҮИТБС) тайланд уул уурхайн эрх зүйн болон зохицуулалтын хамрах хүрээг тодорхойлсон юм. Уул уурхайн салбарын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө (57-58-р хуудас), уул уурхайтай холбоотой төрөл бүрийн хууль тогтоомжууд (2006 оны хууль, 2014 оны нэмэлт өөрчлөлт, 2001 оны Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Газрын хууль, Цөмийн энергийн хууль гэх мэт), (58-60-р хуудас) болон Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд (29-р хуудас)-д тус тус энэ талаар дурдсан байна. Гэхдээ “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль (“Урт нэртэй хууль”) (28, 57-р хуудас)-инд энэ талаар нэн хязгаарлагдмал хүрээнд дурдсан бөгөөд зөвхөн дагаж мөрдөх хэрэгцээ шаардлагын талаар тэмдэглэсэн байдаг. Газрын тос, шатдаг хийн эрх зүйн болон зохицуулалтын хамрах хүрээ: Газрын тосны тухай хуульд (2014) (64-65-р хуудас) энэ талаар дурдаж, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулинд (65-р хуудас) мөн дурдсан байна. Гаалийн татвараас чөлөөлөх, НӨАТ-с 5 жил чөлөөлөх, газрын тосны борлуулалтаас олсон орлогыг орлогын татвараас чөлөөлөх зэрэг 25 жилийн хугацаатай Бүтээгдэхүүн Хуваах Гэрээний (БХГ) системийн талаар мөн дурджээ. Олборлох, үйлдвэрлэх, ашиглах зардлыг 100% нөхөх боломж, түүнчлэн зардлыг нөхөх жилийн 40%-н төлбөрийн талаар бас тайлбарлажээ.

Төсвийн шилжүүлгийн зэрэглэл болон холбогдох төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагын талаар (54-55-р хуудас) мөн дурдсан байв. Дэлхийн Банк⁶³ зэрэг хоёрдогч эх үүсвэрээс бидний авсан мэдээлэлд үндэслэн хэдийгээр энэ талаар 2013 оны ОҮИТБС-ын тайланд дурдаагүй боловч, алт, зэсээс бусад бүх бараа бүтээгдэхүүний хувьд нөөц ашигласны төлбөрийн 30%-ийг орон нутгийн удирдах байгууллага шууд авна гэж ойлгож байна. Уул уурхайн хувьд, тусгай зөвшөөрөл олгоход гүйцэтгэх АМГ-ын болон засаг дарга нарын үүрэг ролийн талаар мэдээлэл (59, 60-р хуудас) оруулжээ. Газрын тос, шатдаг хийн хувьд АМГ болон Газрын Тосны Газрын гүйцэтгэх үүрэг ролийн талаар ерөнхий хүрээнд дурдав. Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үүрэг ролийг зөвхөн цацраг идэвхт бодисын хувьд авч үзсэн (60-р хуудас) бөгөөд бусад тусгай зөвшөөрөл буюу БХГ-тэй холбоотой мэдээллийг оруулаагүй болно. Цөмийн Энергийн Газрын үүрэг ролийн талаар дурдсан хэдий ч нарийвчлан тодорхойлоогүй (64-р хуудас) юм. Шинээр байгуулах, бүх БХГ-ний

⁶² Хуудасны дугаарлалтыг МОҮИТБС-ын вэбсайтад байгаааа МОҮИТБС-ын 2013 оны Англи хэл дээрх тайлангийн дагуу ашиглаж байгаа болно. (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/Final%20report%20EITI%20Mongolia%202013%20en.pdf>)

⁶³ Дэлхийн банк (2011), “МОҮИТБС-ыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нь” Хуудас13 – <http://siteresources.worldbank.org/INTOGMC/Resources/EITI-WBMiningSectorWEB.pdf>

дагуу Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл хориг тавих эрхтэй болох нь Газрын Тосны Газрын газрын тос, хийн төлөөлөгчидтэй бидний хийсэн хэлэлцүүлгээс ойлгогдож, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордоос харагдаж байна.⁶⁴

2013 оны ОУИТБС-ын тайланд 2014 оны Газрын тосны тухай хууль, 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Ашигт малтмалын тухай хууль, Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого (58-р хуудас) зэрэг саяхан батлагдсан шинэчлэлийн талаар мэдээллийг оруулжээ. Ашигт Малтмалын Газрын албадаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэх зорилго бүхий Германы санхүүжилттэй төслийн талаар 63-64-р хуудсанд дурдсан байна. Гэхдээ шаардлагатай дагаж мөрдөх журам зэрэг одоо хийгдэж байгаа шинэчлэлийн талаар энэ хоёр хуулинд дурдаагүй байна.

Оролцогчдын санал

Зөвлөлдөх уулзалтад оролцсон, олборлох үйлдвэрлэлийн болон газрын тос, шатдаг хийн салбарын төлөөлөгч нар Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн болон Урт нэртэй хуулийн үүрэг ролийг нарийвчлан заасан тодорхойлолт байхгүй байгааг гайхаж байлаа. Тэд 2013 оны ОУИТБС-ын тайлангийн үндсэн мэдээлэлд бус, санхүүгийн тохируулга хийсэн хэсгийг хянахад илүү их цаг зарцуулсан тухай ярьж байв. Хэлэлцүүлгийн үеэр, үйлдвэрлэлийн бүх төлөөлөгч нар сүүлийн гурван жилийн хугацаанд хууль эрх зүйн орчин үе үе өөрчлөгдөж байсныг дурдаад, хууль эрх зүйн тогтолцоо болон бодит байдалд гардаг зөрүүтэй байдлын талаар илүү мэдээлэл оруулахыг шаргуу сонирхож байлаа. Иргэний нийгмийн хэд хэдэн байгууллага 2014 оны ОУИТБС-ын тайланд оруулахын тулд зохицуулах эрх зүйн орчны талаар, тухайлбал Урт нэртэй хуулийн талаар илүү мэдээлэл авах хүсэлт гаргаснаа дурдаж байв. Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгч нар “эрх зүйн тогтолцооны тодорхойлолтыг боловсруулахад идэвхтэй оролцоогүй бөгөөд энэ ажил Хараат бус хянагч-нэгтгэгчид үлдэж байгаа” гэдгийг дурдсан юм.

Үнэлгээ

Энэ шаардлага хангагдсан гэж бид үзэж байна. Эрх зүйн тогтолцоог тодорхойлох нь олборлох үйлдвэрлэлийг зохицуулах хууль, журмыг танилцуулах ажиллагааг хамарч байгаа ч хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа, ялангуяа алтны олборлолтод үлэмж нөлөөлсөн “Урт нэртэй хуулийн” (“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль) талаар илүү өргөн хүрээнд хэлэлцэх нь ОУИТБС-ын тайланд ач холбогдолтой юм. Түүнчлэн Засгийн Газрын холбогдох агентлагуудын, ялангуяа Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үүрэг ролийг илүү нарийвчлан тодорхойлох нь ашиг тустай болно. Засгийн Газар, үйлдвэрлэлийн хоорондын тоглоомын дүрмийг тодорхой болгох хэрэгсэл хэлбэрээр ОУИТБС-ын тайлангуудыг хэрэглэхийн тулд зохицуулах хууль эрх зүйн тогтолцоог болон практикт үүсэж байгаа зөрүүтэй байдлын талаар илүү иж бүрэн тодорхойлохыг ОТОАХ хүсэх боломжтой юм.

Лиценз олголт (#3.10)

Явцын баримтжуулалт

2010-2014 оны хооронд шинээр лиценз олгохыг зогсоосон учраас 2013 онд уул уурхайн лиценз (хайгуул, олборлолтын аль алины) олгоогүй боловч газрын тос, шатдаг хийн Бүтээгдэхүүн хуваах нэг гэрээг 2013 онд байгуулсан юм. Мөн 2006 оны Ашигт малтмалын тухай хууль (энэ хуулинд 2014 оны 8-р сард зөвхөн нэмэлт оруулсан) нь лиценз шилжүүлэхийг хориглосон учраас 2013 онд

⁶⁴ Хуудас 86-н” Монгол улсын уул уурхайн салбарын эдийн засгийн дүн шинжилгээ,” жишээ болгож харна уу

[ftp://ftp.repec.org/opt/ReDIF/RePEc/ibf/qjbres/qjbr-v4n4-2010/GJBR-V4N4-2010-8.pdf](http://ftp.repec.org/opt/ReDIF/RePEc/ibf/qjbres/qjbr-v4n4-2010/GJBR-V4N4-2010-8.pdf)

ямарваа лиценз шилжүүлээгүй байна.

Гэхдээ шинээр лиценз олгохыг зогсоосон тухай 2013 оны ОҮИТБС-ын тайланд дурдаагүй байв. Уул уурхайн лиценз олгох ажиллагааны талаар тус тайланд тодорхойлсон ч (хуудас 58-59), (хуудас 65) аль ч салбарт лиценз олгоход ашиглаж байгаа, техникийн болон санхүүгийн ерөнхий шалгуурын тухай, мөн практикт үүсэж болох аливаа зөрүүтэй байдлын талаар дурдаагүй байна. Мөн 2013 онд байгуулсан, газрын тос, шатдаг хийн БХГ-нд холбогдох аливаа мэдээлэл өгөөгүй байв.

Түүнээс гадна, хэдийгээр ОҮИТБС-ын Стандартад шаардаагүй боловч системүүд хэр оновчтой, үр дүнтэй байгаа тухай тайлбар зэрэг, лиценз олголтын тухай нэмэлт мэдээллийг тус тайланд оруулаагүй байв.

Оролцогчдын санал

Засгийн Газрын төлөөлөгчид “лиценз авахаар гаргасан хүсэлтийг үнэлж дүгнэхэд ашиглаж байгаа техникийн болон санхүүгийн шалгуурыг Ашигт Малтмалын Газрын вэб сайтаас олон нийт авах боломжтой⁶⁵” хэмээн мэдэгдсэн ч 2010 оноос 2014 оны хожуу үе хүртэл шинээр лиценз олгохыг зогсоосон байв. Оноо тооцох систем нь дараах бүтэцтэй бөгөөд тендерийн материалыг үнэлэхэд Ашигт Малтмалын Газар 100 оноо тооцох систем мөрдөж, санал болгосон үнэ ханшид үндэслэн 50 оноо олгож, техникийн саналд үндэслэн 50 оноо (ажилласан жилийн тоо, хүний нөөцийн чадавхи, орон нутгийн ажилчдын тоо, орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах заалтууд, техник төхөөрөмжийн өмчлөл зэргийг хамран) өгч байв. Тендерт оролцож байгаа бүх хүмүүсийн өмнө эхлээд техникийн саналуудыг үнэлж, дараа нь санхүүгийн саналын битүүмжилсэн баримтуудыг задалж байв. 2014 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Ашигт Малтмалын тухай хуулийн 49-р Зүйл нь лиценз шилжүүлэхийг зохицуулж байгаа бөгөөд энэ зохицуулалт нь бодит байдалд өөрчлөгдөж гуйваагүй талаар дурдсан байв. БХГ-г 2013 онд зөвшөөрөн баталсан журмын талаар оролцогчид аливаа санал гаргаагүй байна.

Үнэлгээ

Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. Хэдийгээр лиценз олгох журам, ажиллагааны талаар ОҮИТБС-ын тайланд товч танилцуулсан ч лиценз олгох техникийн болон санхүүгийн шалгуур, лицензийг шилжүүлэх заалтууд, газрын тос, шатдаг хийн лицензийн тендер явагдаж байгаа эсэх, зохицуулах хууль, журмууд бодит байдалд зөрчигдөж байгаа эсэх, 2010 оноос 2014 оны хооронд шинээр уул уурхайн лиценз олгохыг зогсоосон хориг мөрдөгдөж байгаа эсэх талаар мэдээлэл оруулаагүй байв. 2013 онд уул уурхайд холбоогүй байсан ч 2010 оноос 2014 оны хооронд шинээр уул уурхайн лиценз олгохыг зогсоосон хориг мөрдөгдөж байсан учир газрын тос, шатдаг хийн БХГ-г харьцуулах тохируулгын хүрээнд хамрагдсан “Чоно Петролеум” компанитай 2013 онд байгуулсан нь энэ лицензэд энэ мэдээллийг хамруулсныг харуулж байна. ОТОАХ нь ОҮИТБС-ын цаашдын тайлангууддаа эдгээр асуудлын талаар олон нийтэд олдож байгаа мэдээллийг (АМГ-ын вэб сайтад тавигдсан, техникийн болон санхүүгийн шалгуурын тодорхойлолт зэрэг мэдээллийг) авч үзэхийг хүсэх боломжтой юм.

Лицензийн бүртгэл (#3.9)

Явцын баримтжуулалт

Лицензүүдийг ил болгох тухай мэдээллийг 2013 оны ОҮИТБС-ын тайланд оруулжээ. Тус

⁶⁵http://www.AMG.gov.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=35&Itemid=53&lang=en

тайлангийн 13-р⁶⁶ Хавсралтад, Монгол улсад лиценз эзэмшигчдийн жагсаалтыг (харьцуулж тохируулсан бүх 250 компани, лицензүүдийн бүх эзэмшигч, радио-идэвхит ашигт малтмалын лиценз эзэмшигчид болон газрын тосны лиценз эзэмшигчдийг) оруулсан байв. Энэ тайлангийн 6.5.3-р хэсэг (хуудас 100) нь лиценз эзэмшиж байгаа байдалд 2013 онд гарсан өөрчлөлтүүдийг болон лицензүүдийн хугацаа дуусах/зогсоох зарим ерөнхий шалтгааныг товч танилцуулсан байв. Тус тайлангийн 19-р Хүснэгт (хуудас 36) нь хэрэгжиж байгаа, Бүтээгдэхүүн хуваах 21 Гэрээний талаар, лицензүүдийн нэрс, олгосон огноо, БХГ-г удирдах Засгийн Газрын тогтоол, лиценз эзэмшигчийн нэрс, лиценз эзэмшигчийн уугуул эх орон, лицензийн төрлийг (хайгуулын/ашиглалтын) хамруулан нарийвчлан мэдээлсэн байна. Дээр өгсөн мэдээлэл 3029 лицензийг хамарч байгаа нь харьцуулах тохируулгын хүрээнд хамрагдсан 250 компаниас илүү өргөн хүрээтэй байна. Гэхдээ 17-р диаграмм (хуудас 62) нь 2013 онд нийт 3118 лиценз (хайгуулын 1815 лиценз, ашиглалтын 1303 лиценз) хүчинтэй байсан тухай дурдсан байв. 2013 оны ОҮИТБС-ын тайланд уул уурхайн кадастрын системийг компьютерт оруулах зорилгоор Дэлхийн Банк санхүүжүүлж, 2014 онд дууссан төслийн талаар зөвхөн товч дурдсан (хуудас 63-64) байна.

Гэхдээ 2013 оны ОҮИТБС-ын тайлан нь кадастрт болон АМГ-ын ажиллуулж байгаа уул уурхайн кадастрт (төлбөргүй, бүртгүүлэлгүй орох боломжтой) холбогдох линкийг дурдалгүй, 3.9-р Шаардлагын дагуу шаардагдах, хүсэлт гаргасан, олгосон, хугацаа нь дуусах сар өдрөөс⁶⁷ бусад бүх мэдээллийг хамарч байв. Цахим тайлагнах вэб сайт⁶⁸ нь уул уурхай, газрын тос, шатдаг хийн аль алины 1438 лицензийн мэдээллийг хамарч байна. Эдгээр мэдээлэл нь зөвшөөрөл олгосон огноо, зөвшөөрлийн хугацаа дуусах огноо, зөвшөөрлийн дугаар, байршлын нэрс, талбайн хэмжээ, хамрагдаж байгаа ашигт малтмалын төрлийг хамарч байгаа ч координат, эсвэл зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан сар өдрийн тухай мэдээлээгүй байна. АМГ-ын кадастр болон Цахим тайлагналын систем нь лицензийн ижил дугаарууд ашиглаж байна.

Оролцогчдын санал

Засгийн Газрын төлөөлөгчид “лиценз авахаар хүсэлт гаргасан сар өдрийг кадастрт ил болгоогүй боловч байгууллагын дотоод хүрээнд энэ мэдээллийг авах боломжтой (гэхдээ олон нийтэд боломжгүй)” гэдгийг дурдсан юм. Лиценз олгох тухай бүрт кадастрыг шинэчилдэг. Лиценз авах хүсэлт гаргасан сар өдрийн жагсаалтыг олон нийтэд зориулан кадастрт ирээдүйд байрлуулахаар төлөвлөж байгаа ч тодорхой сар өдөр товлгоогүй бөгөөд техник туслалцааны шинэ гэрээг Дэлхийн Банктай байгуулах шаардлага гарах юм байна.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. 2013 оны ОҮИТБС-ын тайланд лицензүүдийн талаар зарим мэдээлэл өгсөн ч лиценз авахаар хүсэлт гаргасан сар өдөр, эсвэл лицензийн координатын талаар мэдээлээгүй байв. Хэдийгээр АМГ-ын ажиллуулж байгаа, газрын тос, шатдаг хий, уул уурхайн кадастрыг онлайнаар үзэх боломжтой бөгөөд энэ кадастр нь 3.9-р Шаардлагын дагуу шаардагдах, хүсэлт гаргасан, олгосон, хугацаа нь дуусах сар өдрөөс бусад бүх

⁶⁶ Хавсралт 13 нь хэдэн зуун хуудастай учир МОҮИТБС-ын вэбсайтад МОҮИТБС-ын 2013 оны тайлангаас тусад нь нийтэлсэн болно (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/2013%20Report%20annex%20EN.zip>)

⁶⁷ АМГ-ын Уул уурхай, газрын тос, байгалийн хийн кадастрыг <http://cmcs.mram.gov.mn/cmcs#cid=5> –с харах боломжтой

⁶⁸ Интернэтээр мэдээлэх вэбсайтад Google Earth-с тогтоох кадастрын мэдээлэл багтах бөгөөд <http://e-reporting.eitimongolia.mn/portalMap/1/> -с харах боломжтой

мэдээллийг агуулж байгаа ч Хавсралт 13-т оруулсан уул уурхайн болон газрын тосны лицензүүдийн жагсаалт бүрэн биш байна. Монгол дахь ОҮИТБС-ын цахим тайлангийн вэб сайт нь АМГ-ын кадастртай ижил код ашиглан, хүчинтэй бүх лицензийг олгосон огноог болон хугацаа нь дуусах сар өдрийг мэдээлж байна. Энэ нь “лиценз авах хүсэлт гаргасан сар өдрийг л олон нийт үзэх боломжгүй” гэсэн агуулгатай байна. ОТОАХ нь бүх лицензийг хамран лиценз авах хүсэлт гаргасан, лиценз олгосон, лицензийн хугацаа дуусах сар өдрийн мэдээллийг кадастрт хандан чөлөөтэй уншиж болдог болгохын тулд АМГ-тай хамтран ажиллах нь зүйтэй юм.

Гэрээг ил болгох (#3.12)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд гэрээг ил болгох талаар Засгийн Газрын бодлогыг тусгаагүй боловч гэрээг ил болгох талаар Засгийн Газрын бодлоготой нийцэхгүй байгаа тохиолдлуудыг нарийвчлан мэдээлсэн байв. Энэ тайлангийн 2.4.3 (хуудас 14), 8.4 (хуудас 112) хэсгүүд нь гэрээг ил болгохтой холбогдож байгаа бөгөөд гэрээг ил болгох Засгийн газрын бодлогын талаар Засгийн газрын төрөл бүрийн байгууллагууд (Уул уурхайн Яам, Газрын Тосны Газар), компаниудын хооронд тодорхойгүй байдал үүссэнтэй холбогдож байна. Энэ мэдээлэл нь зөвхөн газрын тос, шатдаг хийн БХГ-г хамарч, уул уурхайн гэрээнүүдийг хамраагүй байв. Уул уурхайн гэрээг ил болгох тухай Засгийн газрын бодлогын талаар 2013 оны ОҮИТБС-ын тайланд тодорхой мэдээлээгүй байна. Тус тайланд “Газрын тосны БХГ-г болон газрын тосны хайгуул, ашиглалтын лицензийг ил болгохтой холбогдсон заавал биелүүлэх заалт байхгүй байна” хэмээн дурдсан (хуудас 64) байв. Хэдийгээр 2012 оноос хойш Оюу Толгойн вэб сайтад Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын Гэрээ нийтлэгдсэн боловч бодит практикт ил болгосон аливаа гэрээний талаар тус тайланд дурдаагүй байна. Түүнээс гадна, OpenOil вэбсайтад ⁶⁹ газрын тос, шатдаг хийн гурван, БХГ-г нийтэлсэн байв. Гэхдээ 2014 оны жилийн ажлын тайланд (хуудас 11) Оюу Толгойн Гэрээ нийтлэгдсэн тухай дурдсан байв.

Хэдийгээр ОҮИТБС-ын Стандарт энэ талаар шаардаагүй боловч 2013 оны ОҮИТБС-ын тайлан нь аливаа гэрээ, лицензийг ил болгосон талаар дурдаагүй, нийтлэгдсэн гэрээнүүдийг хэрхэн олж унших талаар мэдээлээгүй байна.

2013 оны ОҮИТБС-ын тайланд олон нийтийн гэрээнүүдийн тухай мэдээллийг бас оруулсан байв. Хавсралт 14 (хуудас 114) нь орон нутгийн удирдах байгууллагатай байгуулсан 153 гэрээний тухай мэдээлэл өгч, харьцуулах тохируулгын хүрээнд хамрагдсан 250 компанийн талаар дүгнэлт гаргажээ. Энэ мэдээлэл нь:

- Хамтран ажиллах 22 гэрээ,
- Нийгмийн хариуцлагын 27 гэрээ,
- Орд ашиглах 37 гэрээ,
- Байгаль орчныг нөхөн сэргээх 9 гэрээг хамарч байв.

Гэрээг ил болгох талаар ОҮИТБС-ын тайланд өгсөн мэдээллийн мөрөөр ОТОАХ ажилласан байна. 2015 оны 1-р сард байгуулагдсан, гэрээг ил болгох Ажлын Хэсэг нь Газрын Тосны Газартай хамтран ажиллаж, 2014 онд нэмэлт оруулсан Газрын Тосны тухай хуулийн хүрээнд боловсруулсан БХГ-ний шинэ загвараас нууцлалын тухай заалтыг амжилттай хасаж чаджээ. Газрын Тосны Газар гэрээг ил болгох байр суурьтай байсан ч хуучин БХГ-үүдийн нууцлалын заалтууд нь тэдгээр гэрээг ил болгох боломжийг Засгийн Газрыг олгохгүй байсан” хэмээн мэдээлсэн юм. Мөн 1990-д онд байгуулагдсан, Монгол улсад ашиггүй, санхүү, мөнгөний болзол, нөхцлүүдтэй байсан, хамгийн хуучин БХГ-үүдийн болзол нөхцлүүдийг ил болговол харьцангуй шинэ БХГ байгуулах хүсэлт гаргах хуулийн

⁶⁹ <http://repository.openoil.net/wiki/Mongolia>

этгээдүүд тэдгээр хуучин болзол, нөхцлүүдтэй ижил болзол, нөхцлүүдийг шаардаж болзошгүй учир гэрээг ил болгохын болзошгүй нөлөөллийн талаар санаа зовниж байгаа тухайгаа Газрын Тосны Газар Ажлын Хэсэгт илэрхийлсэн байв. ОТОАХ болон гэрээг ил болгох Ажлын Хэсэг нь газрын тос, шатдаг хийн БХГ байгуулсан бүх компанитай уулзаж, тэдний БХГ-г ил болгох талаар тэдгээр компани бичгээр бэлтгэсэн зөвшөөрөл авах хүсэлт тавьж байна.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. ОҮИТБС-ын тайлан нь гэрээг ил болгох талаар Засгийн Газрын тууштай бодлогыг тодорхой дурдаагүй ч Засгийн Газрын төрөл бүрийн агентлагууд баримталж байгаа эсрэг тэсрэг хандлагын талаар дурджээ. Гэхдээ тус тайлан нь гэрээг ил болгох бодит практикийг баримтжуулаагүй бөгөөд Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын Гэрээ наад зах нь гурван өөр вэб сайтад (Оюу Толгойн, Туркойс Хилл болон Рио Тинтогийн) нийтлэгдсэн боловч энэ талаар баримтжуулаагүй байв. Гэрээг ил болгох талаар Засгийн Газрын бодлогыг тодорхой байлгах саналыг ОҮИТБС-ын тайланд дэвшүүлсэн бөгөөд энэ талаар идэвхтэй ажиллаж, 2015 онд боловсруулсан БХГ-ний шинэ загвараас нууцлалын заалтуудыг хасуулсан юм.

Бенефициар эзэмшлийг ил болгох (#3.11)

Явцын баримтжуулалт

Бенефициар эзэмшлийг шалгах эхний үе шатны хувьд 2013 оны ОҮИТБС-ын тайлан нь компаниудын хууль ёсны эзэмшлийн талаар мэдээлэл авах шаардлагыг тусгажээ. 2014 оны 3-р сарын 11-нд хийсэн Олон Талын Оролцоот Ажлын Хэсгийн (ОТОАХ) хурал нь Үнэт Цаасны тухай Монгол улсын хуулийн 4.1.26 заалтыг тусгахын тулд бенефициар эзэмшлийг тодорхойлох хэрэгтэй байгааг зөвшөөрсөн юм.

Энгийн асуулга ашиглаж, Олон Талын Оролцоот Бүлэг (ОТОБ) нь уул уурхайн, эсвэл газрын тосны лицензүүдийн 5% болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа аливаа компани, хуулийн этгээдээс бенефициар эзэмшлийн тухай мэдээллийг асуужээ. Тус судалгаа сайн дурынх байсан ч, харьцуулах тохируулгад хамрагдсан 250 компанийн 215 нь өөрсдийн хувьцаа, хувьцаа эзэмшигчдийн талаар мэдээлэл өгч, бас нэлээд тохиолдолд бенефициар эзэмшигчдийнхээ талаар мэдээлэл өгсөн юм. Гэхдээ энэ нь бенефициар эзэмшлийн тухай бүрэн мэдээлэл биш бөгөөд зарим тохиолдолд мэдээлэл нь зөвхөн хууль ёсны эзэмшигчдэд л холбоотой мэдээлэл байв. 215 компанийн нийт 368 хувьцаа эзэмшигчийг тогтоосон бөгөөд тэдний 215 нь хувь хүмүүс, 144 нь аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд, 13 нь төвийн болон орон нутгийн удирдах байгууллагын ажилтнууд байв. Тайлан гаргаж байгаа компаниудаас авсан хариултыг 2013 оны ОҮИТБС-ын тайлангийн Хавсралт-22 (хуудас 207-220) -т оруулжээ. Хариултын дүнг Монголын ОҮИТБС-ын вэб сайтад⁷⁰ интерактив инфографик мэдээлэл болгон байрлуулжээ. ОТОБ нь бенефициар эзэмшлийн тухай ижил асуултуудыг 2014 оны ОҮИТБС-ын харьцуулах тохируулгад байршуулсан бөгөөд үр дүн, хамрах хүрээг сайжруулна хэмээн найдаж байна.

2015 оны 5-р сард УИХ-аар баталсан Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай шинэ хууль нь бенефициар эзэмшлийн тухай мэдээллийг олон нийтийн бүртгэлд оруулах тухай, өмнөх төслүүдэд байсан заалтыг оруулаагүй юм. Зөвхөн тусгай хүсэлт гаргасан нөхцөлд л мэдээлэл авч болох бөгөөд мэдээлэл өгөхгүй байх үндэслэлүүдийг бас дурджээ. Гэхдээ Ашигт малтмалын нөөцийн салбарын ил тод байдлын тухай хуулийн одоогийн төсөл нь бенефициар эзэмшлийн тухай ил болгохыг тус салбарын компаниудаас шаардсан заалтуудыг агуулж байна.

⁷⁰ <http://www.Монголын ОҮИТБCongolia.mn/en/beneficial-owners>

2014 оны ОУИТБС-ын тайландаа уул уурхай, шатдаг хий, газрын тосны компаниудад зориулан, тайлан гаргах загваруудын бүтэц хэсэг байдлаар хууль ёсны өмчлөлийн гурван түвшинд мэдээлэл авах хүсэлтийг ОТОАХ тавьсан юм. Хараат бус хянагч болох аудитын KPMG компани 2015 оны 7-р сарын 7-нд болсон анхны сургалтын үеэр эзэмшлийн гурван түвшнийг судлахаар ОТОАХ-тэй тохиролцсон юм. Эхний түвшинд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн наад зах нь 5%-г, хоёр дахь түвшинд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн наад зах нь 25%-г хамруулж, гурав дахь түвшинд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн наад зах нь 51%-н түвшнийг⁷¹ хамруулахаар болжээ. Дараах хуваарь, зааварчилгыг бэлтгэхийн тулд тайлан гаргах загварын өмнөх “нэмэлт мэдээлэл” хэсгийг 2014 оны ОУИТБС-ын тайланд зориулан шинэчилжээ:

- (i) Давуу эрхтэй эзэмшлийн тухай тодорхойлолт,
- (ii) ОУИТБС-ын туршилтын тайлангийн загвар,
- (iii) Хувьцаа эзэмшлийн гурван-үет босгыг тодорхойлох (шаардлагатай үед),
- (iv) Вэб хуудсын линк холбоос (нийтэд-зориулан жагсаасан компанид шаардлагатай үед)

Оролцогчдын санал

Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгч “ОУИТБС-ын Стандартын дагуу ил болгох шаардлага нэмэгдэж байгаа нөхцөлд ингэж ил болгох хууль эрх зүйн үндэслэл хангалттай биш байна” хэмээн дурдаж байв. “ОУИТБС-ын тодорхой эрх зүйн тогтолцоо байгуулахын тулд, ялангуяа 2016 оны 6-р сарын сонгуулиас өмнө ОУИТБС-ын хуулийг батлах магадлалгүй байгаа учраас Засгийн Газрын өндөр түвшний ажилтнуудыг оролцуулах хэрэгтэй байгааг” дурдаж байв. Хамгийн их асуудалтай байгаа нь бенефициар эзэмшил болон гэрээнүүдийг ил болгох асуудлууд байв.

Үнэлгээ

Энэ шаардлага биелсэн гэж бид үзэж байна. Хэдийгээр бенефициар эзэмшлийг ил болгохыг шаардаагүй ч 2013 оны ОУИТБС-ын тайлан нь 215 компанийн нийт 368 хувьцаа эзэмшигчийг тогтоосон бөгөөд тэдний 215 нь хувь хүмүүс, 144 нь аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд, 13 нь төвийн болон орон нутгийн удирдах байгууллагын ажилтнууд байв. Хариултын дүнг Монгол дахь ОУИТБС-ын вэб сайтад интерактив инфографик мэдээлэл болгон байрлуулжээ. Гэхдээ энэ нь бенефициар эзэмшлийн тухай бүрэн мэдээлэл биш бөгөөд зарим тохиолдолд мэдээлэл нь зөвхөн хууль ёсны эзэмшигчдэд л холбоотой мэдээлэл байв. Гэвч бид энэ шаардлагыг биелсэн хэмээн үзэж байна. Учир нь ОТОАХ давуу эрхтэй эзэмшлийн тухай асуудлыг тодорхой авч үзэн, ийм мэдээллийг ил болгохоор дэс дараатай ажиллаж байгаа юм.

Төрийн байгууллагын оролцоо (#3.6.а ба #3.6.с)

Явцын баримтжуулалт

Монгол улсын олборлох үйлдвэрлэлд төр оролцож байгаа нь орлогыг материаллаг түвшнээс (10,000 төгрөг) дээгүүр нэмэгдүүлж байна. Монголын төрийн өмчит 99 компанийн наад зах нь 11 нь ноогдол ашиг, татвар, ашигт малтмал олборлосны роялти татвар, бусад төлбөрийг Засгийн Газарт төлж байна. Гэвч 2013 оны ОУИТБС-ын тайлан нь Засгийн газар хувь эзэмшиж байгаа 99 компанийн зөвхөн 11 компанийн эзэмшлийн хэлбэр, өөрчлөлтийг 2013 оны хугацаанд ил болгосон юм. ОТОАХ-ийн 2014 оны хурлуудын тэмдэглэлээс үзэхэд Засгийн Газар хувь эзэмшиж байгаа бүх 99 компанийн хувьд энэ мэдээллийг ил болгоход саад, хориг байгаа тухай аливаа хэлэлцүүлэг байхгүй байна. Төрийн өмчит компаниуд (ТӨК) болон Засгийн Газар хоорондын санхүүгийн

⁷¹ KPMG-н ОУИТБС-ын явцын тайлангийн Хавсралт 1 болон 5-н Сэдэв 3.4

харилцааны зөвхөн хагасыг 2013 оны ОУИТБС-ын тайланд мэдээлжээ. 2013 оны ОУИТБС-ын тайланд төрийн оролцоотой 99 компанийг дурдаж (хуудас 45), төрийн өмчит компаниудын тухай нарийвчилсан мэдээллийг 3.6 Хэсэгт (хуудас 45-52) оруулжээ. Мөн энэ хэсэгт төрийн оролцооны категори ангиллыг 25-р Хүснэгтэд (хуудас 46)) мэдээлжээ. Түүнчлэн төр хувь эзэмшиж байгаа, уул уурхайн 11 компанийн жагсаалтыг төрийн эзэмшлийн хувь, ашигт малтмалын төрөл, байршлын хамт (хүснэгт 26, хуудас 46) мэдээлсэн байв. Гэхдээ ОУИТБС-ын тайлан нь төрийн өмчит бүх 99 компанийн бүрэн жагсаалтыг оруулж чадаагүй байна. Тус тайлангийн 3.6.1.1.3 Хэсэг нь (хуудас 48-51) харьцуулах тохируулгын хүрээнд хамрагдсан Төрийн өмчит 11 компанийн тухай мэдээлэл өгчээ. Төрийн өмчит компаниуд болон төрийн хоорондын сангуудын шилжүүлгийг удирдах журам, практик, байгаа орлого, дахин хөрөнгө оруулалт болон гурав дахь талын санхүүжилтийг тус Тайланд тодорхойлоогүй байна.

Төрийн өмчит компаниудын түвшин болон салбарын эзэмшлийг зөвхөн хэсэгчилсэн байдлаар тодорхойлжээ. Мөн төрийн өмчит тэдгээр компанийн бүх салбарын бүрэн жагсаалтыг оруулаагүй байна. 3.6.1.1.3 Хэсэг (хуудас 48-51) нь харьцуулах тохируулгын хүрээнд хамрагдсан төрийн өмчит 11 компанийн тухай мэдээлэл өгч, Хавсралт 15 (хуудас 167-169) нь төрийн өмчит 11 компанийн Захирлуудын зөвлөлийн гишүүдийн нэрсийг оруулжээ.

2013 оны ОУИТБС-ын тайланд зээлийн болон зээлийн баталгааны тухай мэдээлэл оруулаагүй байв. Төрийн өмчит компаниуд, эсвэл олборлох үйлдвэрлэлийн бусад компаниудад олгосон зээлийн болон зээлийн баталгааны тухай мэдээлэл байхгүй байна. 2013 онд Эрдэнэс Таван Толгойд Монгол улсын Хөгжлийн Банкнаас 200 сая ам долларын зээл⁷² олгосон тухай дурдаагүй, стратегийн орд газруудад төр эзэмшиж байгаа 34%-ийг Засгийн Газар хэрхэн санхүүжүүлж байгаа хэлбэрийн талаар 47, 49-р хуудсанд дурдаагүй байв.

Хэдийгээр ОУИТБС-ын Стандарт шаардаагүй боловч мэдээлэл оруулсан төрийн өмчит 11 компанийн эзэмшлийн өөрчлөлтийн талаар мэдээлээгүй, оруулсан мэдээлэл нь шилжүүлгийн болзол, нөхцлийн талаар дурдаагүй байв.

Оролцогчдын санал

Засгийн Газрын төлөөлөгчид “улсын өмчийг удирдах ажлыг хариуцах үүрэгтэй Төрийн Өмчийн Хороо бол төрийн өмчит компаниудын талаар мэдээлэл, тухайлбал төрийн өмчит компаниудын болон Засгийн Газар хоорондын санхүүгийн харилцааг удирдах дүрэм, практикийн талаар мэдээлэл хадгалж байх ёстой агентлаг мөн” хэмээн дурджээ. Энэ мэдээллийг ил болгоход эрх зүйн саад хориг байгаа эсэх талаар дурдаагүй байв. Ерөнхийдөө бол, санхүүгийн харилцааг удирдах дүрэм, практикийг Компанийн тухай хуулиар зохицуулна хэмээн дурджээ. Хараат бус хянагч-нэгтгэгч нь “Төрийн өмчит компаниудын талаар мэдээлэл авахад саад учруулдаг байсан Засгийн Газрын хүнд суртлаас шалтгаалан төрийн оролцооны тухай мэдээлэл орхигдсон” хэмээн дурдсан байв.

Үнэлгээ

Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. Олборлох үйлдвэрлэлд төр хэрхэн оролцох талаар ОУИТБС-ын тайланд авч үзсэн боловч 3.6 Шаардлагын дагуу зөвхөн хязгаарлагдмал мэдээллийг ил болгосон байв. Тус тайланд Засгийн Газар (эсвэл түүний салбар байгууллагууд) хувь эзэмшиж байгаа бүх 99 компанийн жагсаалтыг оруулаагүй, төрийн өмчит компаниудын болон Засгийн Газар хоорондын санхүүгийн харилцааг удирдах дүрэм, практикийн

⁷² Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн 2014 оны 5-р сард гаргасан “Эрдэнэс таван толгой”-н эдийн засгийн үнэлгээг 6-р хуудаснаас, мөн http://eri.mn/ERI_TT.pdf-с харах боломжтой. Мөн ОУБС-н (2014 оны 3-р сар), Зүйл IV Зөвлөгөө (Хуудас 6)-г <https://www.imf.org/external/pubs/ft/scr/2014/cr1464.pdf>-с харна уу.

талаар мэдээлээгүй, эсвэл олборлох үйлдвэрлэлийн компаниудад Засгийн Газраас олгосон зээлийн болон зээлийн баталгааны тухай мэдээлэл байхгүй байна. Тус салбарт төрийн гүйцэтгэх үүрэг өргөн хүрээтэй бөгөөд төрийн өмчит компаниуд болон олборлох үйлдвэрлэлд төсвөөс гадуур олгох төсвийн санхүүжилт үлэмж хэмжээтэй байгаа учраас төрийн оролцооны талаар бүрэн үнэлэлт дүгнэлт өгөх нь Монгол улсын хувьд чухал байгаа юм.

Ил болгосон мэдээллийн цаг хугацаа, бүрэн байдал, найдвартай байдлын үнэлгээ (#2)

- Цаг хугацаа: 2013 оны ОҮИТБС-ын тайланг 2014 оны 12-р сард хэвлэж, 2015 оны 1-р сарын 13-нд Үндэсний Зөвлөл баталжээ. 2015 оны 1-р сараас хойш ажиллуулж байгаа цахим тайлагналын систем нь мэдээллийг ил болгох хугацааг сайжруулсан бөгөөд 2015 оны 3-р сарын 31-ны байдлаар 987 компани, Засгийн Газрын 35 газар, хэлтсүүд 2014 оны харьцуулах тохируулгад ашигласан, ОҮИТБС-ын мэдээллээ ил болгосон юм.
- Бүрэн байдал: лицензүүдийн тухай болон төрийн оролцооны тухай мэдээллийг бүрэн ил болгоогүй байна.
- Найдвартай байдал: холбогдох нөхцөл байдлын мэдээлэл нь тууштай биш ч 2013 оны ОҮИТБС-ын тайланд оруулсан мэдээлэл нь Засгийн Газрын вэб хуудсуудад байгаа бусад эх үүсвэрийн мэдээлэлтэй нийцэж байна. Хэдийгээр нөхцөл байдлын мэдээллийн найдвартай байдлыг ОТОБ авч хэлэлцээгүй бололтой ч мэдээллийн найдвартай байдалд оролцогч нар санаа зовж байгаа тухай Олон улсын Ажлын Албанд мэдэгдээгүй байна.

Хүснэгт 2 – Үнэлгээний хураангуй хүснэгт: Гэрээ байгуулж, лиценз олгосон тухай

ОҮИТБС-ын шаардлага	Гол дүгнэлт	ОҮИТБС-ын шаардлагыг хангасан эсэх тухай Баталгаажуулагчийн зөвлөмж ('Шаардлагатай' заалтуудыг бөглөнө.)
Эрх зүйн тогтолцоо (#3.2)	2013 оны ОҮИТБС-ын тайлан нь холбогдох хууль, журмууд, санхүүгийн журмыг ил болгосон ч тус салбарын хөгжилд үлэмж нөлөөлсөн хэд хэдэн чухал хуулийг орхигдуулсан байна.	Шаардлагыг биелүүлсэн.
Лиценз олголт (#3.10)	Уул уурхайд энэ шаардлага 2013 онд холбоотой биш байсан байж болох ч 2010 оноос 2014 онд уул уурхайн лиценз олгохыг зогсоосон учраас энэ хоригийн талаар тайлбар байхгүй, газрын тос, шатдаг хийнд лиценз олгох процессын тухай тайлбарлаагүй, 2014 онд өөрчлөлт оруулсан Ашигт малтмалын тухай хуулийн дагуу лиценз олгох процессын тухай тайлбарлаагүй байна.	Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.
	3.9-н дагуу шаардагдах бусад бүх мэдээллийг АМГ-ын кадастраас болон цахим тайлагналын системээс авч болох ч уул уурхай, газрын тос,	

Лицензийн бүртгэл (#3.9)	шатдаг хийн лиценз авах хүсэлт гаргасан сар өдрийн талаар мэдээлэл байхгүй. Бүх лицензийг авах хүсэлт гаргасан, лиценз олгосон, хугацаа нь дуусах сар өдрийн талаар мэдээллийг кадастраас чөлөөтэй авдаг болгохын тулд АМГ-тай ОТОАХ хамтран ажиллах нь зүйтэй байна.	Нэлээд ахиц гарсан ч энэ заалт биелээгүй.
Гэрээг ил болгох (#3.12.b)	ОҮИТБС-ын тайланд гэрээний ил тод байдал, Засгийн Газрын тогтвортой бус бодлогын бодит практикийн талаар санал гаргажээ. Засгийн Газрын бодлогыг тодорхой болгох, нууцлалын заалтуудыг арилгахын тулд газрын тос, шатдаг хийн БХГ-ний загварт нэмэлт оруулахын тулд ОТОАХ ажилласан байна.	Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.
Бенефициар эзэмшлийг ил болгох (#3.11)	Бенефициар эзэмшлийн мэдээллийг ил болгох талаар ОТОБ-н хэд хэдэн хурал дээр ОТОАХ авч үзэн, хууль ёсны эзэмшлийн тухай мэдээллийг ил болгох анхны ажлыг (энэ ажил нь бенефициар эзэмшлийн үлэмж мэдээллийг ил болгожээ) 2013 оны ОҮИТБС-ын тайланд хийжээ.	Шаардлагыг биелүүлсэн.
Төрийн оролцоо (#3.6.a and #3.6.c)	2013 оны ОҮИТБС-ын тайлан нь төр хувь эзэмшиж байгаа 99 компанийн зөвхөн 11 компанийн төрийн оролцоог мэдээлжээ. Энэ тайлан нь төр, төрийн өмчит компаниуд хоорондын санхүүгийн харилцааг удирдах дүрэм, практикийг тайлбарлаагүй, төрийн өмчит компаниудад олгосон зээлийн болон зээлийн баталгааны тухай мэдээлээгүй байна.	Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.

Ерөнхий үнэлгээ:

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.

Баталгаажуулагчийн зөвлөмж:

- ОТОАХ нь Засгийн Газар, үйлдвэрлэлийн хоорондын аливаа үл ойлголцлыг тодорхой болгох хэрэгсэл маягаар зохицуулах тогтолцооны болон практикт үүсдэг зөрчлийн тайлбарыг ОҮИТБС-ын тайлангуудад ашиглаж болох байв. Энэ хүсэлтийг үйлдвэрийн хэд хэдэн оролцогч нар шаргуу гаргаж байсан юм. Хуулиудыг практикт хэрэглэх явдлыг тодорхой болговол ОҮИТБС-ын тайлангуудыг ашиглан хөрөнгө оруулалтыг дэмжих хэрэгсэл болгох боломжтой юм.
- ОТОАХ нь уул уурхайн лиценз олголтын хоригийг зогсоосноос хойшхи жилүүдийг хамруулан ОҮИТБС-ын цаашдын тайланд лиценз олгох явцын техникийн болон санхүүгийн шалгуурын талаар олон нийт унших боломжтой мэдээллийг оруулж байх нь зүйтэй юм.
- Бүх лицензийг хамран лиценз авах хүсэлт гаргасан, лицензийг олгосон, хугацаа нь дуусах сар өдрийн мэдээллийг кадастрт хандан чөлөөтэй уншиж болдог болгохын тулд АМГ-тай ОТОАХ хамтран ажиллах нь зүйтэй юм.
- Дотоодын улс төрд үлэмж маргаан үүсгэдэг асуудал болсон учраас төр болон төрийн өмчит компаниудын (зээлийг хамруулан) хоорондын санхүүгийн харилцааг зохицуулах журам, практикийн талаар ОТОАХ авч хэлэлцэх нь зүйтэй. 2012 оноос хойш үлэмж нэмэгдсэн, төсвөөс гадуурх төлбөрийн үүрэг хариуцлагын талаар олон нийтийн хяналтыг сайжруулах хэрэгсэл

байдлаар ОҮИТБС-ын тайланг ашиглах нь зүйтэй юм.

2. Хяналт ба олборлолт

2.1 Танилцуулга

Энэ хэсэгт хайгуул, олборлолт, экспортод холбогдох ОҮИТБС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулав.

2.2 Үнэлгээ

Олборлох сектор, хайгуулын ажиллагааны товч тодорхойлолт (#3.3)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд олборлох үйлдвэрлэлийн талаар товч танилцуулжээ. ОҮИТБС-ын тайлан нь уул уурхайн салбарын (хуудас 25-31) болон газрын тос, хийн салбарын (хуудас 31-37) товч мэдээлэл оруулжээ. Энэ мэдээлэл нь ашигт малтмалын нөөцийн тооцоо, олборлолт явуулж буй үндсэн уурхайнууд, БХГ-г хамарч байв. Мөн гар аргын болон жижиг уурхайн ажиллагааны талаар (хуудас 30-31) мэдээлэл өгч, уул уурхайн хайгуулын томоохон ажлуудын тухай мэдээлэл (хуудас 31) болон газрын тос, хийн хайгуулын талаар (хуудас 32-33) мэдээлэл оруулжээ. 6.5 Хэсэгт (хуудас 98-99) газрын тос, хийн хайгуулын талаар дурдалгүй, уул уурхайн хайгуулын хамгийн том лиценз эзэмшигчдийг товч танилцуулжээ.

Оролцогчдын санал

Зөвлөлдөх уулзалтад оролцсон үйлдвэрлэлийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгч нар 2013 оны ОҮИТБС-ын тайланд дурдсан олборлох үйлдвэрлэлийн товч танилцуулгын талаар тодорхой санал илэрхийлээгүй байв. Албан бус тэдгээр үйл ажлын тухай тайлбарт ОҮИТБС-ын Стандартын шаардлагаас илүү мэдээлэл өгсөн ч тухайн үйл ажлууд явагдаж байгаа салбарын хувьцаа эзэмшлийн тооцоог оруулаагүй байна.

Үнэлгээ

Энэ шаардлага биелсэн гэж бид үзэж байна.

Олборлолтын мэдээлэл (#3.5.а)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд олборлолтын тухай зөвхөн хэсэгчилсэн мэдээлэл оруулсан байв. Уурхайн олборлолтын тухай мэдээлэл (хуудас 37) болон газрын тос, шатдаг хийн мэдээллийг (хуудас 38) оруулсан бөгөөд уул уурхайн энэ мэдээлэл нь олборлосон ашигт малтмалын хэмжээг харуулсан ч (Хүснэгт 20, хуудас.37) олборлолтын хэмжээг мэдээлээгүй байв. Ашигт малтмалын бүтээгдэхүүн (түүхий тосыг хамруулаагүй) бүрээр олборлолтын хэмжээг төгрөгөөр тооцсон мэдээллийг зөвхөн харьцуулах тохируулгад хамрагдсан компаниудыг (бүх компанийг хамраагүй) хамран бэлтгэж 44-р Хүснэгтэд (хуудас 87) жагсаажээ. Газрын тос, шатдаг хийн хувьд, газрын тосны нийт олборлолтын хэмжээг график хэлбэрээр харуулсан ч графикийн харуулах боломж бага, олборлолтын тоон үзүүлэлт байхгүй учир олборлолтын нийт хэмжээг мэдэх боломжгүй байна. Газрын тосны олборлолтын хэмжээг бас ил болгоогүй бөгөөд ОҮИТБС-ын Стандартад шаардаагүй боловч, олборлолтын талаар ил болгосон тоон үзүүлэлтүүд нь сум, аймгаар харуулалгүй, улсын нэгдсэн хэмжээг л харуулсан байв.

Оролцогчдын санал

Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгч “Олборлолтын хэмжээг долоо хоног бүрээр, мөн Монголд олборлосон 15 бүтээгдэхүүний өртгийн мэдээллийг АМГ мэдээлж байгаа бөгөөд хэрвээ 2013 оны ОҮИТБС-ын тайланд ийм мэдээлэл оруулаагүй бол алдаа гарсан байх” хэмээн үзэж байв. Олборлолтын хэмжээг тодорхойлох хэлэлцүүлгийн үеэр “ашигт малтмалын олборлолтын зардал нууц байсан, харин худалдах үнэ нь ил байсан” хэмээн оролцогчид дурдаж байв. 2015 оноос эхлэн нүүрс, төмрийн хүдрийн роялти татварын хэмжээг гэрээний үнээр тооцож байгаа бол бусад бүх бүтээгдэхүүний роялти татварыг жишиг үнэ ханшид үндэслэн тогтоож байна. Иймээс олборлолтын мэдээллийг ил болгоход аливаа саад харагдахгүй байна. Монгол улсын үндсэн бүтээгдэхүүний борлуулалтын үнэ доогуур байгаа (тухайлбал, Австралийн FOB үнийн талаас бага үнээр нүүрсээ Монгол улс худалдаж байна) учраас олборлолтын хэмжээг тооцоход олон улсын жишиг үнийг ашиглах нь тохиромжгүй хэмээн оролцогчид санал нийлсэн юм.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. ОҮИТБС-ын тайланд олборлосон ашигт малтмалын хэмжээг ил болгосон ч түүхий тосны хэмжээг мэдээлээгүй байв. Нийт олборлолтын хэмжээг тус тайланд мэдээлээгүй бөгөөд зөвхөн харьцуулах тохируулгад хамрагдсан компаниудын олборлолтын хэмжээг мэдээлсэн байв. Иймээс ОҮИТБС-ын тайлангаас хавьгүй ойр давтамжтайгаар (долоо хоног тутам) ийм мэдээлэл гаргаж байгаа АМГ-ын мэдээллийг ОҮИТБС-ын цаашдын тайлангуудад оруулж байхыг ОТОАХ хүсэх боломжтой юм.

Экспортын мэдээлэл (#3.5.b)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд экспортын талаар зөвхөн хэсэгчилсэн мэдээлэл оруулсан байв. Экспортын хэмжээ, өртгийг нүүрс, зэс, төмрийн хүдэр, түүхий тосоор (хуудас 39-40) тооцсон байв. Молибден, алт, вольфрам, цайр, давсны олборлолтын хэмжээг (дээр) мэдээлсэн боловч эдгээр ашигт малтмалын экспортын талаар мэдээлээгүй байна. Зөвхөн харьцуулах тохируулгад хамрагдсан компаниудын (бүх компанийг хамруулаагүй) олборлолтын хэмжээ, борлуулалтын өртгийг (түүхий тосыг хамруулаагүй) ашигт малтмалын төрлөөр Хүснэгт 44 (хуудас 87)-т жагсаасан байв. Гэхдээ эдгээр борлуулалт нь экспорттой ижил эсэх нь тодорхойгүй (ижил байх магадлалгүй) байгаа юм. Олборлосон дулааны нүүрсний зарим хэсгийг экспортлолгүй, дотоодын цахилгаан станцуудад борлуулсан баримт байгааг бид энд онцолж байна. Иймээс борлуулалтын болон экспортын тоон үзүүлэлтүүд зөрөх нь аргагүй. Ашигт малтмалын нийт экспортын өртөг болон нийт газрын тос, шатдаг хийн экспортын хэмжээг Хүснэгт 14 (хуудас 40)-т оруулсан ч ашигт малтмал бүрээр задалж мэдээлээгүй байв. ОҮИТБС-ын Стандартад ингэж шаардаагүй боловч, энэ мэдээллийг ашигт малтмалын гарал үүслийн бүс нутгаар задаргаа хийлгүй үлдээжээ.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. ОҮИТБС-ын тайлан нь экспортод гаргасан ашигт малтмалын хэмжээ, өртгийн талаар зөвхөн хэсэгчилсэн мэдээлэл оруулжээ. Энэ тайлан нь Монголд олборлосон 15 төрлийн ашигт малтмалын 11-г орхигдуулсан бөгөөд борлуулсан өртгийн мэдээлэл нь экспортынх уу, эсвэл дотоодын борлуулалтыг хамарсан нийт борлуулалтынх уу гэдэг нь тодорхойгүй байна. Нийт экспортын хэмжээг тус тайланд мэдээлээгүй бөгөөд зөвхөн харьцуулах тохируулгад хамрагдсан компаниудын мэдээллийг оруулсан байв. Иймээс энэ мэдээллийг АМГ, эсвэл Монгол Банкнаас авч ОҮИТБС-ын цаашдын тайлангуудад оруулж байхыг ОТОАХ хүсэх боломжтой юм.

Ил болгосон мэдээллийн цаг хугацаа, бүрэн байдал, найдвартай байдлын үнэлгээ (#2)

- Цаг хугацаа: 2013 оны ОҮИТБС-ын тайланг 2014 оны 12-р сард хэвлэж, 2015 оны 1-р сарын 13-

нд Үндэсний Зөвлөл батлав.

- Бүрэн байдал: олборлолт, экспортын өгөгдлийн тухай мэдээллийг бүрэн ил болгоогүй, үндсэн ашигт малтмалын хэмжээ, өртгийн мэдээллийг оруулаагүй байна.
- Найдвартай байдал: холбогдох нөхцөл байдлын мэдээлэл нь тууштай биш ч 2013 оны ОҮИТБС-ын тайланд оруулсан мэдээлэл нь Засгийн Газрын вэб хуудсуудад байгаа бусад эх үүсвэрийн мэдээлэлтэй нийцэж байна. Хэдийгээр нөхцөл байдлын мэдээллийн найдвартай байдлыг ОТОБ авч хэлэлцээгүй бололтой ч мэдээллийн найдвартай байдалд холбоотойгоор оролцогч нар санаа зовж байгаа тухай аливаа мэдээлэл Олон Улсын Ажлын Албанд мэдэгдээгүй байна.

Хүснэгт 3 – Үнэлгээний товч хүснэгт: Хяналт ба олборлолт

ОҮИТБС-ын шаардлага	Гол дүгнэлт	ОҮИТБС-ын шаардлагыг хангасан эсэх тухай Баталгаажуулагчийн зөвлөмж ('Шаардлагатай' заалтуудыг бөглөнө.)
Хайгуулын ажиллагааг хамарсан, олборлох салбарын товч танилцуулга (#3.3)	2013 оны ОҮИТБС-ын тайланд олборлох үйлдвэрлэлийг болон хайгуулын томоохон ажлуудыг нарийвчлан тодорхойлжээ.	Шаардлагыг биелүүлсэн
Олборлолтын мэдээлэл (#3.5.a)	ОҮИТБС-ын тайланд уул уурхайн олборлолтын хэмжээг мэдээлсэн ч газрын тос, хийн олборлолтыг мэдээлээгүй. Зөвхөн харьцуулах тохируулгад хамрагдсан компаниудын олборлолтын өгөгдлийг нийт дүнгээр мэдээлсэн ч харьцуулах тохируулгын материаллаг түвшний босго доогуур учраас олборлолтын ихэнхийг хамарч байна.	Нэлээд ахиц гарсан ч энэ заалт биелээгүй.
Экспортын мэдээлэл (#3.5.b)	Ашигт малтмалын борлуулалтын тухай мэдээлэл нь Монголд олборлосон 15 бүтээгдэхүүнээс зөвхөн дөрвийг хамарч, борлуулалт нь экспортод холбоотой эсэх нь тодорхойгүй байна.	Нэлээд ахиц гарсан ч энэ заалт биелээгүй.
Ерөнхий үнэлгээ: Нэлээд ахиц гарсан ч энэ заалт биелээгүй.		
Баталгаажуулагчийн зөвлөмж: 1. ОҮИТБС-ын тайлангаас хавьгүй ойр давтамжтай (долоо хоног тутам) мэдээлэл гаргаж байгаа АМГ-ын олборлолтын мэдээллийг ОҮИТБС-ын цаашдын тайланд оруулж байх талаар ОТОАХ		

зөвлөлдөх нь зүйтэй.

2. Ашигт малтмалын хэмжээ, өртгийн тухай мэдээллийг АМГ, Монгол Банкнаас авч байх талаар ОТОАХ зөвлөлдөх нь зүйтэй. Тэгснээр Монголын худалдааны нөхцлийн талаар дотоодын шинэлэг бодлогын тухай, ашигт малтмалын глобаль үнэ бууралт Монголын төлбөрийн балансад хэрхэн нөлөөлж байгаа тухай хэлэлцүүлгийг мэдээлэхэд ач холбогдолтой болно.

3. Орлого цуглуулалт

3.1 Товч тодорхойлолт

Ил болгосон мэдээллийн бүрэн байдал, чанар, түвшнийг хамруулан, орлогын ил тод байдалд холбогдох, ОҮИТБС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэх талаар энэ хэсэгт мэдээлэв. Мөн ОҮИТБС-ын тайлан гаргах журамд холбогдох, ОҮИТБС-ын шаардлагад нийцүүлэх талаар энэ хэсэгт авч үзлээ.

3.2 Үнэлгээ

Бүрэн байдал (#4.1.a, #4.2.a-b)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд *материаллаг байдлын тодорхойлолт* хийсэн ч материаллаг түвшний босгын талаар тайлбарлаагүй байна. Мөн бодит практик дээр материаллаг түвшний босгоос хазайх тохиолдлууд гарч байна. Тайлан гаргалтын материаллаг түвшний босгыг 11-р хуудас, мөн 4.4 Хэсэгт (хуудас 70) тайлбарлажээ. Энэ босго нь 2010 оны 6-р сарын 24-нд тогтоосон хэвээрээ буюу 10,000 төгрөг (5 ам. доллар) хэвээр байна.

Материаллаг орлогын бүх урсгалыг харьцуулах тохируулгын хүрээнд хамруулсан бөгөөд 2010 оны 6-р сарын 24-нд (хуудас 70) зөвшөөрсөн тайлангийн загвар дээр нэмэгдүүлэн, төлбөрийг хамарч байгаа тайлангийн загваруудыг 2014 оны 1-р сарын 3-нд Үндэсний Зөвлөл зөвшөөрчээ. Хэдийгээр компаниуд шаргуу хүсэлт тавьж байсан ч хувь хүний орлогын татварын мэдээллийг орхигдуулсан байв. 2015 оны 4, 5, 6-р сард ОТОАХ-ын хурлууд тайлангийн загварын асуудлыг хэлэлцсэн ч хувь хүний орлогын татварын мэдээллийг (Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг ажлын хэсэгт гишүүнээр оруулаагүй байв) ахин дахин орхигдуулсан байв. Харьцуулах тохируулгад хамрагдсан төлбөрийн урсгалыг 68-р хуудасны диаграммд үзүүлсэн ч урсгал тус бүрийг тодорхойлоогүй байна.

Өмнөх жилд 200 байснаас нэмэгдүүлэн, харьцуулах тохируулгад хамруулахаар сонгогдсон 250 компанийн хувьд ч *материаллаг түвшний босгыг* 2013 оны 12-р сарын 23-нд (хуудас 70) нийт 40 сая төгрөгийн төлбөрөөр тогтоосон байв. Энэ нь “Засгийн Газарт 40 саяас дээш төгрөгийн нийт дүнтэй төлбөр төлж байгаа бүх компанийг харьцуулах тохируулгад хамруулсан” гэсэн агуулгатай бөгөөд “10,000 төгрөгийн материаллаг түвшний босгоос (төлбөр тутамд) дээш тэдгээр компанийн төлсөн бүх төлбөрийг харьцуулах тохируулгад хамруулсан” гэсэн агуулгатай юм. ОҮИТБС-ын тайланд материалын компаниудын жагсаалтыг (Хавсралт 2, хуудас 135-146) оруулсан ч тайлан гаргаж байгаа компаниуд зөвшөөрөгдсөн материаллаг түвшний босгоос хазайсан тухай дурдсан байв. Тус жагсаалтыг ОҮИТБС-ын Ажлын Алба өөрөө бэлтгэсэн мэдээлэлд үндэслэн Хараат бус хянагч-

нэгтгэгчид хүргүүлсэн юм. Хараат бус хянагч-нэгтгэгч “250 компаниас Засгийн Газарт хамгийн их төлбөр төлж байгаа 91 компанийг харьцуулах тохируулгад хамруулаагүй” тухай (Секц 2.4.1.3, хуудас 11) дурджээ. Харин оронд нь бусад 91 компанийг харьцуулах тохируулгад сонгосны 20 компани нь тайлан гаргаж байгаа компанид зориулан Үндэсний Зөвлөлөөс тогтоосон 40 сая төгрөгийн материаллаг түвшний босгоос доогуур байжээ. “Сонгон шалгаруулалтын анхны үндэслэлийг болон компаниудыг хассан Ажлын Албаны аргыг бид нягталж үзээгүй” хэмээн (хуудас.11) дурдсан байв. Сонголтуудыг хэрхэн авч үзсэн болон материаллаг түвшний босгыг тогтоосон учир шалтгааныг 2013 оны ОҮИТБС-ын тайланд тайлбарлаагүй байв. ОҮИТБС-ын тайлан гаргалтанд оролцож байгаа компаниудын тоо нэмэгдэж, 2010 оны ОҮИТБС-ын тайланд 301 компани байсан бол 2013 оны ОҮИТБС-ын тайланд 1151 компани болжээ. Хэдийгээр харьцуулах тохируулгын хамрах хүрээнд компаниудын дөрөвний нэгээс бага нь багтсан ч материаллаг төлбөр хийж байгаа бүх компанид ОТОАХ асуулга тавьсан юм. Харьцуулах тохируулгад хамрагдсан 250 компанийн гурваас бусад нь 2013 оны ОҮИТБС-ын тайланд мэдээллээ ил болгоогүй байв.

2013 оны ОҮИТБС-ын тайлангийн 2.4.5 Хэсэгт (хуудас 18) нэг компаниас (“Монгол-болгаргео”) бусад бүх компани тайлан гаргасан тухай дурджээ. Гэхдээ “Монгол-болгаргео” компани 2011, 2012 оны ОҮИТБС-ын тайланд тайлангаа өгсөн байв. 2013 оны ОҮИТБС-ын тайлан нь “Монгол-болгаргео” компанитай холбоо барих гэж нэлээд хэдэн удаа оролдсон тухай дурдсан ч энэ компани яагаад тайлан гаргаагүйг тайлбарлаагүй байв. Түүнээс гадна, хоёр компаниас “Засгийн Газрын болон тус хоёр компанийн өөрсдийн тайлангийн хооронд яагаад зөрүү гарч байгааг” асуусан асуулгад тус хоёр компани хариу өгөөгүй байв. 5.2.3.3 Хэсэгт (хуудас 86) мэдээллээ бүрэн өгөөгүй гурван компанийн төлбөрийн нийт хэмжээг мэдээлжээ. Нэмэлт гурван компанийг энд онцолсны шалтгаан нь “тэдний өгсөн мэдээлэл харьцуулах тохируулгад хангалттай биш байв”. Учир нь Засгийн Газар гаалийн татвар, НӨАТ, гаалийн үйлчилгээний хураамжийн төлбөрийн баримтыг зөвхөн нийт дүнгээр олгож, харин компаниуд нарийвчилсан задаргааг мэдээлж байв.

ОҮИТБС-ын тайланд “тодорхой компаниуд тайлангаа өгөөгүй нь материаллаг бус шинжтэй байна” хэмээн дурджээ. Зөрүүтэй зүйлсийн *материаллаг түвшний босгыг* 100,000 төгрөг байхаар (хуудас 70-71) тогтоосон байв. Гэхдээ нийт төлбөрийн зөрүүтэй байдал уу, эсвэл орлогын урсгал бүрээр тооцсон зөрүүтэй байдал уу гэдгийг тодорхойлоогүй байна. “Монгол-болгаргео” компанийн 2011оны тайлан (612 сая төгрөг), 2012 оны тайланд (400 сая төгрөг) үндэслэн Хараат бус хянагч-нэгтгэгч “энэ үндсэн дээр, компанийн орхигдуулсан мэдээлэл материаллаг шинжтэй гэж харагдахгүй байна” хэмээн (хуудас 18) мэдэгджээ. Орхигдуулсан мэдээлэл нь материаллаг шинжтэй бус гэж үзсэн мэдэгдэл нь “100,000 төгрөгийн материаллаг түвшний босго нь Засгийн Газрын нийт төлбөрүүдэд холбогдох уу, эсвэл орлого бүрийн урсгалд холбогдох уу” гэдгээс хамаарчээ. Тодруулга өгөөгүй “Бужгар орд” ХХК (71,845.7 төгрөг), “Угалзан цамхаг” ХХК (14,879.4 төгрөг) (хуудас 18-19) хоёр компанийн шийдэгдээгүй зөрүүтэй зүйлсийг “материаллаг шинжтэй бус” хэмээн тооцжээ. ОҮИТБС-ын тайланд нийт орлогын хуваарилалтын үнэлгээг оруулаагүй байв. 5.2 Хэсэгт (хуудас 82-83) шийдэгдээгүй зөрүү нь 36.84 сая төгрөг (Засгийн Газар авсан нийт мөнгөний 0.0002%) гэж бүртгэсэн учраас энэ нь материаллаг шинжтэй биш юм. 2.4.7 Хэсэгт (хуудас 19) “шийдэгдээгүй нийт зөрүү нь санхүүгийн хувьд материаллаг шинжтэй биш” байсан гэж дурджээ. Зөрүүгийн хувь нь орон нутгийн удирдах байгууллагууд 67%, Гаалийн Ерөнхий

Газар 29%, Сангийн Яам 4% байв. Мөн 2.4.9 Хэсэгт (хуудас 19-20) “Засгийн Газрын тодорхой байгууллагуудаас хариу авахад хүндрэлтэй бөгөөд тодорхой компаниудын мэдээллийг Хавсралт 16, 17⁷³ -д оруулсныг дурдсан байв.

Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОҮИТБС-ын ил болгосон мэдээллийг болон харьцуулах тохируулгын хамрах хүрээг үнэлж дүгнэхээс илүүгээр зөрүүтэй зүйлсийн материаллаг байдлын үнэлгээг зөвхөн оруулжээ. Харьцуулах тохируулгад (хуудас 82) хамруулсан нийт орлогын 0.0002% зөрүүтэй бөгөөд энэ нь тус салбараас Засгийн Газар олсон нийт орлого дотор эзлэх, харьцуулах тохируулгад хамрагдсан компанийн хувийг тооцоогүй байна.

Материаллаг төлбөр авч байгаа *Засгийн Газрын байгууллагуудын* жагсаалтыг 4.3.1 Хэсэгт (хуудас 69) оруулжээ. 2013 оны харьцуулах тохируулгад хамрагдсан тэдгээр орлогын хувийг хамруулан, харьцуулах тохируулгын хүрээнд багтсан компаниудаас төлбөр авч байгаа Засгийн Газрын бүх байгууллагын жагсаалтыг Хүснэгт 2-т (хуудас 7) харуулсан байна. 2.4.5 Хэсэгт (хуудас 18) “Засгийн Газрын бүх байгууллага харьцуулах тохируулгад хамрагдсан” хэмээн мэдээлжээ.

Гэхдээ, ОҮИТБС-ын тайланд Засгийн Газрын байгууллагуудын бүрэн мэдээллийг оруулаагүй байна. 4.3.2 Хэсэгт (хуудас 69-70) “1198 компани тайлангаа ОҮИТБС-ын Ажлын Албанд тушаасан бөгөөд Сангийн Яаманд 1617 компани тайлангаа тушаасан” гэж дурджээ. Хүснэгт 7-д (хуудас 16) “2013 онд 1691 компани уул уурхайн, газрын тос, шатдаг хийн лиценз эзэмшиж байсан” хэмээн мэдээлжээ. Бүх лиценз эзэмшигч нар наад зах нь лицензийн хураамж төлөх ёстой учраас Засгийн Газар өөрийн орлогын бүрэн мэдээллийг оруулаагүй байгааг энэ нь харуулж байна. Хүснэгт 3-т (хуудас 9) төлбөрийн урсгал бүрийн орлогын хэмжээг ил болгосон ч компаниуд болон Засгийн Газрын ил болгосон мэдээллийн хооронд бараг зөрүү байхгүй учраас энэ нь төлбөрөө ил болгосон зөвхөн 1198 компанийн орлогыг хамарсан бололтой харагдаж байна. Хүснэгт 5 (хуудас 15) нь орлогын урсгалын харьцуулах тохируулгын мэдээллийг хамарч байгаа ч энэ нь Засгийн Газрын ил болгосон мэдээллийг бүрэн хамраагүй байв.

Түүнчлэн Хараат бус хянагч-нэгтгэгч (хуудас 70) “АМГ болон Сангийн Яаманд компаниудын хоёр өөр жагсаалт байгаа бөгөөд эдгээр жагсаалт нь өөр зорилготой байна” хэмээн дурджээ. “Сангийн Яамны жагсаалтыг харьцуулах тохируулгын хамрах хүрээг тогтооход ашиглах зорилготой” хэмээн Хараат бус хянагч-нэгтгэгч дурджээ.

ОҮИТБС-ын тайлан нь компани, Засгийн Газрын байгууллага, орлогын урсгалаар задаргаа хийсэн мэдээллийг 2013 оны ОҮИТБС-ын тайлангийн Хавсралт 1В (хуудас 122-125) болон Хавсралт 1С-д (хуудас 126-134) оруулжээ. Компани, Засгийн Газрын байгууллага, орлогын урсгалаар бэлтгэсэн мэдээллийг Монголын ОҮИТБС-ын вэб хуудаснаас⁷⁴ Экселийн дэлгэмэл хуудас хэлбэрээр авах боломжтой байна.

Хэдийгээр энэ нь ОҮИТБС-ын Стандартын шаардлага биш ч санхүүгийн өгөгдлийг төслөөр

⁷³ МОҮИТБС-ын 2013 оны тайлангийн хавсралт 16 болон 17-г МОҮИТБС-ын вэбсайтад тус тусад нь нийтэлсэн. (<http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/2013%20Report%20annex%20EN.zip>).

⁷⁴ http://www.Монголын_ОУИТБСmongolia.mn/sites/default/files/uploads/Компани_report_2013.xlsx

задаргаа хийгээгүй байв. Гэхдээ 2015 оны 1-р сарын 13-ны хурал дээрээ Үндэсний Зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ажиллагаанд холбогдсон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын мэдээлэлд задаргаа хийх боломжийг үнэлүүлэх зорилгоор Ажлын хэсэг байгуулах үед “төсөл-төслөөр” тайлан гаргах асуудлыг авч үзжээ. Энэ нь төслөөр задаргаа хийсэн тайлан гаргах анхны алхам хэмээн харагдаж байв.

8.2.2 Хэсэгт (хуудас 109) “компаниудыг сонгох аргыг эргэн харж, лицензийн болон татварын бүртгэлийг харьцуулж, олборлох салбарын компаниудыг илүү хялбар таних боломжтой болгох хэмжээнд тайлангийн системийг сайжруулж болох эсэхийг шалгах нь зүйтэй” гэсэн зөвлөмж оруулжээ. ОТОАХ болон 2014 оны ОҮИТБС-ын тайлангийн Хараат бус хянагч болох аудитын KPMG компани энэ зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажилласан байв. 2015 оны 7-р сарын 7-нд хийсэн анхны сургалтын үед эрсдэлд үндэслэсэн дараах зарчмыг баталжээ.⁷⁵

- Ганцаарчлан харьцуулах тохируулга (үндэсний түвшний хэсэг 1): нийт 250 саяас дээш төгрөгийн орлогын үндсэн урсгалтай компаниуд нийт орлогын 97.8%-г бүрдүүлж байна. Энд нийт 183 компани байгаа бөгөөд эдгээр компанийг ганцаарчилсан түвшинд харьцуулан тохируулна.
- Загвараар харьцуулах тохируулга (үндэсний түвшний хэсэг 2): нийт 100 саяас дээш төгрөгийн орлогын үндсэн урсгалтай боловч нийт 250 саяас доош төгрөгийн орлогын үндсэн урсгалтай компаниудыг эрсдэлд суурилсан зарчмаар дүгнэнэ. Ийм 130 компани байна.

Оролцогчдын санал

Засгийн Газрын хоёр төлөөлөгч харьцуулах тохируулгын хамрах хүрээг тогтооход баримталсан, одоогийн материаллаг түвшний босгын талаар шүүмжилж байв. Хэрэв 1300 гаруй компаниас мэдээлэл авсан бол яагаад энэ мэдээллийг Засгийн Газар ил болгож байгаа мэдээлэлтэй харьцуулан тохируулж болохгүй вэ гэдэг нь эдгээр оролцогч нарт тодорхой бус байв. Үйлдвэрлэлийн хэд хэдэн төлөөлөгч нар “материаллаг түвшний босгыг эргэн харах саналыг хэд хэдэн удаа тавьсан бөгөөд хамгийн сүүлд 2015 оны 11-р сарын 3-нд Үндэсний Чуулган дээр тавьсан тухай” дурдаж байв. Хоёр өөр босготой болгох (хайгуулын болон олборлолтын лиценз эзэмшигч нарт) санал тавигдсан бөгөөд ингэвэл Хараат бус хянагч-нэгтгэгч нь бага төлбөр хийж байгаа хайгуулын компаниудын хойноос хөөцөлдөж цаг алдахгүй болох ажээ. “Харьцангуй идэвхтэй бус хайгуулын компаниуд зөвхөн лицензийн хураамж төлдөг бөгөөд төлбөрөө төлөөгүй аливаа тохиолдолд лицензийг нь түдгэлзүүлдэг байсан” хэмээн зарим оролцогч дурдаж байв. Энэ талаар ОТОАХ авч хэлэлцээгүй боловч хэлэлцүүлгийн үеэр Засгийн Газрын нэг төлөөлөгч “Засгийн Газар орлого авч байгаа компаниудын тоо нь лиценз эзэмшиж байгаа компаниудын нийт тоотой тэнцэхгүй байна” хэмээн мэдэгдэж байв. Тус төлөөлөгч “бүх лиценз эзэмшигчдийн тухай мэдээллийг ил болгоход Засгийн Газарт практик бодитой саад байхгүй” хэмээн мэдэгдсэн юм.

⁷⁵ 2015 оны 7-р сарын 7-ны Явцын тайлангийн хурлын тэмдэглэлийг МОҮИТБС-ын вэбсайтад нийтлээгүй болно. Бид батлуулсан Явцын тайланг оруулсан болно.

2014 оны ОҮИТБС-ын тайланд цахим тайлангийн системээр тайлан гаргасан компаниудын тоо 987 болж буурчээ. АМГ зэрэг Засгийн Газрын агентлагуудтай бид хэлэлцүүлэг хийх үед тэдгээр агентлагууд “2014 онд компаниуд тайлан гаргах түвшин доогуур байсны шалтгаан нь олон компани ажлаа зогсоосон, эсвэл мөнгөгүй болж, эрх хүлээн авагчид шилжсэн” хэмээн дурдаж байв. “Лицензтэй 1500 гаруй компаниас 380 нь ашиглалтын төлөвлөгөөгөө АМГ-д тушааснаас 300 нь батлагдаж, 78 нь ажиллаж, олборлолт хийсэн” хэмээн дурдагдаж байв. Лиценз эзэмшигч нар олборлолт хийгээгүй байсан ч лицензийн жилийн төлбөрөө Засгийн газарт материаллаг хэлбэрээр төлж байв.

Засгийн Газрын хоёр төлөөлөгч “Засгийн Газрын бүх газар, хэлтэст тогтвортой ашиглахын тулд компанийг илэрхийлэх тодорхой тоотой болговол компанийн төлбөрийг олж илрүүлэх ажил хялбар болно” хэмээн хүсэлт тавьж байв.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. 2013 оны ОҮИТБС-ын тайланд төлбөрийн материаллаг түвшний босгыг оруулж, харьцуулах тохируулгад хамрагдах компаниудыг мэдээлсэн ч яагаад тухайн босгыг ийм түвшинд тогтоосныг тайлбарлаагүй байна. Төлбөрийн материаллаг түвшний босгыг 2010 оны 6-р сард тогтооход болон компаниудын материаллаг түвшний босгыг 2013 оны 12-р сард тогтооход ОТОАХ оролцжээ. Гэхдээ компаниудын материаллаг түвшний босгыг практикт биелүүлэхгүй байна. Тайлан гаргаагүй компанийн нийт орлогын хувийг дүгнээгүй байв. Гэхдээ, 2014 оны ОҮИТБС-ын тайланг эхлүүлэх үеийн хэлэлцүүлгээс бид “харьцуулах тохируулгад хамрагдсан компаниудад тогтоосон материаллаг түвшний босгын нарийвчилсан хэлэлцүүлгийг 2015 оны 7-р сарын 7-нд явуулж, эрсдэлд-суурилсан зарчмыг баримталсан” гэдгийг тэмдэглэж байна. Энэ нь “ОТОАХ эдгээр цоорхойг шийдэхийг хичээж байгааг харуулах юм.

Орлогын урсгал бүрийн тодорхойлолтыг энд оруулаагүй байна.

Бас зөрүүтэй зүйлсийн материаллаг түвшний босго нь тайлан гаргаж байгаа компани тутмын төлбөрийн урсгал бүрийн зөрүүтэй зүйлсэд холбогдож байна уу, эсвэл нийт дүнгээр байна уу гэдэг нь тодорхой бус байв.

Эцэст нь тэмдэглэхэд, ОҮИТБС-ын тайлан бүрэн эсэх талаар Хараат бус хянагч-нэгтгэгчийн үнэлгээ байхгүй байна.

Мэдээллийн чанар

Явцын баримтжуулалт

Хараат бус хянагч-нэгтгэгчид зориулсан Зорилгын тодорхойлолт: 2014 оны 3-р сарын 12-ны хурлаар⁷⁶ Зорилгын тодорхойлолтыг ОТОАХ баталж, Үнэлгээний Хороо⁷⁷ байгуулсны дараа Монгол улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар 2014 оны 3-р сард Хараат бус хянагч-нэгтгэгч

⁷⁶ Зөвхөн Монгол хэлээр байгаа - http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/АН_35_20150312.pdf

⁷⁷ ОҮИТБС-ын олон талт ажлын хэсгийн 2014 оны 3-р сарын 11-ны 35-р хуралдааны хурлын тэмдэглэл (вэбсайтад зөвхөн Монгол хэлээр боломжтой http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/АН_35_20150312.pdf)

нарт зориулан Зорилгын тодорхойлолтыг баталсан юм. Тус Хороо 2014 оны 5-р сарын төгсгөл хүртэл тендерийн материалуудыг үнэлж, “Улаанбаатар Аудит корпораци” ХХК, Их Британийн “Харт нөрс” компанийн консорциумыг сонгосон юм. Харин түүнтэй өрсөлдөж байсан, 2012 оны ОҮИТБС-ын тайланг хариуцсан “Далай Ван аудит” ХХК, Их Британийн “Мур Стефенс” компанийн консорциум тус тендерийн техникийн үнэлгээний дүн болон оноо тооцолтын талаар гомдол гаргажээ. Гэсэн ч Үнэлгээний Хороо тус гомдлыг албан ёсоор гаргаагүйг тогтоож, анхны сонголтыг хэвээр үлдээсэн байв. Энэ гэрээнд 2014 оны 7-р сард гарын үсэг зуржээ.

Гэсэн ч 2013 оны ОҮИТБС-ын тайланд зориулсан Зорилгын тодорхойлолт нь Олон улсын ОҮИТБС-ын вэб хуудсанд байгаа Зорилгын тодорхойлолтын загвараас ихээхэн ялгаатай байна. Энэ загвар нь олон улсын, эсвэл аль нэг улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байв. Энэ загвар нь холбогдох нөхцөл байдлын тухай мэдээллийн эх үүсвэрийг тогтоох, эсвэл тайлан гаргах явцад ОТОБ оролцсоныг тодорхой харуулж чадахгүй байна. Мөн энэ загвар нь ОҮИТБС-н Зөвлөл баталсан Зорилгын тодорхойлолтын загварын 1-р Хавсралт доторхи мэдээллийн аль нэгийг өгөөгүй байв.

Тайлан гаргах загваруудыг жил тутам хянаагүй бөгөөд хэдийгээр ОТОАХ ч, Үндэсний Зөвлөл ч тайлан гаргах загваруудын шинэчлэлийг Хараат бус хянагч-нэгтгэгчтэй авч хэлэлцээгүй боловч хамгийн сүүлд загваруудыг 2013 оны 12-р сарын 23-нд⁷⁸ Үндэсний Зөвлөл зөвшөөрчээ. Тайлан гаргах загваруудыг шинэчлэх процессыг ОТОАХ зөвшөөрч, Үндэсний Зөвлөл баталж, Үндэсний Статистикийн Хороо хянаж батлан (Үндэсний Статистикийн хуульд шаардсаны дагуу), эцэст нь Хууль Зүйн Яам баталдаг. Энэ үйл явц голдуу есөн сар үргэлжилдэг. Тайлангийн загваруудыг хамгийн сүүлд шинэчлэхдээ Ажлын Албанаас бидэнд “ОТОАХ санал болгож, батлуулсан тайлангийн загваруудад Үндэсний Статистикийн Хороо ямарваа нэмэлт оруулаагүй” гэж мэдэгдсэн юм. Ил болгох мэдээллийн чанарын баталгааг сайжруулахын тулд ОТОАХ хянаж нягталсан загваруудыг 2015 оны 6-р сард Үндэсний Зөвлөл баталжээ. Тайлангийн загваруудын талаар ОТОАХ 2015 оны 4, 5, 6-р сард хуралдсан юм. Шинэчилсэн тайлангийн загваруудыг 2015 оны 11-р сард Үндэсний Статистикийн Хороо үргэлжлүүлэн хянасаар байв. Энэ хяналт нь 2015 оны ОҮИТБС-ын тайланг гаргах үед буюу 2016 онд л дуусах төлөвтэй байна.

Компанийн аудит: 2013 оны ОҮИТБС-ын тайлангийн 2.4.2.1 Хэсэгт (хуудас 13) компаниудад зориулсан баталгаа гаргах ажиллагааг товч танилцуулж, ОҮИТБС-ын харьцуулах тохируулгад зориулж өгсөн мэдээллийн нарийвчлалын талаар дурдсан, компанийн удирдлагын гишүүний захидлыг оруулжээ. Өгөгдөл мэдээллийн найдвартай байдлын талаар Хараат бус хянагч-нэгтгэгчийн дүгнэлтийн хураангуйг ОҮИТБС-ын тайланд мэдээлсэн байв. 2.4.2.1 Хэсэгт (хуудас 13) “35 компани удирдлагын захидал явуулаагүй байгаа нь Засгийн Газар хүлээн авч тайлагнасан мөнгөний хэмжээний 20% болж байна” гэдгийг тайлбарлажээ.

Түүнчлэн, 6.2 Хэсэгт (хуудас 89-90), ОҮИТБС-ын харьцуулах тохируулгад хамрагдсан компаниудад хийсэн аудит ажиллагааны дүгнэлтийг оруулжээ. Өөрсдийн компанийн аудитын тайлангийн хувиа ирүүлэх хүсэлтийг тайлан гаргах бүх 250 компанид явуулахад 45 компани (250 компанийн 22%) хариу өгөөгүй байна. Хариу өгсөн 205 компаниас:

- 181 компанийн аудитын тайлан чанарын шаардлага хангаагүй,
- 16 компанийн аудитын тайлан “чанарын шаардлага хангасан” саналтай,

⁷⁸ 2013 оны ОҮИТБС-ын 2013 оны тайлангаар тайлагнасан бүдүүвчийг Үндэсний зөвлөл 2014 оны 1-р сарын 3-ны хуралдаанаар зөвшөөрсөн бөгөөд үүнийг Үндэсний зөвлөлийн 2013 оны 12-р сарын 23-ны хуралдаанаар дахин авч үзэх шаардлагатай.

- 2 компани нь “аудитор үл хариуцах” нөхцөлтэй,
- 6 компани аудит хийлгээгүй байв.

Засгийн Газрын аудит: Засгийн Газрын ил болгосон мэдээллийн найдвартай байдлын талаар 2.4.1.2 Хэсэгт (хуудас 11) “албан ёсоор баталгаажуулах ажил хийгдээгүй (2.3.2.4-г үзнэ үү), “материаллаг шинжтэй биш байсан ч мэдээлэл дотор нарийвчлалгүй зарим мэдээлэл орсон (дараагийн хэсгийг үзнэ үү)” хэмээн дурджээ. 2.4.2.4 Хэсэгт (хуудас 13-14) Хараат бус хянагч-нэгтгэгч “Засгийн Газар авсан мөнгөний дэлгэмэл хуудсуудад Сангийн Яамны төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурсан. Гэхдээ, ОҮИТБС-д зориулж Хараат бус хянагч-нэгтгэгч мэдэгдсэн, Засгийн Газар авсан мөнгөнд холбоотой баталгаа гаргаагүй бөгөөд Засгийн Газрын гарын үсэг нь юуг илэрхийлж байгаа талаар дурдаагүй байна” хэмээн мэдэгджээ.

8.3 Хэсэгт (хуудас 110-111) Засгийн Газрын байгууллагуудад зориулан, Үндэсний Аудитын Газар, эсвэл зохих чадвартай аудитын компанийн аудитын ажиллагааны танилцуулгыг оруулсан байв. Засгийн Газрын байгууллагуудад зориулсан аудитын тэдгээр шаардлагыг бодит практикт гуйвуулсан эсэх талаар үнэлгээ дүгнэлт гаргаагүй байна.

Засгийн Газрын нэг төлөөлөгч “Засгийн Газрын ил болгосон мэдээллийн чанарын баталгааны сертификатыг зөвхөн 2014 оны ОҮИТБС-ын тайланд ашигласан тайлангийн загваруудад хэрэглэсэн” хэмээн мэдэгдсэн юм. 2013 оны ОҮИТБС-ын тайланг хамарч байгаа, ОҮИТБС-ын өмнөх тайлангуудад “цаг хугацааны хувьд зөрүүтэй байгаа нь үндсэн бэрхшээл учруулж байв” хэмээн дурджээ. Засгийн Газрыг төлөөлөн Сангийн Яам 2014 оны 2-р сарын дундуур 2013 оны ОҮИТБС-ын тайланг тушаах шаардлагатай бөгөөд дараа нь энэ тайланг ОҮИТБС-ын Ажлын Алба хадгалж байгаад 2014 оны 3-р улиралд Хараат бус хянагч-нэгтгэгчид шилжүүлж өгдөг. Гэхдээ Засгийн Газрын тайланд нэгдсэн аудит хийхийн өмнө Үндэсний Аудитын Газар 4-р сарын 20-нд зөвхөн сум, аймгуудын тайланд аудит хийсэн байв. Иймээс Улсын Аудитын шаардлага хангасан тухай сертификатыг 2014 оны 2-р сарын дунд үед олгох боломжгүй болсон байв.

Урьдчилсан харьцуулах тохируулгын мэдээллийн нууцлал: Харьцуулах тохируулга хийхээс өмнө мэдээллийн нууцлалыг хадгалах тухай заалтууд нь 2013 оны ОҮИТБС-ын тайланд хүчтэй биш байв. Тайлан гаргах байгууллагуудад зориулж D Хавсралт болон 2014 оны гарын авлагад оруулсан диаграмм нь компаниуд болон Засгийн Газрын байгууллагуудын аль алианаас мэдээлэл нэгтгэж авахад ОҮИТБС-ын Ажлын Албаны гүйцэтгэсэн гол үүргийг тодорхой харуулж байна. Засгийн Газрын байгууллагууд ил болгосон мэдээллээ Татварын Ерөнхий Газар, Сангийн Яамаар дамжуулан төвлөрүүлдэг. Гэхдээ энэ асуудлыг 2014 оны ОҮИТБС-ын тайланд ингэж шийдсэн бөгөөд тайлан гаргаж байгаа байгууллагууд (Засгийн Газар, компанийн аль аль нь) өөрсдийн мэдээллийг цахим тайлангийн системд шууд оруулж байна. Гэхдээ харьцуулах тохируулга хийхийн өмнө, цахим тайлангийн системд ил болгосон мэдээллийг вэб хуудсанд шууд байрлуулж нийтэлдэг. Харин энэ ажиллагааны талаар ОТОАХ-н аливаа гишүүн болон тайлан гаргаж байгаа аливаа этгээд санал, гомдол гаргаагүй байв.

Түүнээс гадна, хураангуй өгөгдлийн загварыг ОҮИТБС-ын бүх тайланд зориулан, Засгийн Газрын тайлангууд⁷⁹, компанийн тайлангуудын хамт⁸⁰ вэб хуудсанд байршуулжээ. Энэ үндсэн дээр хураангуй өгөгдлийн стандартжуулсан загварыг ОҮИТБС-ын Олон Улсын Ажлын Алба⁸¹

⁷⁹ <http://www.Монголын ОҮИТБСcongoliamn/en/government-reports>

⁸⁰ <http://www.Монголын ОҮИТБСcongoliamn/en/компани-reports>

⁸¹ <https://drive.google.com/folderview?id=0B7tEEAf2PsWEUjIV1g2Zy02MFE&usp=sharing&tid=0B7tEEAf2PsWEaF84YkN2MU14Y0U>

боловсруулсан юм.

Оролцогчдын санал

Засгийн Газрын хоёр төлөөлөгч “2013, 2014 оны ОУИТБС-ын тайланд хэрэглэхийн тулд Хараат бус хянагч-нэгтгэгчид зориулан Зорилгын тодорхойлолтод инпут оруулсан” хэмээн мэдэгдсэн юм. Засгийн Газрын нэг төлөөлөгч “2015 оны хавар Сангийн Яамнаас Үндэсний Аудитын Газарт албан бичиг явуулж, ОУИТБС-д зориулж Засгийн Газар ил болгосон мэдээлэлд аудит хийлгэх хүсэлтийг тус агентлагт тавьсан” хэмээн мэдээлжээ. Тус агентлаг хариу өгөхдөө “ийм аудит хийх боломжтой, гэхдээ манай байгууллагын ирээдүйн ажлын төлөвлөгөөнд тусгаж, улсын төсвийн бүтэц хэсэг байдлаар УИХ баталсан үед аудит хийх боломжтой байдаг” хэмээн дурджээ. Энэ санал 2016 оны улсын төсвийн төсөлд тусгагдаагүй байв. Түүнчлэн Үндэсний Аудитын Газар хариундаа “бид зөвхөн бүрэн баталгаа гаргах бөгөөд ийм баталгаа нь Засгийн Газарт хүргүүлсэн тайлангуудын анхны аудит болж, ОУИТБС-ын эцсийн тайлангийн хоёр дахь аудит болно” хэмээн дурджээ. ОУИТБС-ын өмнөх тайлангуудад энэ саналыг олон удаа дэвшүүлсэн учир Баталгаажуулах үед мэдээллийн чанарын баталгаа нь асуудал үүсгэнэ гэдгийг Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгч нар мэдэж байв.

Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгч нар “өгөгдөл мэдээлэлд чанарын баталгаа гаргахад өндөр түвшний, албаны ажилтны жирийн гарын үсэг хангалттай” хэмээн тайлбарласан юм. Аудит хийгдсэн санхүүгийн тайлангуудад холбогдох сертификат олголтонд үүсэж байгаа бэрхшээл бол Үндэсний Аудитын Газар нь Засгийн Газрын зөвхөн зардалд санхүүгийн аудит хийж, орлогод аудит хийхгүй байгаа явдал байв. Жил бүрийн орлогын төлөвлөгөөг Татварын Ерөнхий Газарт өгдөг бөгөөд Үндэсний Аудитын Газар нь Татварын Ерөнхий Газраас ирсэн тайланд л харьцуулах тохируулга хийж байна. “Компаниудыг таних тоон код цахим тайлангийн системд байхгүй учраас тухайлбал АМГ, Гаалийн байгууллагад цахим тайлангийн систем бэрхшээл үүсгэсэн хэвээр байна” хэмээн яригдаж байв. Мөн Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгчид “хэрэв харьцуулах тохируулгад хамрагдах компаниудын тоог багасгавал ОУИТБС-д ил болгосон мэдээллийн чанарыг сайжруулж болно” хэмээн дурдаж байв.

Үнэлгээ

Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. 2013, 2014 оны ОУИТБС-ын тайланд холбоотойгоор Хараат бус хянагч-нэгтгэгчид зориулсан Зорилгын тодорхойлолтыг бэлтгэхэд ОТОАХ-ын оролцоо хязгаарлагдмал байсан бололтой. 2013 оны Зорилгын тодорхойлолт нь ОУИТБС-ын Зөвлөл баталсан загвараас ихээхэн ялгаатай бөгөөд 2014 оны Зорилгын тодорхойлолтыг хэвлэхийн өмнө тохируулга хийгээгүй байв. Тайлангийн загваруудыг ОТОАХ, Хараат бус хянагч-нэгтгэгч нар хоорондоо зөвлөлдөх үедээ дахин хянаж нягтлаагүй байна. Тэдгээр тайлангийн загварыг түр Ажлын Хэсэг хянаж, ОТОАХ зөвшөөрсний дараа Хараат бус хянагч-нэгтгэгчтэй гэрээ хийхийн өмнө Үндэсний Зөвлөл баталжээ. Гэхдээ ОТОАХ, эсвэл Үндэсний Зөвлөлийн хурлын тэмдэглэлд тайлангийн загварын талаар Хараат бус хянагч-нэгтгэгчтэй зөвлөлдсөн тухай нотолгоо байхгүй байна. Тайлангийн хянагдсан загваруудыг зөвшөөрөх ажиллагаа өөрчлөгдөж, ОУИТБС-ын Стандартад шаардсаны дагуу Үндэсний Статистикийн Хороо, Хууль Зүйн Яам эцэслэн батлах ёстой байсан ч Засгийн Газрын энэ хоёр байгууллага ОТОАХ-ын хүсэлтийн эсрэг ажилласан шинжгүй боловч ОТОАХ-ын баталсан тайлангийн загваруудад нэмэлт оруулаагүй байв. 2013 оны ОУИТБС-ын тайланд аудитын хяналтыг тусгаж, чанарыг батлах ажиллагаа хийсэн ч бодит практикт гуйвж хазайж байгаа талаар үнэлээгүй байна. Энэ хяналтад үндэслэн, Хараат бус хянагч-нэгтгэгч нь 2013 оны ОУИТБС-ын тайланд ОТОАХ-тай хамтран (2013 оны ОУИТБС-ын тайлангийн хуудас 13-14. Эхний шатны явцад 2014 оны 8-р сард зөвшөөрсөн шийдвэрийг энд хамруулжээ) баталгаа гаргахыг зөвшөөрчээ. 2013 оны ОУИТБС-ын тайланд чанарын баталгаа гаргах журмыг баримталсан эсэх талаар дүгнэлт оруулж,

тус дүгнэлтэд Хараат бус хянагч-нэгтгэгч нь “Засгийн Газрын тайлан мэдээлэлд албан ёсны баталгаа байхгүй” (хуудас 108), “харьцуулах тохируулгад хамрагдсан 250 компаниас 35 нь (олборлох үйлдвэрлэлээс Засгийн Газарт орж байгаа орлогын 20%-г бүрдүүлж байгаа) баталгааны сертификат олгоогүй байна” (хуудас 111) гэж дурджээ.

2013 оны ОҮИТБС-ын тайлан нь холбогдох нөхцөл байдлын бүх мэдээллийг тууштай хамруулаагүй байна.

Хэдийгээр 2014 оны ОҮИТБС-ын тайланд зориулан цахим тайлангийн системийг ашиглахдаа энэ дутагдлыг засахыг хичээсэн ч харьцуулах тохируулга хийхийн өмнө мэдээллийн нууцыг хадгалах тухай заалтууд нь 2013 оны ОҮИТБС-ын тайланд хүчтэй биш байв. 2013 оны ОҮИТБС-ын тайланд ил болгосон мэдээлэлдээ чанарын баталгааны сертификат гаргахыг компаниуд зөвшөөрсөн боловч олон компани гаргаагүй бөгөөд Засгийн Газрын байгууллагуудын ил болгосон мэдээлэлд огт сертификат гаргаагүй байна. 2014 оны ОҮИТБС-ын тайланд ашигласан цахим тайлангийн системд чанарын баталгааны шаардлагуудыг сайжруулан тусгасан ч олон компани, Засгийн Газрын байгууллагууд тэдгээр шаардлагыг практикт мөрдөөгүйг бид мэдсэн юм. Чанарын баталгааны сертификатыг тайлан гаргагч байгууллагууд өөрчилж байгааг зогсоохын тулд цахим тайлангийн системд тусгасан, чанарын баталгаа гаргах ажиллагааны журмыг ОТОАХ эргэн харахыг хүсэх боломжтой юм.

Татвар ба бусад төлбөр (#4.1.b)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд “дараах орлогын бүх урсгалыг ОТОАХ авч үзсэн” хэмээн дурджээ:

- Газрын тосны ашгийг төлбөрийн бүтэц хэсэг байдлаар жагсаасан ч (хуудас 68) нэмэлт тайлбар оруулаагүй.
- Газрын тосноос Монгол улсын Засгийн Газарт орсон орлогыг БХГ бүрээр мэдээлжээ. (Хуудас 124).
- Аж ахуйн нэгжийн орлогын татвар нь ашгийн татварын төрөл бөгөөд харьцуулах тохируулгад хамруулсан байв (хуудас 68, 122).
- Ашигт малтмал ашигласны төлбөр (роялти татвар) болон газрын тос ашигласны төлбөрийг (газрын тосны роялти татвар) харьцуулах тохируулгад хамруулжээ (хуудас 122).
- Төрийн өмчийн ноогдол ашгийг харьцуулах тохируулгад хамруулжээ (хуудас 122).
- Гарын үсгийн бонус, БХГ-ий бүтэц байдлаар олборлолт эхэлсний бонус, БХГ бүрийн сургалтын бонус бүгдийг харьцуулах тохируулгад хамруулжээ (хуудас 122).
- Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лицензийн төлбөр, агаарын бохирдлын төлбөр (нүүрс), компаниас нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн төлбөр, гаалийн үйлчилгээний төлбөр, газрын төлбөр, ус ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, гадаадын шинжээч, ажилчид ажиллуулсны төлбөрийг бүгдийг нь харьцуулах тохируулгад хамруулжээ (хуудас 123-124).
- Засгийн Газарт төлсөн орлогын бусад томоохон урсгал буюу НӨАТ, шатахуун, дизелийн татвар, мөн дизель түлшний татварыг (хуудас 122) хамруулжээ.

Оролцогчдын санал

Харьцуулах тохируулгад хамруулсан орлогын урсгал бүрэн эсэх талаар үйлдвэрийн болон иргэний нийгмийн төлөөлөл тодорхой санал гаргаагүй байв. Засгийн Газрын нэг төлөөлөгч “орлогын бүх урсгалыг хамруулсан бөгөөд төлбөр тутамд материаллаг түвшний босго доогуур, 10,000 төгрөг байгаа учир харьцуулах тохируулгын хүрээнд орлогын бүх урсгалыг хамруулах хүсэлтээ ОТОАХ тодорхой илэрхийлсэн” хэмээн дурдсан юм. Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгч материаллаг

түвшний босго ийм доогуур байгаад гонсойж буйгаа илэрхийлж, харьцуулах тохируулгын хүрээнд хамруулах орлогын урсгалыг сонгох талаар илүү хэлэлцүүлэг хийхийг хүсэж байв. Тэгснээр материаллаг орлогын урсгалд холбогдох бүх мэдээллийг ил болгоход чармайлтаа төвлөрүүлэх боломжтой” хэмээн үзэж байв.

Үнэлгээ

Энэ шаардлага биелсэн гэж бид үзэж байна.

Мөнгөн бус орлого (#4.1.с)

Явцын баримтжуулалт

Мөнгөн бус, материаллаг орлоготой холбоотойгоор олборлох үйлдвэрлэлийн газрын тос, шатдаг хийн салбарт төрийн оролцоо нэмэгдэж байгаа ч уул уурхайн салбарт нэмэгдээгүй байв. 2013 оны ОҮИТБС-ын тайланд газрын тосны ашгийг (хуудас 68) харьцуулах тохируулгад хамрагдсан төлбөрийн диаграммын бүтэц хэлбэрээр үзүүлжээ. Энэ төлбөрийг бэлнээр төлсөн хэмээх таамаглал байгаа ч (хуудас 124 нь БХГ-с Засгийн Газарт бэлнээр төлсөн газрын тосны орлого) энэ талаар тайлбарлаагүй, эсвэл батлаагүй байна. Бүтээгдэхүүний төрөл, үнэ ханш, зах зээл, борлуулсан хэмжээний талаар мэдээллийг ил болгоогүй байв. ОҮИТБС-ын Стандартад шаардаагүй ч борлуулсан хэмжээ болон хүлээж авсан орлогод харьцуулах тохируулга хийгээгүй байв.

Оролцогчдын санал

Засгийн Газрын нэг төлөөлөгч Эрдэнэс Таван Толгойн олборлолт, борлуулалтын асуудлыг мөнгөн бус орлогын жишээ байдлаар хөндөж байв. Гэхдээ уул уурхайг Засгийн Газар бүрэн эзэмшиж байгаа (мөнгөн бус орлого нь хувийн оператортой гэрээ хийсний үр дүн байдлаар үүсээгүй) учраас энэ нь мөнгөн бус орлого гэж хатуу тооцогдохгүй юм. Төрийн өмчит уул уурхайн компаниуд хувийн эзэмшлийн компаниудтай адилаар Засгийн Газарт татвар, лицензийн хураамж, ноогдол ашиг зэрэг материаллаг төлбөр хийж байгаа (эсвэл Хүний Хөгжлийн Сангийн бүтэц хэсэг болж байгаа “Эрдэнэс Монгол”-д, төрийн өмчит дөрвөн компанид болон төрийн өмчит бусад бүх компанид зориулан Төрийн Өмчийн Хороонд хийж байгаа) боловч энэ нь мөнгөн бус орлогын борлуулалтаас үүссэн орлогыг хамрахгүй байна. Эрдэнэс Таван Толгой зэрэг төрийн өмчит уул уурхайн компани өөрсдийн бүтээгдэхүүнээ борлуулж, борлуулсан хэмжээндээ үндэслэн Засгийн Газарт татвар, хураамж, ноогдол ашиг төлж байна. Эрдэнэс Таван Толгойн олборлож, борлуулсан нүүрсний хэмжээний талаар мэдээллийг ил болгоход хууль эрх зүйн саад байхгүй ч бодит практикт эдгээр тайланг ил болгохгүй байна. Төрийн бус байгууллагууд ийм мэдээллийг “буруу тайлбарлаж” байгаад Засгийн Газрын төлөөлөгчид харамсаж байв.

Газрын тос, шатдаг хийн салбарт шийдвэр гаргах эрхтэй, Үндэсний Зөвлөлд оролцож байгаа, Засгийн Газрын нэг төлөөлөгч Монгол улсын БХГ-ний системийн хүрээнд мөнгөн бус орлогод холбогдох заалтуудыг тайлбарласан юм. Газрын тос, шатдаг хийн операторууд олборлолтын хэсгээ Засгийн Газарт мөнгөн бус хэлбэрээр шилжүүлэх шаардлагатай (БХГ-үүд бүгд өөр байгаа учраас Засгийн Газарт шилжүүлэх хэсэг нь БХГ-ээс хамааран хэлбэлздэг) байдаг. Газрын тос, шатдаг хий олборлох гурван БХГ-ний хувьд бол, хоёр оператор нь Засгийн Газарт оногдох тосны ашгийн хэсгийг арилжааны болгох асуудлыг анхаарч, дараа нь Газрын Тосны Газарт орлогыг (маркетингийн төлбөр) шилжүүлдэг. Өрөмдлөгийн цооногийн дэргэд гаалийн ажилтан тусгайлан гурван удаа шалгах бөгөөд арилжсан газрын тосны хэмжээг Газрын Тосны Газраар дамжуулан Засгийн Газар хянаж байна.

Үнэлгээ

Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. 2013 оны ОҮИТБС-ын тайланг гаргаж дуусгах үед болон хурлуудаа хийх үедээ ОТОАХ нь мөнгөн бус орлогын асуудлыг

авч үзээгүй бололтой байв. Газрын тос, шатдаг хийн БХГ нь Засгийн Газарт мөнгөн бус хэлбэрээр шилжүүлэх тосны хэсгийг заасан ч ОУИТБС-ын тайланд ийм заалтуудыг тодорхойлоогүй байв. Уул уурхайн салбарт мөнгөн бус орлогод зориулсан, заавал мөрдөх заалтууд байхгүй байгааг бид ойлгож байгаа ч газрын тос, шатдаг хийн БХГ-үүд нь тосны ашгийн хэмжээг тусгасан (хэлбэлзэлтэй) бөгөөд мөнгөн бус хэлбэрээс илүүгээр бэлнээр төлөгдөж байв. Эдгээр заалтын талаар энд тайлбарлаагүй бөгөөд тосны ашгийн бэлэн мөнгөн төлбөрийн харьцуулах тохируулгыг газрын тос, шатдаг хийн хоёр олборлогч Засгийн Газарт мэдээлсэн байв.

Тээврийн орлого (#4.1.f)

Явцын баримтжуулалт

2013 оны ОУИТБС-ын тайлангийн 7.3 Хэсэгт (107) “Ашигт малтмалд холбогдох 2013 оны тээврийн орлогыг улсад, эсвэл Засгийн Газрын байгууллагуудад тайлагнаагүй байна” гэж дурджээ. 2013 оны ОУИТБС-ын тайлангаас үзэхэд, олборлох үйлдвэрлэлд холбогдон Засгийн Газарт орсон тээврийн орлого байхгүй гэсэн утгатай юу, эсвэл ОУИТБС-ын явцад тээврийн тийм орлого бүртгэгдээгүй гэсэн утгатай юу гэдэг нь тодорхойгүй байна. Мөн тээврийн орлогын материаллаг байдлын тодорхойлолтыг авч үзээгүй бөгөөд үүнээс илүү ил болгосон нэмэлт мэдээлэл байхгүй байв.

Оролцогчдын санал

Зөвлөлдөх уулзалтанд оролцсон үйлдвэрлэлийн болон Засгийн Газрын оролцогч нар “Ашигт малтмал, газрын тос, шатдаг хийн тээврээс Засгийн Газар аливаа материаллаг орлого аваагүй” хэмээн дурдсан юм. Зөвлөлдөх уулзалтанд оролцсон, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгч нар тээврийн орлогын асуудлаар аливаа санаа бодол илэрхийлээгүй байв.

Үнэлгээ

Энэ шаардлага хангагдсан байна.

Бартер болон дэд бүтцийн төлбөр (#4.1.e)

Явцын баримтжуулалт

2013 оны ОУИТБС-ын тайлангийн 7.1 Хэсэгт (хуудас 101) “Төлбөр төлөгдсөн хэмжээгээр дэд бүтцийн зардлыг нийгмийн зардалтай хамт ил болгосон бөгөөд энэ хэсэгт оруулсан” гэж мэдээлжээ. Хүснэгт 56 (хуудас 103-104) –д нийтийн дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалтын мэдээллийг өгсөн байв. 7.1 Хэсэгт (хуудас 105) “Бартерын гэрээ хийгдээгүй” хэмээн мэдэгдсэн бөгөөд хоёроос бусад бүх компани баталгааны төлбөр хэлбэрээр дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийсэн тухай бас тайлбарлажээ. Энэ нь (“Терра Энержи”, “Саус Гоби Сэндс” ХХК) компаниуд болон Монгол улсын Засгийн Газар хооронд хийгдсэн Концессийн хоёр гэрээг (хуудас 104) мэдээлсэн байв. Ил болгосон мэдээллийн нарийвчлалын түвшин нь орлогын бусад урсгалд тохирч (компани болон тодорхой хөрөнгө оруулалтаар) байна. 2013 оны ОУИТБС-ын тайланд материаллаг байдлын тодорхойлолтыг оруулаагүй байв.

Оролцогчдын санал

Үйлдвэрлэлийн болон Засгийн Газрын оролцогч нартай хийсэн яриа хэлэлцүүлгээс Олон Улсын ОУИТБС-ын Ажлын Алба “бартерын гэрээнүүд хийгдэж байгааг”, тухайлбал, лиценз эзэмшигч нар өөрсдийн гүйцэтгэгч компаниудад мөнгөн бус (ашигт малтмалаар) төлбөр төлөхөд хэрэглэж байгааг, мөн 2012 оны дунд үеэс хойш, эдийн засгийн саарлын үеэр Монгол улсад ам долларын олдоц багасахын хэрээр бартер хийх нь нэмэгдсэнийг ойлгосон юм. Үйлдвэрлэлийн нэлээд хэдэн төлөөлөгч “иргэний нийгмийн байгууллагууд хувиараа үйлчилгээ үзүүлэгч нарт гэрээт уурхайн зардлаа төлөхийн тулд мөнгөн бус төлбөр ашиглаж байсан” хэмээн дурдсан байв. Гэхдээ үйлдвэрлэлийн болон Засгийн Газрын оролцогч нар “Засгийн Газарт татвар, хураамж төлөхөд

аливаа бартер хийгээгүй” гэсэн юм.

Үнэлгээ

Энэ шаардлага биелсэн гэж бид үзэж байна. ОҮИТБС-ын тайлан нь дэд бүтцийн хангамж, бартерын талаар хангалттай хамарч байв. Олон улсын ОҮИТБС-ын Ажлын Алба “уурхайн ордоо ашиглахын тулд гүйцэтгэгч нарыг ашиглах нь лиценз эзэмшигч нарт нийтлэг байдаг, тэдэнд төлбөр төлөхдөө олборлолтын хэсгээс өгдөг” гэж ойлгож байгаа ч Засгийн Газарт төлөх татвар, хураамжаа мөнгөн бус (ашигт малтмал, дэд бүтцийн алинаар ч) хэлбэрээр төлж байгаа аливаа компанийн талаар нотолгоо байхгүй байна.

Орон нутгийн шууд төлбөр (#4.2.d)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайлангийн Хүснэгт 3 (хуудас 9)-т аймаг, нийслэл, сум, дүүрэгт хийсэн орон нутгийн түвшний шууд төлбөрийн нийт хэмжээг жагсаасан байв. Хавсралт 18b (хуудас 173-175) нь компаниудаас байгаль орчинд оруулсан нийт хөрөнгө, нөхөн сэргээлтийн тусгай дансанд орон нутгийн удирдах байгууллагад оруулсан хөрөнгийг мэдээлжээ. ОҮИТБС-ын тайлан нь орон нутгийн шууд төлбөрийн материаллаг байдлын талаар ОТОБ-ын тодорхойлолтыг хамруулаагүй байв. Орон нутгийн эдгээр шууд төлбөрийг нийт дүнгээр нь ил болгосон (хуудас 122) бөгөөд аймаг, сумаар (Хавсралт 20, хуудас 190-200) мэдээлжээ. 2013 оны ОҮИТБС-ын тайланд нийт 20 аймгийн тайлан (олборлох үйлдвэрлэлийн компаниас материаллаг төлбөр авч байгаа нийт аймгууд), 120 сумын (олборлох үйлдвэрлэл явагдаж байгаа сумдын нийт тоо) тайланг оруулжээ.

Оролцогчдын санал

Сурталчлах болон мэдээлэл түгээх арга хэмжээнүүд болон орон нутгийн ОТОБ-ын хурлуудын үеэр ийм мэдээллийг хүчтэй шаарддаг учраас иргэний нийгмийн байгууллагуудын оролцогч нар орон нутгийн шууд төлбөрийг онцлон анхаардаг. Өөрсдийнх нь сумдад ажиллаж байгаа компаниуд хэр их хувь нэмэр оруулж байгааг орон нутгийн иргэдэд илүү сайн ойлгуулахын тулд ийм мэдээлэл нэн шаардлагатай гэж үйлдвэрлэлийн төлөөлөгч нар бас үздэг. Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгч “орон нутгийн ОТОБ байгуулах нь сум, аймгуудын ОҮИТБС-ын тайланг сайжруулахад тустай” хэмээн үзэж байв.

Үнэлгээ

ОҮИТБС-ын тайлан гаргалтанд орон нутгийн төлбөрийг оруулж байхын тулд ОТОАХ мэдэгдэхүйц алхмууд хийжээ. Орон нутгийн удирдах байгууллагуудад компаниас төлсөн төлбөрийг ил болгож байгаа ч орон нутгийн удирдах байгууллага хүлээж авсан мөнгөтэй тэдгээр төлбөрийг харьцуулах тохируулга хийхгүй, эсвэл ил болгосон мэдээллийг төлбөрийн урсгалаар задаргаа хийхгүй байна. Иймээс, нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж тооцогдож байна.

Төрийн өмчит компаниуд болон Засгийн Газар хоорондын төлбөр (#4.2.c)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд төрийн өмчит таван компаниас улсад төлсөн ноогдол ашгийн төлбөрийг мэдээлсэн (хуудас 48) ч төр хувь эзэмшиж байгаа бусад 99 компанийн хэд нь ноогдол ашиг төлсөн, эсвэл Засгийн Газарт өөр бусад төлбөр төлсөн тухай мэдээлээгүй байв. Бас төрийн өмчит 11 компанийн нарийвчилсан мэдээллийг оруулсан (хуудас 49-51) боловч төрийн өмчит компаниудын санхүүжилтийн бүтцийг тодорхойлоогүй байв.

2013 оны ОҮИТБС-ын тайланд төрийн өмчит уул уурхайн компаниудын хэд нь Засгийн Газрыг

төлөөлөн орлого хураасан эсэхийг, эсвэл 2013 онд Засгийн Газраас санхүүжилт авсан эсэхийг мэдээлээгүй байна. Засгийн Газрыг төлөөлөн орлого хураасан, эсвэл Засгийн Газраас төлбөр авсан газрын тос, шатдаг хийн төрийн өмчит компани байхгүй байв.

Оролцогчдын санал

“Эрдэнэс Монгол” компаниас оролцсон Засгийн Газрын төлөөлөгч “төрийн өмчит компаниудын санхүүжилтийн бүтцийг, эсвэл “Эрдэнэс Монгол”-д, эсвэл Төрийн Өмчийн Хороонд ноогдол ашиг төлсөн компанийн нийтэд нь ил болгоход хууль эрх зүйн саад байхгүй” хэмээн дурдсан юм.

Үнэлгээ

Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. Олборлох үйлдвэрлэлд ажиллаж байгаа, төрийн өмчит компаниудын үүрэг ролийг ОҮИТБС-ын тайланд бүрэн ил болгоогүй байна. “Эрдэнэс Таван Толгой”-д байгаа Хүний Хөгжлийн Санд 2011 онд 310 сая ам доллар төлсөн шигээр төрийн өмчит компаниуд урьд нь Засгийн Газрын бусад байгууллагад төлбөр төлж байсан ч тэдгээр төлбөрийг (болон тэдгээрийн материаллаг байдал) ОҮИТБС-ын тайланд ч, ОТОАХ-ын хурлуудад ч авч хэлэлцээгүй байв. Төрийн өмчит таван компаниас төлсөн ноогдол ашгийн төлбөрийн мэдээлэл бүрэн биш бөгөөд 99 компанийн үлдсэн бусад, төр хувь эзэмшдэг компани төлсөн ноогдол ашгийн талаар мэдээлэл орхигдсон байв. Тэдгээр шилжүүлгийн талаар Эрдэнэс Монгол, Төрийн Өмчийн Хороо, Сангийн Яамнаас авсан мэдээллийг төрийн өмчит компаниудын төлбөрийн тухай, тэдгээр компаниуд Засгийн Газартай хэрхэн харьцдаг тухай үндэсний хэлэлцүүлэгт хамруулахын тулд ОҮИТБС-ын тайланд оруулахыг ОТОАХ хүсэх боломжтой юм. Аажмаар Эрдэнэс Монгол компанийг арилжаанд голлосон, төрийн өмчийн удирдлагын байгууллага (Темасектэй төсөөтэй) болгон хувиргах төлөвлөгөөтэй байгаа учраас мэдээллийг ингэж ил болгох нь одоогийн практикийн ил тод байдлыг сайжруулах боломжтой юм.

Ил болгосон мэдээллийн цаг хугацаа, бүрэн байдал, найдвартай байдлын үнэлгээ (#2)

- Цаг хугацаа: 2013 оны ОҮИТБС-ын тайланг 2014 оны 12-р сард хэвлэж, 2015 оны 1-р сарын 13-нд Үндэсний Зөвлөл батлав.
- Бүрэн байдал: Мөнгөн бус орлого, бартер болон төрийн өмчит компаниуд, Засгийн Газар хоорондын төлбөрийн тухай мэдээллийг бүрэн ил болгоогүй байна. Засгийн Газрын мэдээллийн нэг талт ил болголтын бүрэн байдлыг баталсан баталгаа байхгүй байв.
- Найдвартай байдал: 2013 оны ОҮИТБС-ын тайланд харьцуулах тохируулга хийхийн тулд ашигласан мэдээлэл нь Засгийн Газрын байгууллага, эсвэл компаниудын хувьд чанарын хүчтэй батламжаар дэмжигдэхгүй байна. Орон нутгийн төлбөрийн материаллаг түвшний босго, дэд бүтцийн заалтууд, эсвэл бартерьг ОТОБ авч хэлэлцээгүй бололтой байна. Гэхдээ мэдээллийн найдвартай байдалд холбоотойгоор оролцогч нар аливаа гомдол гаргасан тухай Олон Улсын Ажлын Албанд мэдэгдээгүй байна.

Хүснэгт 4 - Үнэлгээний товч хүснэгт: Орлого цуглуулалт

ОҮИТБС-ын шаардлага	Гол дүгнэлт	ОҮИТБС-ын шаардлагыг хангасан эсэх тухай Баталгаажуулагчийн зөвлөмж ('Шаардлагатай')
---------------------	-------------	--

		заалтуудыг бөглөнө.)
Бүрэн байдал (#4.1.a, #4.2.a-b)	2013 оны 12-р сар, 2015 оны 7-р сард харьцуулах тохируулгад хамрагдсан компаниудын хувьд материаллаг түвшний босгыг хянасан боловч 2010 онд тогтоосон төлбөрийн материаллаг түвшний босго бага байгааг тайлбарлах талаар ОТОАХ ойрын үед хэлэлцээгүй байв. 2013 оны ОҮИТБС-ын тайланд орлогын урсгал бүрийг тодорхойлоогүй, Засгийн Газрын ил болгосон мэдээллийг бүрэн оруулаагүй байна. Зөрүүтэй зүйлсийн материаллаг түвшний босго гэж юу болох тухай тодорхой байдал дутаж байгаа учраас (нэг урсгал уу, эсвэл нийт үү) зөрүүтэй зүйлсийн материаллаг эсэх тухай мэдэгдлийг үнэлэхэд хэцүү юм.	Нэлээд ахиц гарсан ч шаардлага биелээгүй.
Өгөгдлийн чанар (#5)	Хараат бус хянагч-нэгтгэгчид зориулан Зорилгын тодорхойлолтыг боловсруулахад ОТОАХ-н оролцоо 2013, 2014 онд хязгаарлагдмал байсан бололтой. Тайлангийн загваруудыг жил тутам батлаагүй ч тэднийг батлах эцсийн эрхийг Засгийн Газар барьж байна. Үндэсний Статистикийн Хороо нь ОТОАХ-ын эсрэг ажилласан шинжгүй байв. Мэдээллийн чанарын баталгааны асуудал (компани, Засгийн Газрын аль алинд) болон харьцуулах тохируулга хийхийн өмнө мэдээллийн нууцлалыг хадгалах асуудал нь 2013 оны ОҮИТБС-ын тайланд чухал байв. 2014 оны ОҮИТБС-ын тайланд ашигласан цахим тайлангийн систем нь харьцуулах тохируулга хийхийн өмнө ОҮИТБС-ын санхүүгийн мэдээллийн нууцлалыг хангахыг хичээсэн ч мэдээллийн чанарын баталгааны бэрхшээлийг шийдсэн шинжгүй байв.	Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.
Татвар, бусад төлбөр (#4.1.b)	Засгийн Газарт орж байгаа бүх орлогын урсгалыг 2013 оны ОҮИТБС-ын тайланд хамруулжээ.	Шаардлагыг биелүүлсэн
Мөнгөн бус орлого (#4.1.c)	2013 оны ОҮИТБС-ын тайланд мөнгөн бус орлогыг улс цуглуулж авах талаар заагаагүй байв.	Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.

Тээврийн орлого (#4.1.f)	Ийм орлогын материаллаг түвшний босгыг тогтоогоогүй боловч тээврийн орлогыг Засгийн Газар авч байгаа эсэхийг ОТОАХ анхаарсан шинжгүй байна.	Шаардлагыг биелүүлсэн.
Бартер болон дэд бүтцийн төлбөр (#4.1.d)	2013 оны ОҮИТБС-ын тайланд дэд бүтцийн заалтуудыг мэдээлж, бартер хийгдээгүй гэж дурджээ.	Шаардлагыг биелүүлсэн
Орон нутгийн түвшний шууд төлбөр (#4.2.d)	Орон нутгийн шууд төлбөрийг ОТОАХ анхаарч, 2013 оны ОҮИТБС-ын тайланд ил болгожээ. Гэхдээ орлогын урсгалаар задаргаа хийгээгүй, орон нутагт төлсөн мөнгөтэй харьцуулан тохируулаагүй байна.	Нэлээд ахиц гарсан ч шаардлага биелээгүй.
Төрийн өмчит компаниуд, Засгийн Газар хоорондын төлбөр (#4.2.c)	Төрийн өмчит компаниуд, Засгийн Газар хоорондын төлбөрийг ОТОАХ авч үзсэн шинжгүй байв.	Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.
Ерөнхий үнэлгээ: Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.		
Баталгаажуулагчийн зөвлөмж: 1. Ил болгосон мэдээллийн бүрэн байдал болон тайлангийн чанарын хоорондын балансыг тэнцүүлэхийн тулд төлбөрийн материаллаг түвшний босгыг дахин авч хэлэлцэх талаар ОТОАХ авч үзэх нь зүйтэй. ОТОБ нь тайлангийн загваруудыг шинэчлэх журмын талаар Хараат бус хянагч-нэгтгэгчтэй хамтран Үндэсний Статистикийн Хороотой зөвшилцөж, эдгээр журмыг нийтэд таниулах хэрэгтэй. 2. Шаардлагатай сертификатын агуулгыг тайлан гаргагч байгууллагууд өөрчлөх чадвартай байгааг зогсоохын тулд цахим тайлангийн системд суулгасан, чанарын баталгаа гаргах ажиллагааны журмыг ОТОАХ дахин авч үзэх боломжтой юм. 3. Газрын тос, шатдаг хийн салбарт мөнгөн бус орлогыг улс цуглуулж авах заалтуудыг ОТОАХ тодорхойлох нь зүйтэй. 4. Төрийн өмчит компаниудад Засгийн Газрын эзэмшиж байгаа хувийг дахин тогтоох, улсын өмчийг удирдах нэг байгууллага болгох төлөвлөлт хийгдэж байгаа учир одоогийн практикийг ил болгох, эзэмшлийн хувийг дахин тогтоох чармайлтад олон нийтийн дэмжлэг авахын тулд ОҮИТБС-ын тайлангуудыг ашиглах хүсэлтийг ОТОАХ гаргах боломжтой байна. 5. Засгийн Газрын тайлан гаргах байгууллагуудын дотоод хүрээнд мэдээлэл цуглуулж авах ажлын үр дүнг сайжруулахын тулд Засгийн Газрын бүх агентлагийн хэмжээнд компаниудыг таних тоон кодтой болгох талаар авч үзэх нь зүйтэй юм.		

4. Орлогын менежмент ба хуваарилалт

4.1 Танилцуулга

Энэ хэсэгт орлогын менежмент, хуваарилалтад холбогдох ОҮИТБС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэх тухай мэдээлэл оруулав.

4.2 Үнэлгээ

Орон нутгийн шилжүүлэг (#4.2.e)

Явцын баримтжуулалт

2011 онд шинэчилсэн, Монгол улсын Төсвийн тухай Хууль нь орон нутагт олгох төлбөрийг Орон Нутгийн Хөгжлийн Сангаар (ОНХС) дамжуулан хийх тухай заасан бөгөөд тус Сан нь уул уурхайн роялти татварын 5%, газрын тос, шатдаг хий, уурхайн лицензийн хураамжийн 30%-г авч, газрын тосны нөөцийн татварын заалтын хүрээнд 20%-г аймаг, 10%-г газрын тос, шатдаг хийн хайгуул, олборлолт явагдаж байгаа сум нь авч байна. Сум, аймгийн хэрэгцээний талаар судалгаа явуулсны дараа ОНХС-ийн 60% болон 100%-г сум, аймгийн түвшний хөгжлийн санд олгодог (хуудас 56) болжээ. ОНХС-н талаар 3.8.3 Хэсэгт (хуудас 56) болон томъёог тайлбарлаж, 2013⁸² оны улсын төсвийн тодотголын талаар мэдээлжээ. 3.8 Хэсэгт орлого хуваарилалтын талаар (хуудас 54-55) тодорхойлж, олборлох үйлдвэрлэлээс улсын төсөвт оруулж байгаа төлбөрийг тайлбарлажээ. Орон нутгийн төлбөрийг дээр дурдсан томъёоны дагуу тодорхойлсон боловч орлого хуваах холбогдох томъёоны дагуу тооцсон дүн, шилжүүлсэн дүнгийн хооронд зөрүү байсан эсэх талаар дүгнээгүй байна. Мөн Засгийн Газар болон орон нутгийн холбогдох байгууллага бүрийн хооронд шилжүүлсэн бодит хэмжээг дүгнээгүй байв. 2013 оны ОҮИТБС-ын тайланд сум, аймгийн ОНХС-д олгосон мөнгөний зөвхөн нийт дүнг оруулжээ.

Хэдийгээр ОҮИТБС-ын Стандартад шаардаагүй боловч орон нутгийн төлбөрүүдэд харьцуулах тохируулга хийгээгүй, материаллаг аливаа зөрүү, эсвэл тохиолдлын шилжүүлгийн талаар дурдаагүй байв.

Оролцогчдын санал

Орон нутгийн төлбөрт баримталж байгаа зарчмын талаар иргэний нийгмийн байгууллагууд болон үйлдвэрлэлийн төлөөлөгч нар тодорхой санал гаргаагүй байв. Засгийн Газрын нэг төлөөлөгч “томъёоны дагуу аймаг, сумууд хүлээж авах ёстой мөнгөн дүн болон орон нутагт шилжүүлсэн төлбөрийн бодит түвшний хооронд аливаа зөрүү гарсан эсэх талаар ОТОАХ авч хэлэлцээгүй байна” хэмээн дурдсан юм.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. ОҮИТБС-ын тайланд ОНХС-ийн тухай нарийвчлан мэдээлсэн ч шилжүүлэхээр тооцсон дүн болон бодит шилжүүлгийн хооронд аливаа зөрүү гарсан эсэх талаар дүгнээгүй байв. Гэхдээ орон нутгийн удирдах байгууллагуудад санхүүжилт олгох томъёог тайлбарлаж, орон нутагт төлбөр төлсөн шилжүүлгүүдийг ил болгосон байв.

Орлогын хуваарилалт (#3.7)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд орлогын хуваарилалтыг харуулж, 3.7 Хэсэгт (хуудас 52-54) улсын төсөв, орон нутгийн төсөв, Хүний Хөгжлийн Сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн талаар мэдээлжээ. 3.5.10 Хэсэгт (хуудас 44) Хүний Хөгжлийн санг тайлбарлаж, 3.5.11 Хэсэгт (хуудас 44-45) Нийгмийн даатгалын Санг тайлбарлажээ. 3.8 Хэсэгт (хуудас 54-56) сангуудын эх үүсвэр, Хүний Хөгжлийн Сан, ОНХС-д оруулсан төлбөрийг мэдээлж, Төсвийн хуулийн гол заалтуудыг дурдсан байв. Хэдийгээр ОҮИТБС-ын Стандартад шаардаагүй боловч орлогыг ангилах

⁸² <http://www.iltod.gov.mn/?p=3095>

олон улсын болон дотоодын системийн талаар мэдээлээгүй байна. Гэхдээ олон улсын Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн ангиллыг мэдээлж, өгөгдлийн хураангуй загварыг бэлтгэжээ.

Оролцогчдын санал

Орлого хуваарилалтын тухай мэдээллийг ил болгох ОТОАХ-ийн зарчмын талаар оролцогчид тодорхой санал гаргаагүй байв.

Үнэлгээ

Энэ шаардлага биелсэн гэж бид үзэж байна.

Орлогын менежмент, зардлын тухай мэдээлэл (#3.8)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд тодорхой зорилгод хэрэглэх орлогын тухай тайлбарлаж, 3.8 Хэсэгт (хуудас 54-56) Хүний Хөгжлийн Сан, ОНХС доторхи тодорхой зорилгод хэрэглэх сангуудыг болон Төсвийн хуулийн ерөнхий заалтуудыг мэдээлжээ. Хэдийгээр ОҮИТБС-ын Стандартад шаардаагүй боловч эдгээр санг ашиглахын үр дүнг баталгаажуулах аргуудын тухай тодорхойлолт нь хязгаарлагдмал байна. Хэдийгээр ОҮИТБС-ын Стандартад шаардаагүй боловч, 4.6.2 Хэсэгт (хуудас 72) аудитын ажиллагааг тодорхойлсон (хязгаарлагдмал) ч дүгнэлт гаргаагүй (“Монгол улсын Үндэсний Аудитын Газрын өмнөөс хийгдсэн жил тутмын аудитад капитал хувьцааны хэсгээс Монголын Засгийн Газар хувь эзэмшиж байгаа байгууллага, компаниуд хамрагдах ёстой. Ажиллах болон тайлан гаргах стандартууд нь олон улсын стандартад нийцэх ёстой”) байв. Хэдийгээр ОҮИТБС-ын Стандартад шаардаагүй боловч төсвийн цикл, олборлолт, бүтээгдэхүүний үнийн таамаг, орлогын тогтвортой байдал, нөөцөөс хараат байдал, орлогын урьдчилсан тооцоонд холбогдох цаашдын аливаа мэдээллийг ОТОБ ил болгоогүй байв.

Оролцогчдын санал

Зөвлөгөөнд оролцсон ихэнх оролцогчид орлогын менежмент, зардлын тухай нэмэлт мэдээлэлд холбоотой аливаа санал гаргаагүй бөгөөд ОТОАХ-ийг заавал оролцуулах гэхгүйгээр ийм мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгч бэлтгэнэ хэмээн хүлээж буйгаа дурдсан юм. Иргэний нийгмийн байгууллагын хэд хэдэн төлөөлөгч “орон нутгийн түвшний оролцогчид буюу орон нутгийн захиргаа, иргэний нийгмийн аль аль нь сум, аймгийн түвшинд орлогыг хэрхэн ашиглаж байгаа талаар илүү мэдээлэл авах сонирхлоо илэрхийлсэн” хэмээн дурдаж байв. Гэхдээ “орлогыг хэрхэн ашиглаж байгаа тухай, эсвэл төсвийн гүйцэтгэлийн тухай илүү мэдээлэл оруулах зорилгоор ОҮИТБС-ын тайланг өргөтгөх талаар ОТОАХ авч үзээгүй байна” хэмээн дурдаж байв.

Үнэлгээ

“2013 оны ОҮИТБС-ын тайланд орлогын менежмент, зардлын тухай мэдээлэл оруулахын тулд ОТОАХ зарим чармайлт гаргасан” гэж бид үзэж байна. Эдгээр чармайлтыг дэмжсэн боловч тохирч буй эсэхийг үнэлэхэд харгалзаагүй байв.

Ил болгосон мэдээллийн цаг хугацаа, бүрэн байдал, найдвартай байдлын үнэлгээ (#2)

- Цаг хугацаа: 2013 оны ОҮИТБС-ын тайланг 2014 оны 12-р сард хэвлэж, 2015 оны 1-р сарын 13-нд Үндэсний Зөвлөл баталжээ.
- Бүрэн байдал: Орлого хуваарилалтын талаар өгсөн мэдээлэл нь бүрэн боловч орон нутгийн төлбөр, орлогын менежментийн тухай мэдээллийг цаашид нарийвчлан тодруулах хэрэгтэй байна.
- Найдвартай байдал: Мэдээллийн эх үүсвэр нь тогтвортой биш ч 2013 оны ОҮИТБС-ын тайланд

ОҮИТБС-ын Удирдах зөвлөлийн баримт бичиг 31-х-х
Туришлын баталгаажуулалтын тайлангийн төсөл: Монгол улс

оруулсан мэдээлэл нь Засгийн Газрын вэб хуудсуудад байгаа эх үүсвэрүүдийн мэдээллээр дэмжигдэж байв. Мэдээллийн найдвартай байдалд холбоотойгоор оролцогч нар аливаа санал гомдол гаргасан тухай Олон Улсын Ажлын Албанд мэдэгдээгүй байна.

Хүснэгт 5 - Үнэлгээний товч хүснэгт: Орлогын менежмент ба хуваарилалт

Үнэлгээний товч Хүснэгт:		
ОҮИТБС-ын шаардлага	Хураангуй дүгнэлт	ОҮИТБС-ын шаардлагыг хангасан эсэх тухай Баталгаажуулагчийн зөвлөмж ('Шаардлагатай' заалтуудыг бөглөнө.)
Орон нутгийн шилжүүлэг (#4.2.e)	Төсвийн гурван хуулийг орхисон ч орон нутгийн төлбөрийг тооцох томъёог 2013 оны ОҮИТБС-ын тайланд ил болгожээ. Гэхдээ бодит төлбөр болон тооцсон төлбөрийн хооронд зөрүү бий эсэх талаар мэдээлээгүй байв.	Нэлээд ахиц гарсан ч шаардлага биелээгүй.
Орлогын хуваарилалт (#3.7)	Орлогыг хэрхэн хуваарилсан талаар 2013 оны ОҮИТБС-ын тайланд ил болгожээ.	Шаардлагыг биелүүлсэн.
Орлогын менежмент, зардлын тухай мэдээлэл (#3.8)	2013 оны ОҮИТБС-ын тайланд тодорхой зорилгод хэрэглэх орлогын менежментийн талаар ил болгожээ.	Шаардлагыг биелүүлсэн.
Ерөнхий үнэлгээ: Энэ шаардлагыг биелүүлсэн.		
Баталгаажуулагчийн зөвлөмж: 1. Мөнгөний эрх олголтын одоогийн системийн үр дүнг үнэлж дүгнэх үндэслэл болгон, томъёоны дагуу шилжүүлэх ёстой төлбөр, бодитой төлсөн төлбөрийн хооронд аливаа зөрүү байгаа эсэхийг ил болгохыг ОТОАХ хүсэх боломжтой юм. 2. Хүний Хөгжлийн Сан, ОНХС төсвийг хэр үр дүнтэй зарцуулж байгааг авч үзэх талаар ОТОАХ хүсэх боломжтой юм. 3. Олборлох салбараас Монгол улс хараат байгаа талаар олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр ярилцах зорилгоор төсвийн цикл, олборлолт, бүтээгдэхүүний үнийн таамаг, орлогын тогтвортой байдал, нөөцөөс хараат байдал, орлогын урьдчилсан тооцоонд холбогдох цаашдын мэдээлэл авахыг ОТОБ хүсэх боломжтой байна.		

5. Нийгэм, эдийн засгийн зарцуулалт

5.1 Товч тодорхойлолт

Нийгэм, эдийн засгийн зарцуулалтанд (ТӨК-н төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр, нийгмийн зардлууд, олборлох салбараас эдийн засагт оруулах хувь нэмэр) холбогдох ОҮИТБС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэх талаар мэдээллийг энэ хэсэгт оруулав.

5.2 Үнэлгээ

Төрийн өмчит компаниудын төсвийн хөрөнгийн зарцуулалттай төстэй төлбөр (#3.6.b)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд төсвийн хөрөнгийн зарцуулалттай төстэй төлбөрийн материаллаг байдлын тодорхойлолтыг оруулаагүй байв. Төсвийн хөрөнгийн зарцуулалттай төстэй төлбөрийн зарцуулалтыг энэ тайланд дурдаагүй байна.

Төрийн өмчийн оролцоотой, дулааны нүүрс олборлож, төрийн өмчийн оролцоот цахилгаан станцуудад борлуулж байгаа Багануур, Шивээ Овоогийн борлуулалтын жишээг бид энд төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр⁸³-ийн жишээ болгон дурдав. Төрийн оролцоот нүүрс олборлогч компаниудаас олгож байгаа олговрыг улсын төсөвт жил тутам бүртгээгүй байна. Эдгээр нөхөн олговор нь Засгийн Газарт бүх зардлыг төлөөлж буй эсэх нь тодорхойгүй (*Оролцогчдын саналыг дороос үзнэ үү.*) байв. Төрийн өмчит компаниудаас нөхөн олговор авч байгаа/зохицуулсан нүүрсний эдгээр үнэ нь эцсийн хэрэглэгч нарт үүсэх эрчим хүчний үнийн хөнгөлөлтийг дэмжиж байна.

Оролцогчдын санал

Засгийн Газрын нэлээд хэдэн төлөөлөгч “төрийн өмчит компаниудын төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрийг ил болгоход эрх зүйн саад хориг байхгүй” хэмээн дурдсан юм. Засгийн Газрын хоёр төлөөлөгч “Төрийн оролцоот нүүрс олборлогч компаниудад олгож байгаа олговрыг жил бүрийн улсын төсөвт бүртгэж байгаа бөгөөд төрийн өмчит цахилгаан станцуудад нүүрсийг хөнгөлөлттэй үнээр борлуулсан зардлын зөвхөн хэсэг нь болдог” хэмээн дурдсан юм. Дулааны нүүрсийг дотоодод борлуулах үнийг Засгийн Газар тогтоож байгаа ч төрийн өмчит нүүрсний компаниудад олгосон олговор нь уг олговрын нэгээхэн хэсэг нь болж, борлуулах үнийг хөдөлгөхгүй барьж буйгаас болж нүүрс олборлогч нарын ашгийн түвшин буурдаг” хэмээн дурдаж байв.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. ОҮИТБС-ын тайланд төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр, эсвэл нөхөн олговрын талаар дурдаагүй байв. Энэ асуудал нь төрийн өмчит цахилгаан станцуудад (бусад ашигт малтмал олборлогч нар ч энд бас хамрагдаж болзошгүй боловч) дулааны нүүрс борлуулахад холбогдох чухал асуудал болж байна. Уул уурхайн салбарын нөхөн олговрын талаар илүү нарийвчилсан тайлбар оруулахыг ОТОАХ хүсэх боломжтой юм. Мөн эрчим хүчний салбарт улсаас шууд бусаар олгож байгаа төрөл бүрийн олговрын талаар тодруулах хэрэгсэл хэлбэрээр ОҮИТБС-ын тайланг ОТОАХ ашиглах боломжтой юм. Эрчим хүчний салбарт шинэчлэл хийхээр Засгийн Газар төлөвлөж байгаа учраас ингэх нь илүү чухал болох талтай юм.

Нийгмийн зардлууд (#4.1.e)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд нийгмийн зардлын тухай мэдээлэл оруулсан ч заавал төлөх болон сайн дураар төлөх нийгмийн зардлуудыг хооронд нь ялгаж зааглаагүй байна. Тус тайлан нь заавал төлөх нийгмийн зардалд холбогдох материаллаг байдлын тухай ОТОБ-ын тодорхойлолтыг

⁸³ Азийн Хөгжлийн Банк (2013 оны 9-р сар), “Монгол улс: Эрчим хүчний салбарын хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх нь” (хуудас 15), <http://www.adb.org/sites/default/files/project-document/81826/43079-012-tacr-01f.pdf>

хамруулаагүй ч бүх төлбөрийн хувьд 10,000 төгрөгийн материаллаг түвшний босго тогтоосон хэмээн таамагласан байв.

7.1 Хэсэгт (хуудас 104-105) Засгийн Газрын байгууллагууд, орон нутгийн нийгэмд компаниудын төлсөн нийгмийн зардлыг тодорхойлсон байв. 7.2 Хэсэгт (хуудас 105-107) компаниудаас төрийн байгууллагуудад өгсөн хандив, дэмжлэгийг мэдээлж (7.2.a), орон нутгийн захиргаанд өгсөн хандив, дэмжлэгийг бас мэдээлжээ (7.2.b). 19-р Хавсралтад (хуудас 176-188) компаниудаас төвийн болон орон нутгийн байгууллагуудад өгсөн хандив, дэмжлэгийг мэдээлсэн байв. Гэхдээ заавал төлөх болон сайн дураар төлөх нийгмийн зардлуудыг хооронд нь ялгаж зааглаагүй учир ОҮИТБС-ын тайланд сайн дурын/удирдлагын шийдсэн нийгмийн зардлын ил болгосон мэдээллийг оруулсан эсэх нь тодорхойгүй байна.

Оролцогчдын санал

Засгийн Газрын болон үйлдвэрлэлийн хэд хэдэн төлөөлөгч нар “нийгмийн зардлыг буруу ангилсан нь ОҮИТБС-ын харьцуулах тохируулгуудад зөрүү гарсны үндсэн шалтгаануудын нэг болж байна” хэмээн дурдсан юм. Засгийн Газарт компаниуд хандив өгөхийг Монгол улсын хуулиар хориглосон учир орон нутгийн захиргааны байгууллагууд (сум, аймгийн түвшний) компаниудаас авсан хандиваа барилгын ажил, эсвэл хураамж зэргээр дахин ангилж, компаниуд нь усан хангамж зэрэг нийгмийн дэд бүтцийг мэдээлснээс энэ нь шалтгаалж болдог байна.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. ОҮИТБС-ын тайланд компаниудын нийгмийн зардлыг ил болгосон ч заавал төлөх болон сайн дураар төлөх нийгмийн зардлуудыг хооронд нь ялгаж зааглаагүй юм. ОТОАХ-ын хурлын тэмдэглэлээс үзэхэд ингэж зааглаж ялгах талаар авч хэлэлцээгүй байв. “Заавал төлөх ёстой нийгмийн зардлууд байгаа юм байна, жишээ нь Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын Гэрээнд нийгмийн тодорхой зардлууд төлөхийг шаардсан⁸⁴ байна” гэж бид ойлгосон юм. Компаниудын оруулж буй, удирдлагаас шийдэж олгосон хувь нэмрийг болон хуульд заасны дагуу төлөх ёстой хувь нэмрийг илүү сайн үнэлж дүгнэхийн тулд, заавал төлөх болон сайн дураар төлөх нийгмийн зардлуудыг хооронд нь тодорхой ялгаж зааглах хүсэлтийг ОТОАХ, эсвэл тухайлбал иргэний нийгмийн байгууллага өөрсдийгөө дэмжих үндэслэл байдлаар гаргаж болох юм.

Олборлох салбараас эдийн засагт оруулах хувь нэмэр (#3.4)

Явцын баримтжуулалт

2013 оны ОҮИТБС-ын тайланд олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийн талаар хязгаарлагдмал мэдээлэл оруулсан байв. 3.4 Хэсэгт (хуудас 38-39) уул уурхайгаас эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг ерөнхий мэдээлсэн боловч газрын тос, шатдаг хийн мэдээллийг оруулаагүй байв. Энэ мэдээлэлд “ДНБ-нд уул уурхайн эзэлж байгаа хэмжээг дурдсан ч нэрлэсэн нөхцлөөр мэдээлээгүй байлаа. 3.1.10 Хэсэгт (хуудас 30-31) бичил болон жижиг хэмжээний уурхайн талаар мэдээлсэн ч олборлох үйлдвэрлэлд эзэлж байгаа хэмжээг дурдаагүй (гар аргын, жижиг уурхайн, эсвэл албан бус бүх ажиллагааг хамруулан) байв.

ОҮИТБС-ын тайланд уул уурхайн экспортын нийт хэмжээ (нийт дүнгээр), газрын тос, шатдаг хийн экспортыг (нийт дүнгээр) нэрлэсэн нөхцлөөр, нийт экспортод эзлэх хэмжээг нь тооцон (хуудас 40) мэдээлжээ. Ажил эрхлэлтийн үзүүлэлтийн хувьд, 3.4.1.3 Хэсэгт (хуудас 40-41) ажил эрхлэлтийн

⁸⁴ Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний 4-р бүлэг (хуудас 14-15),
http://www.turquoisehill.com/i/pdf/Oyu_Tolgoi_IA_ENG.PDF

мэдээллийг абсолют нөхцлөөр, нийт ажил эрхлэлтэнд эзлэх хэмжээгээр мэдээлсэн ч зөвхөн уул уурхайг дурдаад, газрын тос, шатдаг хийн салбарыг орхисон байв. 21-р Хавсралтад (хуудас 202-205) ажил эрхлэлтийн мэдээллийг компаниар гаргаж, үндсэн ажилчид, гүйцэтгэгч, дотоодын, гадаадын ажиллах хүчийг ялган мэдээлжээ.

Олборлох үйлдвэрлэлийн газар зүйн байршлын хувьд, 3.1 Хэсэгт (хуудас 25) стратегийн ач холбогдолтой ордуудын зургийг оруулж, 3.2.1.1 Хэсэгт газрын тос, шатдаг хийн блокуудын зураг оруулжээ. Уул уурхайг бүрэн хамарсан газрын зураг оруулаагүй бөгөөд 2013 оны ОҮИТБС-ын тайланд зэсийн олборлолт хийгдэж байгаа байршлыг л зөвхөн тайлбарласан байна. Гэхдээ ашигт малтмалын бусад томоохон олборлолтын ажлууд хаана явагдаж байгааг мэдээлээгүй байв.

Оролцогчдын санал:

Засгийн Газрын нэг төлөөлөгч “гар аргын, эсвэл жижиг уурхайн тухай танилцуулга нь албан бус уурхайн бүх ажиллагааг үнэлэхэд хангалттай эсэх” талаар асууж байв. Албан бус уурхайн үйл ажиллагааны тухай мэдээлэл нь ОҮИТБС-ын Стандартын шаардлагаас давсан нэмэлт мэдээлэл өгсөн ч тухайн салбартаа эзлэх хувийг тооцоогүй байна.

Үнэлгээ

Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй гэж бид үзэж байна. ОҮИТБС-ын тайланд эдийн засагт оруулж байгаа уул уурхайн хувь нэмрийг ДНБ-нд эзэлж байгаа хэмжээгээр ерөнхийлөн дурдсан ч нэрлэсэн нөхцлөөр мэдээлээгүй байв. Мөн газрын тос, шатдаг хийн салбарын хувьд энэ мэдээллийг орхигдуулсан байна. Стратегийн ач холбогдолтой ордуудын зургийг оруулж, газрын тос, шатдаг хийн блокуудын зураг оруулсан ч уул уурхайн бүх ажиллагааг бүрэн хамарсан газрын зураг оруулаагүй байв. Одоо энэ мэдээллийг цахим тайлангийн вэб хуудсанд оруулсан байгаа ч 2013 оны ОҮИТБС-ын тайланд линкийг нь хамруулаагүй байна. Гэхдээ ОҮИТБС-ын үндсэн шаардлагыг давуулж биелүүлэн, ажил эрхлэлтийн нарийвчилсан мэдээллийг ОТОАХ ил болгож, уурхай бүрээр, ажилчдын яс үндэс зэргийг мэдээлсэн ч газрын тос, шатдаг хийн салбарын хувьд энэ мэдээллийг орхигдуулсан байлаа. Энэ нь үндэсний хэлэлцүүлэгт холбогдох болон бусад хэрэгтэй мэдээллийг ил болгоход ОҮИТБС-ын тайланг хэрхэн ашиглаж болохын жишээ юм. Олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулж буй хувь нэмрийн талаар илүү иж бүрэн мэдээллийг үндэсний хэлэлцүүлэгт зориулан оруулах талаар авч үзэхийг ОТОАХ хүсэх боломжтой юм.

Ил болгосон мэдээллийн цаг хугацаа, бүрэн байдал, найдвартай байдлын үнэлгээ (#2)

- Цаг хугацаа: 2013 оны ОҮИТБС-ын тайланг 2014 оны 12-р сард хэвлэж, 2015 оны 1-р сарын 13-нд Үндэсний Зөвлөл баталжээ.
- Бүрэн байдал: Төрийн өмчит компаниудын төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрийн болон олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулж буй хувь нэмрийн талаар мэдээлэл бүрэн биш байв. Нийгмийн зардлууд нь заавал төлөх болон сайн дураар төлөх нийгмийн зардлуудыг хоёуланг нь хамарсан эсэх талаар тодорхой бус байна. Төрийн өмчит компаниудын төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрийг ОТОБ авч үзээгүй бололтой байв.
- Найдвартай байдал: Мэдээллийн эх үүсвэр нь тогтвортой биш ч 2013 оны ОҮИТБС-ын тайланд оруулсан мэдээлэл нь Засгийн Газрын вэб хуудсуудад байгаа эх үүсвэрүүдийн мэдээллээр дэмжигдэж байв. Мэдээллийн найдвартай байдалд холбоотойгоор оролцогч нар аливаа санал гомдол гаргасан тухай Олон Улсын Ажлын Албанд мэдэгдээгүй байна.

Хүснэгт 6 - Үнэлгээний товч хүснэгт: Нийгэм, эдийн засгийн зарцуулалт

ОҮИТБС-ын шаардлага	Гол дүгнэлт	ОҮИТБС-ын шаардлагыг хангасан эсэх тухай Баталгаажуулагчийн зөвлөмж ('Шаардлагатай' заалтуудыг бөглөнө.)
Төрийн өмчит компаниудын төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр (#3.6.b)	2013 оны ОҮИТБС-ын тайланд төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрийн мэдээллийг ил болгоогүй байна. Төрийн өмчит уурхайнууд цахилгаан станцуудад нүүрсээ хөнгөлөлттэй үнээр борлуулж буйг нийгэмд өргөн мэддэг ч ийм зарцуулалт хийгдэж байгаа эсэх талаар ОТОАХ авч хэлэлцээгүй бололтой байв.	Хязгаарлагдмал ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.
Нийгмийн зардлууд (#4.1.e)	Нийгмийн зардлуудыг ОТОАХ нарийвчлан авч үзэн, 2013 оны ОҮИТБС-ын тайланд ил болгосон ч заавал төлөх болон сайн дураар төлөх нийгмийн зардлуудыг ялгаж салгах талаар авч үзсэн шинжгүй байна.	Нэлээд ахиц гарсан ч шаардлага биелээгүй.
Олборлох салбараас эдийн засагт орох хувь нэмэр (#3.4)	2013 оны ОҮИТБС-ын тайланд эдийн засагт оруулж байгаа уул уурхайн хувь нэмрийг ДНБ-д эзэлж байгаа хэмжээгээр нь дурдсан ч нэрлэсэн нөхцлөөр мэдээлээгүй, газрын тос, шатдаг хийн ДНБ-г дурдаагүй байв.	Нэлээд ахиц гарсан ч шаардлага биелээгүй.
Ерөнхий үнэлгээ: Нэлээд ахиц гарсан ч энэ шаардлага биелээгүй.		
Баталгаажуулагчийн зөвлөмж: 1. Уул уурхайн салбарт хэрэглэж байгаа нөхөн олговрын талаар ОТОАХ авч үзэх нь зүйтэй. Эрчим хүчний салбарт шинэчлэл хийхээр Засгийн Газар хичээж байгаа учраас улсаас олгож буй шууд болон шууд бус нөхөн олговрыг тодорхой болгох хэрэгсэл хэлбэрээр ОҮИТБС-ын тайланг ОТОАХ ашиглах боломжтой юм. 2. Заавал төлөх болон сайн дураар төлөх нийгмийн зардлуудыг хооронд нь тодорхой ялгаж зааглах талаар ОТОАХ болон иргэний нийгмийн байгууллага авч үзэх нь зүйтэй. 3. Олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулж байгаа бүх хувь нэмрийг абсолют нөхцлөөр болон ДНБ-нд харьцуулан ОТОАХ авч үзэх нь зүйтэй. Ингэвэл уул уурхайн үйлдвэрлэлээс эдийн засагт өгч байгаа үлэмж өгөөжийн тухай үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт дэмжлэг болно.		

Хэсэг III – Үр дүн ба нөлөөлөл

1. Товч танилцуулга

Олборлох Үйлдвэрлэлийн ил тод байдлын Санаачилгын (ОҮИТБС) үйл явцын үр дүн, нөлөөнд холбогдох, ОҮИТБС-ын шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг энэ хэсэгт орууллаа.

2. Үнэлгээ

2.1.1 Олон нийтийн хэлэлцүүлэг (#6.1)

Явцын баримтжуулалт

Харилцаа: 2013 оны сүүл үеэр ОҮИТБС-ын ажлын алба өөрийн харилцааны стратегийн дагуу ОҮИТБС-ын талаар нийгэм, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслийн компанит ажил хэрэгжүүлэх зорилгоор “Mongol Mass Media” ХХК-тай гэрээ байгуулсан юм. Гэрээний хүрээнд телевизийн 12 цуврал нэвтрүүлэг, 5 ярилцлагыг олон нийтэд хүргэсэн бөгөөд www.news.mn вэб сайтад таван нийтлэл онцлон тавигдаж, гурван үйл явдлыг телевизээр үзүүлсэн. ОҮИТБС –ын тухай сурвалжлагыг Bloomberg Mongolia TV, TV9, TV8, Eagle TV, Eco TV зэрэг телевизийн үндсэн сувгуудаар үзүүлэв. Түүнчлэн хэрэглэгчдэд илүү эвтэйхэн болгох, ОҮИТБС-ын тайланг ашиглах түвшинг, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд ОҮИТБС-ын ажлын алба нь www.eitimongolia.mn вэб сайтыг өөрчлөн зохион байгуулсан юм. 2012 оны ОҮИТБС-ын тайланг ашиглан хэд хэдэн инфографик мэдээлэл бэлтгэж, ОҮИТБС-ын вэб сайт болон www.ikon.mn мэдээллийн вэб сайтад нийтэлжээ.

2015 онд ОҮИТБС-ын ажлын алба монгол хэлээр хэвлэгддэг “Үндэсний шуудан” сонины газартай гэрээ байгуулж, 2013 оны ОҮИТБС-ын тайлангийн (1-7 дугаар сарын тайлан) дүгнэлтэд тусгасан асуудлуудаар таван нийтлэл хэвлүүлэхээр тохиролцов. 2013 оны ОҮИТБС-ын тайланд бенефициарь өмчлөгчийн ил болгосон мэдээллээр 2015 оны эхээр интерактив инфографик мэдээлэл бас бэлтгэлээ. Түүнчлэн 2014 оны 9-р сараас хойш ажлын албанд бүртгэлтэй байдаг 400 холбогдох хаягийн мэдээллийн сан руу сар тутмын мэдээллийн эмхтгэлийг илгээсэн.

Мөн тус байгууллага олон нийтийн сүлжээг ашиглан харилцаа холбоог сайжруулах стратеги баримталж байна. 2014 оны 10-р сард ажиллуулж эхэлсэн ОҮИТБС-ын Фейсбүк хуудас⁸⁵ 2015 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар 299 дагагчтай болж, 2014 оны 6-р сард ажиллуулж эхэлсэн ОҮИТБС-ын Twitter аккаунт⁸⁶ 160 дагагчтай, YouTube хуудас⁸⁷ нь 12 видеотой, Flickr аккаунт⁸⁸ нь 19 зургийн цомогтой болсон байна. Тус байгууллагын Flickr аккаунт дөнгөж хоёр дагагчтай байх үед ОҮИТБС-ын ажлын алба зургууд байршуулахын тулд энэ хэрэгслийг голлон ашиглаж, дараа нь холбогдох хаягууд руу электрон шуудан явуулан мэдэгдэж байсан учир дагагчдын тоонд мэдээлэл хүргэх энэ хэрэгслийн нөлөөг оруулаагүй тооцсон байх магадлалтай юм. ОҮИТБС-ын тухай мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хэрхэн хүргэж буйг ажиглах, нөлөөлөлд анализ хийхийн тулд ОҮИТБС-ын ажлын алба нь хэвлэл мэдээллийн зөвлөгөө өгөх дотоодын “Максима Медиа” фирмтэй гэрээ байгуулахаар төлөвлөж байна. Гэсэн ч ажлын алба болон Үндэсний Зөвлөлөөс санал

⁸⁵ <https://www.facebook.com/EITIMongolia/>

⁸⁶ <https://twitter.com/eitimongolia>

⁸⁷ <https://www.youtube.com/user/eitimongoliamn/videos>

⁸⁸ <https://www.flickr.com/photos/123397335@N02/albums>

дэвшүүлж, Олон Талын Оролцоот Ажлын Хэсгийн 34 дэх хурлаар 2013 оны 12-р сарын 13-нд авч хэлэлцсэн, мэдээ, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг сайжруулах талаар хийсэн судалгаа нь ОУИТБС-ын мэдээ, мэдээллийг түгээхийн тулд илүү хүчин чармайлт гаргах хэрэгтэй байгааг харуулж байв. Орон нутгийн түвшинд хүрч ажиллах болон хэрэгжүүлэх стратеги нь уул уурхайн нөлөөнд өртөж байгаа иргэд, олон нийтийн илүү өргөн хүрээг хамрах (орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх талаар дороос үзнэ үү) юм. 2015 оны 11-р сарын 10-нд ОУИТБС-ын ажлын алба нь “Монголиан Майнинг” сэтгүүлийн редакцтай хамтран ОУИТБС-ын тайлангуудыг хэрхэн унших, тайлбарлах зэрэг сэдвүүдийг хамруулан орон нутгийн 52 сэтгүүлчдэд сургалт явуулжээ.

Хурч ажиллах: ОУИТБС-ын ажлын алба сүүлийн жилүүдэд сургалт, мэдээлэл хүргэх зэрэг арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж байна. 2013 онд “Адам Смит Интернешнл” байгууллага, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны (ЕСБХБ) дэмжлэгээр тус ажлын алба нь Олон Талын Оролцоот Бүлэгтэй хамтран Улаанбаатар хот болон дөрвөн аймагт (Дархан-уул, Ховд, Говь-Алтай, Хэнтий) ийм арга хэмжээг Монгол улсын 21 аймгийн 20 аймгаас ирсэн 700 орчим хүмүүсийг хамруулан зохион байгуулсан байна. Тус ажлын алба нь эдгээр сургалт, арга хэмжээний үеэр нийт 25 сургагч, 20 сэтгүүлчдэд сургалт явуулжээ.

2014 онд Олон Талт Оролцоот Бүлэг болон ОУИТБС-ын Ажлын алба нь орон нутгийн есөн суманд мэдээлэл хүргэх арга хэмжээ, хөдөлгөөнт компанит ажил зохион байгуулж, орон нутгийн нийт 619 хүнийг хамруулжээ. Эдгээр арга хэмжээний үеэр анх удаа аймаг, сумын түвшинд ОУИТБС-ын хураангуй тайлангуудыг бэлтгэсэн байна. Ажлын алба 2014, 2015 онд аймгийн түвшинд боловсруулсан ОУИТБС-ын хураангуй дөрвөн тайлан гаргаж, сумын түвшний 12 тайлан бэлтгэж нийт 4800 хувийг түгээжээ.⁸⁹ Германы Олон улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг 2013 оны ОУИТБС-ын тайланд үндэслэн, сум, аймгийн түвшний хураангуй гурван тайлан бэлтгэж, хэвлэгдсэн мэдээ мэдээллийг хүмүүс олж унших, авах боломжийг сайжруулахын тулд “Монголиан Майнинг” сэтгүүлтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан юм. Түүнчлэн ОУИТБС-ын Ажлын алба 2014 онд эдгээр есөн сумын таван суманд (120 оролцогчтой), 2015 онд гурван суманд судалгаа (102 оролцогчтой) судалгаа явуулж, олборлох үйлдвэрлэлийн талаар ямар мэдээлэл тэдэнд олдож байгаа, мөн ямар мэдээлэл тэдэнд хамгийн сонирхолтой байх талаар оршин суугчдаас асуулга авчээ. Хариулт өгсөн оролцогч нар дараах сэдвүүдийг онцлон дурдаж байв: байгаль орчныг нөхөн сэргээх (20%), хандив тусламж (25%), ажлын байр бий болгох (15%), нийгэм олон нийтийг хөгжүүлэх гэрээнүүд (15%), татвар (10%), нөөцүүд (10%), тусгай зөвшөөрөл (5%) болон бенефициарь эзэмшил г.м. 2015 онд ОУИТБС-ын Ажлын алба, Олон Талын Оролцоот Бүлэг хамтран ОУИТБС-ын Нээлттэй Өдрүүдийг орон нутагт дөрвөн удаа (гурван дүүрэг, нэг аймагт) явуулж, ОУИТБС-ын бүсийн чуулган 2015 онд Баруун, Хойд, Өмнөд бүс нутагт гурван удаа хийсэн бөгөөд 2016 онд бүсийн чуулганыг Зүүн бүс нутагт хийхээр төлөвлөж байна. Эдгээр хурлууд нь туршлага хуваалцах, мэдээлэл солилцоог сайжруулах зорилгоор зохион байгуулагдсан бөгөөд харин Нээлттэй Өдрүүд нь эдгээр өдрүүд зохиогдож байгаа аймаг, сумдад явагдаж буй уул уурхайн үйл ажиллагааны талаар илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан мэдээлэл өгөх зорилгоор зохиогджээ.

2015 онд явуулсан Нээлттэй Өдрүүдийн үеэр аймаг, сумдад хийсэн хэлэлцүүлэг нь Нарийн бичгийн газрын дүгнэснээр мэдээлэл илүү шаардагдаж байгаа дараах гурван үндсэн чиглэлийг хамран хөндсөн юм:

- Уул уурхайн тодорхой ажлууд явагдах хугацаа, ажил эрхлэлтэд үүсэх нөлөө,
- Тусгай зөвшөөрөл олгох үйл явц

⁸⁹ ОУИТБС-ын Монгол дахь Нарийн бичгийн газрын харилцаа хариуцсан ажилтан хадагтай Дэлгэрмаагийн ярилцлага болон 2015 оны 11 сарын 3-ны Үндэсний форумын баримт бичиг.

- Уул уурхайн ашиглалтаас байгаль орчинд үүсэх нөлөөлөл (ялангуяа ус ашиглалт, орон нутгийн газар тариаланд үүсэх нөлөө) болон байгаль орчны доройтолд Засгийн Газраас үзүүлэх хариу үйлдлүүд.

Түүнчлэн ОҮИТБС-ын Ажлын алба 2014, 2015 онд “Коул Транс” чуулган, хөрөнгө оруулалтын “Дисковер Монголия” чуулган, Уул уурхайн Яамны Нээлттэй Өдөр зэргийг хамарсан олон улсын болон дотоодын хэд хэдэн конференци хуралд оролцож, мэдээлэл, сурталчилгааны материалууд тараасан юм. Мөн тус Нарийн бичгийн газраас 2015 онд хувь нийлүүлэгчдийн бүлэг бүрт зориулан сургалтууд зохион байгуулжээ. Тухайлбал Эксел программын дэлгэмэл хуудаснууд ашиглан 2013 оны ОҮИТБС-ын тайлангаас мэдээ, мэдээллийг хэрхэн олж авах тухай сургалтыг Иргэний нийгмийн байгууллагуудад (Төлсөн авснаа нийтэл эвсэл болон Монголын Байгаль орчны иргэний Зөвлөлд) зориулан 2015 оны 4-р сард тус Ажлын алба зохион байгуулав. 2015 оны 2, 3-р сард тус Ажлын алба хоёр удаагийн сургалтыг Засгийн Газрын байгууллагуудад зориулж, нэг сургалтыг компани, аж ахуйн нэгжүүдэд зориулан 2013 оны ОҮИТБС-ын тайлангаар ил болгосон мэдээллийн чанарыг хэрхэн сайжруулах талаар явуулав.

Хэдийгээр Монгол улсын Засгийн Газрын 2012 оны 222-р Тогтоолоор “ОҮИТБС-ын тайлангуудыг жилд нэг удаа УИХ-ын Эдийн Засгийн Байнгын Хороонд хүргүүлж байхаар” заасан ч энэ ажил практикт огт хэрэгжээгүй юм. Хэдийгээр бидний ярилцсан зарим Иргэний нийгмийн байгууллагууд “Ерөнхий Сайд Үндэсний Зөвлөлийг даргалж байгаа учраас үүнийг хийх бүрэн эрхтэй нь тодорхой” хэмээн маргаж байгаа ч ОҮИТБС-ын тайланг УИХ-д ямар байгууллага (Төрийн нарийн бичиг, Уул Уурхайн Яам гэх мэт) хүргэх талаар тодорхой заавар дутсанаас энэ байдал үүдэлтэй хэмээн ОҮИТБС-ын Ажлын алба үзэж байна. 2014 оны 12-р сараас 2015 оны 3-р сар хүртэл хугацаанд УИХ-ын гишүүдэд зориулан олборлох үйлдвэрлэлийн засаглалын талаар сургалтын хөтөлбөрийг Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэн (ББЗХ) хэрэгжүүлсэн юм. Энэхүү хөтөлбөр нь ОҮИТБС-ын талаар нэг модуль бүтэцтэй сургалтыг агуулж байна.

Орон нутгийн хэрэгжилт: Монгол улсын Засгийн Газрын 2012 оны 7-р сарын 4-ний өдрийн 222-р Тогтоол нь олборлох үйлдвэрлэл явагдаж байгаа бүх аймаг, сумууд ОҮИТБС-ын орон нутгийн Зөвлөлүүд байгуулахаар заасан юм. Монгол улсын бүх 21 аймагт болон нийт 329 сумын 103 суманд олборлох үйлдвэрлэл явагдаж байна. 2015 оны дунд үед 20 аймаг, 14 сум ОҮИТБС-ын орон нутгийн Зөвлөлүүдийг Иргэний нийгмийн “Төлсөн авснаа нийтэл” байгууллагын зөвлөмжийн дагуу байгуулсан ч тэдгээр зөвлөлийг (нийт 20 аймагт байгуулсан ч, дөнгөж 7 суманд л байгуулсан) байгуулсан тухай тушаал, зааврын албан ёсны мэдэгдэл нь Ажлын албат бүрэн ирээгүй байна. Тус Тогтоол нь орон нутгийн тэдгээр зөвлөлийг байгуулахад нутгийн удирдах байгууллагын үүрэг роль, хариуцлагыг тодорхой зааж өгсөн бөгөөд 11.2 Заалт нь “хөрөнгө оруулагчдын гурван бүлгийн төлөөлөл нь тооны хувьд тэнцүү байх ёстой” тухай заасан юм. Аймаг, сумын түвшний орон нутгийн Зөвлөлүүдийн үүрэг роль нь ОҮИТБС-ын тайлан гаргахад туслах, ОҮИТБС-ыг орон нутгийн түвшинд өргөжүүлэх, орон нутгийн удирдах байгууллага, олон нийт, компаниуд хооронд санал сонсох хэлэлцүүлгийг дэмжих, орон нутгийн хөгжлийн асуудлуудыг шийдэхэд түлхүү анхаарах явдал юм. Тус Тогтоол нь орон нутгийн Зөвлөлийн ажиллах журмыг тогтоож өгөөгүй, орон нутгийн Зөвлөлийн болон Үндэсний Зөвлөл, Олон Талын Оролцоот Ажлын Хэсгийн хоорондын холбоо харилцааг тодорхойлоогүй, мөн санхүүжих эх үүсвэрийг зааж өгөөгүй байна. Гэхдээ тус Тогтоол нь тайлагнах загваруудад тодорхойлсноос өргөн хүрээнд мэдээллийг ил болгох тухай зохицуулалт оруулж, байгаль орчныг нөхөн сэргээх сангууд, зарцуулалтын талаар зааж өгсөн байв. Хурал явуулах нөхцөл нь сум, аймгаас хамааран ялгаатай бөгөөд хэдийгээр бидэнтэй уулзсан, орон нутгийн 20 Зөвлөлийн төлөөлөгч нар “хамрагдах олон нийтийн тоо бага байх тусам хурал зохион байгуулахад хялбар болж байсныг” тэмдэглэн хэлж байсан ч Орон нутгийн зарим Зөвлөл сар тутам хурлаа хийж байхад зарим зөвлөл хавьгүй цөөн тоогоор хурал хийж байв.

Хэдийгээр зохион байгуулах бэрхшээлүүд учирч байсан ч, бидэнтэй уулзсан орон нутгийн удирдах байгууллагууд, орон нутгийн иргэний нийгмийн аль алины 20 төлөөлөгч “Засгийн Газрын төвийн байгууллагууд, компаниудын байр суурь, хандлагад өөрчлөлт гарч байгаа” тухай ярьж байв. Өмнө нь тэдгээр байгууллага, компаниуд орон нутгийн нийгэм, олон нийтэд үүсэх нөлөөний талаар төдий л хайхрахгүй байна хэмээн тооцогдож байсан ч одоо бол орон нутгийн иргэд, нийгмийн хэрэгцээ, сонирхолд илүү анхаарал тавьж, хүндэлдэг болсон талаар дурдаж байв. Урьд нь бол зөвхөн орон нутгийн засаг дарга л авах боломжтой байсан мэдээлэл буюу өөрсдийнх нь сум, аймагт хүчин төгөлдөр, идэвхтэй байгаа тусгай зөвшөөрлийн тооны талаар мэдээллийг орон нутгийн иргэд одоо авах боломжтой болжээ. Орон нутгийн Зөвлөлүүд сонирхож байгаа, хэлэлцэх гол асуудлууд нь ОҮИТБС-ын Ажлын албат холбогдож байсан асуудлуудтай төсөөтэй байгааг төлөөлөгч нар дурдаж байв:

- Тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа,
- Компаниуд, орон нутгийн удирдах байгууллага хоорондын хамтран ажиллах гэрээ хэлцлүүд.

Оролцогчдын санал

ОҮИТБС-д ойр нягт холбогдож байгаа, Засгийн Газрын өндөр түвшний ажилтан “ОҮИТБС-ын тайлангуудыг парламентын бүх гишүүдэд системтэй тарааж байгаа боловч, энэ нь парламент дээр албан ёсоор тарааж байгаа явдал биш юм” хэмээн хэлсэн юм. Иймээс парламентын гишүүдийн цаг зав хомс, ОҮИТБС-ын тайлан үлэмж том учраас ОҮИТБС-ын тайланг тэд үнэхээр унших магадлал багатай харагдаж байгаа ажээ. ОҮИТБС-ын тайлангуудыг уншсан хүмүүс санал бодлоо илэрхийлэх, ярих, хэлэлцэх тохиолдол гарахгүй, тайлангууд ийм түлхэц өгөхгүй байна” хэмээн дурдагдаж байв. “ОҮИТБС-ын Ажлын алба “think tank” судалгааны байгууллагуудын үйлчилгээ авах гэрээ байгуулан, ОҮИТБС-ын тайлангуудаас мэдээлэл бэлтгэх нь зүйтэй гэж үзсэн ч хөрөнгө санхүү дутмаг учраас ингэх боломжгүй байна” хэмээх санал хэлж байв. Үйлдвэрийн хоёр төлөөлөгч “Ажлын алба, эсвэл Олон Талын Оролцоот Ажлын Хэсэг нь ОҮИТБС-ын мэдээллийг олон нийтийн ихээхэн хэсэг нь авах, ашиглах боломжийг сайжруулахын тулд ОҮИТБС-ын тайлангуудад орсон мэдээллийг илүү чухал болгон онцолж тавих, инфографик мэдээллийг түлхүү ашиглах нь зүйтэй” хэмээх санал гаргаж байв. Үйлдвэрлэлийн төлөөлөгч нар “хүчин чадал дутаж байгаа учраас УУҮА өөрөө ОҮИТБС-ын тайлангуудыг ашиглаагүй, 2012 оноос хойш явагдсан уул уурхайн салбарын бууралтаас хойш эндхийн ажилтнуудыг цомхтгон дөрвөн ажилтан л үлдсэн тухай” ярьж байв. 2014 онд Оюу Толгой улирал тутам гаргаж байсан эмхтгэлүүд нь ОҮИТБС-ын зарим мэдээллийг компани өөрөө ил болгосон “оноо-картын” мэдээлэлтэй хамт ашиглаж байсныг дурдсан юм. ОҮИТБС нь мэдээлэлд анализ хийхээс илүүгээр тайлан гаргах явц, тоонд илүү анхаарч байгаа хэмээх санал гарч байв. Өгөгдөл, мэдээллийн урт хүснэгтүүдийг хараад өргөн олон нийтийн дунд төрөх сэтгэгдэл бол “уул уурхайн үйлдвэрлэл ойлгоход хэцүү хэвээрээ байна” юм. Иймээс ОҮИТБС-ын мэдээллийн талаар илүү сайн анализ хийх, харах, уншихад илүү тохиромжтой, хараа татах хэлбэрээр тайлангууд, эмхтгэлүүдийг бэлтгэх хэрэгтэй байна.

Зөвлөлдөх уулзалтад оролцсон Орон нутгийн Зөвлөлүүдийн төлөөлөгч нар “ОҮИТБС-ын Нээлттэй Өдрийн арга хэмжээний үеэр л ОҮИТБС-ын талаар мэдээлэл авлаа” хэмээн ярьж байв. Уулзалтад оролцсон хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгч нар “тусгайлсан заавар өгөөгүй л бол ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгсэл Монгол дахь ОҮИТБС-ын вэб сайтаас мэдээлэл авахгүй байна” хэмээн ярьсан юм. Мөн “ОҮИТБС-ын мэдээллийг олон нийтэд хүргэх сувгууд цөөн байна” хэмээн тэд үзэж байв. “Хэдийгээр ОҮИТБС-ын тайлангуудыг жилд нэг удаа хэвлэн нийтэлж байгаа боловч тэдгээрийн мөрөөр ажил явуулах нь бага байна. Монгол улсын нэг хүнд оногдох хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээ нь дэлхийд хамгийн өндөрт орж байгаа улсуудын нэг бөгөөд ялангуяа онлайн сошиал мэдээллийн хэрэглээ үлэмж өндөр байна. Иймээс эдгээр сувгийг идэвхтэй ашиглан ОҮИТБС-ын мэдээллийг түгээх, ОҮИТБС-ын ил болгосон мэдээллийг хэлэлцэхэд олон нийтийг

оролцуулах боломжтой юм” хэмээн яригдаж байв. Түүнчлэн, янз бүрийн салбарт сэтгүүлчдийн сүлжээ байгааг дурдаж, ОҮИТБС-ын мэдээллийг олон нийтэд илүү сайн хүргэхийн тулд ОҮИТБС болон иргэний нийгмийн “Төлсөн авснаа нийтэл” эвсэл ийм сүлжээг хөгжүүлэх нь зүйтэй талаар санал гаргаж байв. Иргэний нийгмийн хэд хэдэн гишүүд “улс төрд хамрагдаж байгаа хүмүүс жил бүрийн 2-р сард гаргадаг, Хөрөнгө орлогын мэдүүлгийг тойрдог олон нийтийн “их сонирхол” нь ОҮИТБС-ын хэвлэгдсэн тайлангуудыг олон нийтээр хэлэлцэхгүй буйгаас нэн ялгаатай байгааг (РЕР-д гаргасан, хөрөнгө орлогын 10 мянга орчим мэдүүлгээс зөвхөн 200-г нь олон нийтэд ил болгодог боловч) онцлон ярьж байв.

Иргэний нийгмийн хэд хэдэн байгууллага сумын түвшний Зөвлөлүүдэд иргэний нийгмийн төлөөлөл дутагдаж байгаад харамслаа илэрхийлж байв. Гэсэн ч, орон нутгийн Зөвлөлүүдийн төлөөлөгч нар “зарим тохиолдолд тохиромжгүй, идэвх муутай, Иргэний нийгмийн байгууллагууд орон нутгийн Зөвлөлд оролцож байгааг” дурдаж байв. Ийм тохиолдолд, өөр байгууллагууд буюу (Иргэний нийгмийн “Төлсөн авснаа нийтэл” эвсэл эсвэл Монголын Байгаль орчны иргэний Зөвлөлд үл хамрагдах), ахмадын, залуусын, эмэгтэйчүүдийн зэрэг холбоодыг оролцохыг урьсан тухай дурдаж байв. Зөвлөгөөнд оролцсон хэвлэл мэдээллийн хэрэгслийн гишүүд орон нутгийн түвшинд өргөн ярьж хэлэлцсэн талаар дурдаж, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд (орон нутгийн парламент) дээр илүү чармайлт гаргахыг санал болгож байв. Ашигт Малтмалын тухай Хуулиар бол, уул уурхайн шинэ лиценз, зөвшөөрлүүдийг батлах, олгохдоо орон нутгийн Хуралтай зөвшилцөн шийдэж байх шаардлагатай ч ингэж ажиллах нь тогтмол бус байна. Энэ нь орон нутгийн Хурлууд уул уурхайн тусгай зөвшөөрөл хүссэн компаниудтай зөвлөлдөхдөө ОҮИТБС-ыг ашиглах боломжтой боловч ингэж ашиглах нь ховор байгааг илэрхийлж байна.

Үнэлгээ

“Энэ шаардлага хангагдаж байна” гэж бид үзэж байна. Олон Талын Оролцоот Ажлын Хэсэг нь ОҮИТБС-ын тайланг ойлгомжтой, идэвхтэй танилцуулж, мэдээлж байдаг болгох, иргэд, олон нийт орж үзэх боломжтой байхыг баталгаажуулахын тулд нэлээд алхмууд хийсэн юм. Орон нутагт мэдээлэл хүргэх сургалт, арга хэмжээнүүд зохион байгуулах замаар, түүнчлэн орон нутгийн ОТОБ-үүд байгуулах замаар Монгол улс дахь ОҮИТБС нь олон нийтийн яриа, хэлэлцүүлэгт, ялангуяа аймаг, сумын түвшинд хувь нэмэр оруулж байхыг баталгаажуулсан байна. Олон нийтийн хэлэлцүүлэг нь лицензүүд, нийгмийн зардал, байгаль орчны тухай заалтуудын мэдээлэл зэрэг ОҮИТБС-ын тайлангуудын тодорхой мэдээллээс үүдэн хийгдэж байгаа ч ОҮИТБС нь бас уул уурхайн секторыг хэрхэн удирдаж байгаа талаар яриа, хэлэлцүүлэг өрнүүлэх суурь боломжийг бүрдүүлжээ. Олон Талын Оролцоот Ажлын Хэсэг нь орон нутгийн ОТОБ-үүдэд зориулан ОҮИТБС-ын үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт оролцуулах, орон нутгийн түвшинд яриа хэлэлцүүлгийг баталгаажуулахын тулд орон нутгийн илүү албан ёсны механизм тогтолцоо байгуулахыг хүсэж магадгүй юм.

2.2 Мэдээлэл авах боломж (#6.2)

Явцыг баримтжуулах

ОҮИТБС-ын Ажлын алба өөрийн вэб хуудсандаа аль эртнээс ОҮИТБС-ын өгөгдөл, мэдээллийг машинаар унших боломжтой, дэлгэмэл Эксел (Excel) хуудсууд болгосон бөгөөд ОҮИТБС-ын бүх тайланд зориулсан хураангуй өгөгдлийн загваруудыг нь Засгийн Газрын тайлан⁹⁰ болон компанийн тайланд⁹¹ авч ашиглах боломжтой юм. ОҮИТБС-ын Олон Улсын Ажлын алба нь үүнийг үндэслэн

⁹⁰ <http://www.eitimongolia.mn/en/government-reports>

⁹¹ <http://www.eitimongolia.mn/en/companies-reports>

стандартчилсан хураангуй өгөгдлийн загварыг эмхтгэж, засгийн газрын санхүүгийн статистик (GFS) ангиллыг оруулсан юм.⁹² Нэгтгэсэн тайлангуудыг 2013 оны ОҮИТБС-ын тайланд үндэслэсэн бөгөөд дөрвөн аймаг, 12 суманд зориулан хэвлэсэн (*дээрээс үзнэ үү*) байна.

Олон Талын Оролцоот Ажлын Хэсэгтэй гэрээ, хэлцлийн талаар хамтран ажилласны үр дүнд ил болох ёстой хэмээн тооцогдож байгаа, газрын тос, шатдаг хийн салбарын Бүтээгдэхүүн Хуваах 20 Гэрээнд (БХГ) зориулж анхлан www.resourcecontracts.org/ сайтад байршуулсан гэрээ хэлцлүүдийн портал байгуулахын тулд Байгалийн Нөөцийг Засаглалын Институт (БНЗИ) нь “Төлсөн авснаа нийтэл” эвсэлтэй хамтран ажиллаж байна.

Монгол дахь ОҮИТБС-ыг бас Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас дэмжиж, ОҮИТБС-ын мэдээ, мэдээллийг автоматаар ил болгох, өргөн олон нийт мэдээлэл авах боломжийг сайжруулах зорилгоор цахим тайлагнах eReporting⁹³ платформыг хөгжүүлсэн. Энэ нь хэрэглэгч нарт уул уурхайн компани болон Засгийн Газартай хамтран ажиллахад шаардлагатай мэдээлэлд хандах боломжийг нэмэгдүүлэх зорилготой юм. Энэ төслийн анхны үе шатыг программ хангамжийн орон нутгийн Интерактив ХХК-тай хамтран Адам Смит Интернешнл байгууллага хэрэгжүүлсэн бөгөөд 2015 оны 1-р сард олон нийтэд танилцуулахын өмнө 2014 оны 8-р сард хэрэгжүүлж дуусгажээ. Тус төслийн зорилго нь тайлан гаргах үйл явцын оновчтой байдлыг сайжруулах явдал бөгөөд ялангуяа хувийн хэвшил, Засгийн Газрын байгууллагуудын тайлан гаргах, тушаах явцыг сайжруулах зорилготой байв. Энэ систем нь мэдээллийг кодолж, цахим хэлбэрээр, найдвартай нэг байршилд хадгалдаг. Цахим тайлангийн систем нь дараах боломжоор хангаж байна. Үүнд:

- ОҮИТБС-ын тайланг хувийн хэвшил, Засгийн Газрын байгууллагын аль аль нь онлайнаар тушаах боломжтой болгох,
- Лицензүүдийн кадастрын зургийг Google-н хиймэл дагуулын зургаар үзүүлэх,
- Олборлох компаниуд тайлангаа онлайнаар тушаах боломж,
- Засгийн Газрын байгууллагууд тайлангаа онлайнаар тушаах боломж,
- Хараат бус хянагч-нэгтгэгч тайланг харьцуулах тохируулга оруулах боломж бүхий Тохируулгын модуль,
- Монгол дахь ОҮИТБС-ын өгөгдлийг харуулах, дүн шинжилгээ хийх, олон нийт хандах боломжтой өгөгдлийн портал.

Цахим тайлангийн системийг анх 2014 оны ОҮИТБС-ын тайланд зориулан ашигласан бөгөөд 2015 оны 3-р сарын 31-ны байдлаар 987 компани, Засгийн Газрын 35 байгууллага өөрсдийн тайланг цахим тайлангийн системээр тушаажээ. Засгийн Газрын байгууллагууд хувийн хэвшлийн 1570 компанийн талаар мэдээлэл өгсөн байна. Тайланг тушаасны дараа мэдээллийн порталаар олон нийтэд нээлттэй болох бөгөөд эцсийн хэрэглэгчид компанийн нэр, ашигт малтмалын төрөл, тусгай зөвшөөрлийн дугаар зэргээр хайлт хийн тайлангуудыг олж, унших боломжтой. Ийнхүү энэ нь олон нийтэд мэдээлэл хүрэх хугацааг түргэсгэж, уншигчдын тоог өргөн хүрээнд нэмэгдүүлж чадсан.

Цахим тайлангийн төслийн хоёр дахь шатыг 2015 оны 8-р сард эхлүүлсэн бөгөөд 2016 оны 12-р сард хэрэгжүүлж дуусах юм. Хоёрдугаар шатны төлөвлөгөөг 2015 оны 10-р сард Олон Талын Оролцоот Ажлын Хэсэг баталсан бөгөөд үндсэн дараах зорилтуудыг хамарч байна. Үүнд:

⁹²<https://drive.google.com/folderview?id=0B7tEEAf2PsWEUjIIV1g2Zy02MFE&usp=sharing&tid=0B7tEEAf2PsWEaF84YkN2MU14Y0U>

⁹³ <http://e-reporting.eitimongolia.mn>

- Цахим тайлангийн туршилтын шатанд тулгуурлан гаргасан хэвлэх боломжтой, өндөр чанар бүхий тохиолдлын /кэйс/. Энэ нь ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа бусад улс орнуудад энэ системийг олшруулах анхны алхам болох юм.
- Тайлан гаргах маягтууд, салбар/тодорхойлолт (онлайн тусламжийн файлууд), тайланг тушаах альтернатив сонголтод санал.
- 2015 оны тайлангийн хугацаанд хэрэгцээт дэмжлэгийг тасралтгүй үзүүлж байх.
- Сонгосон хэрэгслүүдийг харуулахын тулд олдох боломжтой түүхэн өгөгдлийг байршуулах/ачааллах.
- Мэдээллүүдийг нэгтгэж, цахим өгөгдлийн санг автоматаар шинэчилж байх. Мэдээллийн Үндэсний Төвөөр дамжуулан Татварын Ерөнхий Газрын өгөгдлийн санг нэгтгэх зөвшөөрөл аль хэдийн олгогдсон. Ашигт Малтмалын Газрын дөрвөн өгөгдлийн сан салангид, хоорондоо харилцан үйлдэлцэх боломжгүй байгаа учир тэднийг нэгтгэхэд нэлээд хугацаа зарцуулна. Гэхдээ Ашигт Малтмалын Газрын дөрвөн өгөгдлийн санг Мэдээллийн Үндэсний Төвд нэгтгэх техник-эдийн засгийн судалгааг Дэлхийн Банк дэмжсэн бөгөөд 2015 оны 11-р сард уг судалгаа үргэлжлэн хийгдэж байгааг бид тэмдэглэх нь зүйтэй.
- Аливаа ажиллагааны тухай дэлгэрэнгүй мэдээлэл “хайх” сонголттой болгохын тулд тохируулгын процессыг шинэчилж, тайланг автоматаар гаргадаг болгох болон/эсвэл Тохируулагчийн сонгосон тайланд дүн шинжилгээ хийдэг болгох,
- Байгаль орчны мэдээллийг хамарсан, боломжтой байгаа нэмэлт мэдээллийн багцуудыг ачааллах,
- XML/XSD программ хангамжид байгаа бүх мэдээллийг (эсвэл сонгосон хэсгийг) үзүүлэх боломжтойгоор экспортлох.
- Үзүүлэх хэрэгслүүдийг болон хүснэгт, график, кадастрын мэдээлэлд зориулан тайлангуудыг удирдах, боловсруулахад зориулсан нэгтгэх зааврыг сонгох, авах, хэрэгжүүлэх,
- Үйл явцыг тайлбарлахын тулд мэдээллийг задлан хуваахад зориулсан баримтуудын дизайн боловсруулах, Экселийн загварууд, XML/XSD-р дамжуулан импортлох болон процесс/программ хангамжийг зохих ёсоор харуулах.
- Сургалтын төлөвлөгөө, сургалтын агуулга, хичээл, сургалтын материалуудыг тодорхойлох, сургалтын талаар санал авах,
- Хянагч-нэгтгэгч модулийн тайлагнах хэсгийг сайжруулах, хүснэгт, график, зургуудыг автоматаар бэлтгэх (хэрэглэгчийн байршлыг харуулж).

Оролцогчдын санал

Засгийн Газрын хэд хэдэн төлөөлөгч ОУИТБС-ын мэдээллийг өөрсдийн ажилдаа хэрэглээгүй тухай хэлж байв. Шилэн Дансны тухай хуулийг 2014 оны 7-р сараас хэрэгжүүлж эхэлснээс хойш 2015 оны эхэн үеэр хууль бус төлбөр илрэх үед нийгэмд яриа шуугиан дэгдсэн ч ОУИТБС-ын тайланг нийтэлснээс шалтгаалсан эсэх талаар нарийвчилсан шалгалт хийгдээгүй юм. Засгийн Газрын нэг төлөөлөгч өөрийн Хэлтсийн бэлтгэсэн статистик мэдээллийг харьцуулах, батлах хэрэгсэл болгож ОУИТБС-ын мэдээллийг ажилдаа хэрэглэсэн тухай хэлж байв.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн төлөөлөгч нар “ОУИТБС-ын тайлангууд иргэдэд нэн хэрэгтэй ихээхэн мэдээлэл агуулж байгаа ч хүснэгтийн олон мэдээлэлтэй учраас хэцүү, хүндрэлтэй байна” хэмээн дурдаж байв. ОУИТБС-ын хураангуй тайлангуудыг сум, аймгийн түвшинд боловсруулах

талаар Монгол дахь ОҮИТБС-ын гаргаж байгаа хүчин чармайлтууд нь холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэхэд ихээхэн тусалж байна. Хураангуй тайлан нь мэдээллийг хялбаршуулж, уншихад илүү хялбар болгож (график, инфографикаар мэдээллийг харуулж), орон нутгийн иргэдийн байршлаас хамааран тэдний тодорхой хүсэл, хэрэгцээнд тохиромжтой болгож байна.

Үнэлгээ

Энэ шаардлага хангагдаж байна хэмээн бид үзэж байна. ОҮИТБС-ын тайлангууд доторх мэдээллүүд рүү орж унших боломжтой бөгөөд өгөгдөл, мэдээллийг машинаар унших боломжтой хэлбэрээр өгч, олон улсын Засгийн газрын санхүүгийн статистик (GFS) ангиллын танилцуулгыг оруулж, идэвхтэй тарааж байна. Цахим тайлагналын систем нь тэдгээр мэдээллийг өргөн олон нийт унших боломжийг үлэмж сайжруулж, байршилд суурилсан хүсэлтийг биелүүлж байна.

2.3 Олсон сургамж ба саналыг дагуу ажиллах (7.1)

Явцыг баримтжуулах

Олон Талын Оролцоот Ажлын Хэсэг болон Хараат бус хянагч-нэгтгэгч 2013 оны ОҮИТБС-ын тайлангийн санхүүгийн тохируулгын зөрүүтэй мэдээллийн талаар системтэй ажилласан юм. ОТОАХ хэд хэдэн хурал уулзалтын⁹⁴ үеэр “ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үндсэн зорилтуудын нэг нь зөрчилтэй мэдээллийг арилгах явдал бөгөөд энэ талаар ихээхэн анхаарал тавьж байгаа” гэдгийг тодорхой ярьсан байв. 2013 оны ОҮИТБС-ын тайлангийн эх төслийг 2014 оны 10 сарын 10-нд болсон хурлаар хэлэлцүүлэх үеэр ОТОАХ зөрчилтэй мэдээллийн талаар нарийвчлан хэлэлцсэн юм. Тухайлбал, Петро Чайна Дачин Тамсаг компанийн 2013 онд ил болгосон мэдээлэлд 55 тэрбум төгрөгийн зөрчил бүртгэгдсэн нь Петро Чайна Дачин Тамсаг компани газрын тосны борлуулалтын орлогоо Монгол дахь салбараас илүүгээр Хятадын өөрийн салбараар дамжуулан бүртгэснээр тайлбарлагдаж байв. Гэхдээ 2014 оны 7-р сарын “Газрын тосны хууль”-ийн дагуу бол ийм борлуулалтаа Монголын өөрийн салбараар дамжуулан тайлагнах үүрэгтэй⁹⁵ байв. Бусад зөрчилтэй мэдээлэл нь ихэнхдээ импортоор оруулсан барааны гаалийн татвар, НӨАТ, гаалийн үйлчилгээний хураамжийн талаар гаалийн үйлчилгээний тодорхой тайлбар дутагдсанаас, мөн гурван компани тайлангаа тушаагүйгээс шалтгаалж (2013 оны ОҮИТБС-ын тайлангийн 80-р хуудас) байв.

ОҮИТБС-аас өмнө нь гаргаж байсан саналуудыг хэрэгжүүлэх асуудал нь 2013 оноос хойш ОТОАХ болон Үндэсний Зөвлөлийн яриа хэлэлцүүлгийн үндсэн сэдвүүдийн нэг байсан юм. Иргэний нийгмийн хоёр байгууллага буюу Хүний Эрх, Хөгжлийн Төв, “Зориг” сан хамтран 2014 онд ОҮИТБС-ын Үндэсний Тохирлын тайлангуудад дэвшүүлсэн саналуудыг хэрэгжүүлэх нөхцөлийн талаар Хяналтын тайлан” боловсруулж бэлтгэсэн байна. 2006-2011 оны ОҮИТБС-ын тайлангуудад дэвшүүлсэн саналуудын хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн судалгаагаар ОҮИТБС-ын эдгээр зургаан тайланд тусгасан 89 саналыг судалж үзсэн бөгөөд тэдгээр саналын 40 нь ойлгомжтой саналууд байв. Давтагдсан санал нэлээд хэд байсан бөгөөд гурван саналыг ОҮИТБС-ын таван тайланд дэвшүүлж, 28 саналыг ОҮИТБС-ын хоёроос дөрвөн тайланд дэвшүүлж, 12 саналыг ОҮИТБС-ын зөвхөн нэг тайланд тусгасан байв. Саналууд нь салбарын шинэчлэл хийх илүү өргөн хүрээтэй саналуудаас илүүгээр бүхэлдээ ОҮИТБС-ын тайланг бэлтгэх явцтай холбоотой байв. Тус судалгаа нь доорх үндсэн таван төрлийн саналыг тодорхойлжээ:

- Тайлангийн загваруудын талаар саналууд,
- Тайлангийн цар хүрээний талаар саналууд,

⁹⁴ 2014 оны 10 сарын 10-ны өдрийн хурал

⁹⁵ 2014 оны 10 сарын 10 өдрийн ОТОАХ-н хурлын тэмдэглэл, хуудас 4.

- Тайлан гаргаж буй талуудын талаар саналууд,
- Тайлангийн процессыг зохион байгуулах тухай саналууд,
- ОУИТБС-ын ач холбогдол, үр дүнг сайжруулах саналууд байв.

“ОУИТБС-ын тайлангийн саналуудыг 2006-2014 онд хийгдсэн Үндэсний Зөвлөлийн 11 хурлын 8 хурлаар авч хэлэлцсэн” хэмээн дурджээ. ОУИТБС-ын Ажлын алба “40 саналын 27 нь хэрэгжсэн” хэмээн дүгнэсэн тухай судалгаанд дурдсан боловч “үүнээс бага буюу 8 санал л хэрэгжсэн” тухай судалгаагаар дүгнэсэн байв. 32 саналыг хэрэгжүүлж чадаагүйн үндсэн шалтгаанууд нь ажиллагаа хийж болох саналууд дутмаг, хэрэгжүүлэх ажлыг хэн хариуцах талаар тодорхой байдал дутмаг байсан зэрэг шалтгаан юм. Түүнчлэн тус судалгаа нь саналуудыг хэрэгжүүлэхийн тулд ажиллахад дараах дөрвөн үндсэн бэрхшээл байгааг тэмдэглэжээ. Үүнд:

- Саналууд хэт ерөнхий, заримдаа тодорхой бус байсан бөгөөд зарим тохиолдолд хууль тогтоомжтой зөрчилдөж байв,
- Саналуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх эх үүсвэрүүд байхгүй,
- Саналуудыг хэрэгжүүлэх процесс удаан бөгөөд хариуцах тогтолцоо байхгүй,
- Саналуудыг хэрэгжүүлэхэд ОУИТБС-ын оролцогч нарын хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй гэж дурджээ.

Өмнөх ОУИТБС-аас дэвшүүлсэн саналуудын хэрэгжилтийг 2011, 2012, 2013 оны ОУИТБС-ын тайлангуудад болон холбогдох Хараат бус хянагч-нэгтгэгч нар дүгнэсэн ч ерөнхий дүгнэлт болжээ.

2012 оны ОУИТБС-ын тайлангийн хувьд, ОУИТБС-ын Ажлын алба “22 саналын 17 нь хэрэгжээгүй байгааг” тогтоосон бөгөөд хэрэгжүүлж чадаагүйн үндсэн шалтгаанууд нь:

- Дөрвөн саналыг хэрэгжүүлэх шаардлагагүй байсан,
- Таван саналыг хэрэгжүүлэх боломжгүй байсан,
- Хоёр санал тодорхой бус байсан,
- Таван саналын хэрэгжилтийг төлөвлөсний дагуу ангилсан бөгөөд 2014 оны 5-р сарын байдлаар хэрэгжих шатандаа явагдаж байв.

Хэдийгээр ОТОАХ “бүх саналыг бүрэн хэрэгжүүлэх ажил хүлээгдэж байгаа, эсвэл хэрэгжүүлэх боломжгүй” хэмээн үзсэн ч 2013 оныг хамарсан, ОУИТБС-ын сүүлчийн тайланд дэвшүүлсэн бүх найман саналыг ажил хэрэг болгохын төлөө ажилласан байв. 2015 оны 1-р сард хийгдсэн Үндэсний Зөвлөлийн хурлаар 2013 оны ОУИТБС-ын тайланг баталсан бөгөөд тодорхой саналуудыг хэрэгжүүлэх зорилгоор ажиллахын тулд таван ажлын хэсэг байгуулсан юм. Тэдгээр таван ажлын хэсэг тус бүр нь доорх асуудлуудад анхаарчээ:

- Гэрээ хэлцлийг ил тод болгох,
- Байгаль орчныг нөхөн сэргээх заалтууд,
- Ашигт малтмал олборлосны роялти татвар тооцох үндэслэл,
- Тайлан гаргах загваруудыг шинэчлэх,
- Олборлох үйлдвэрүүдийн болон Аж ахуйн нэгжийн орлогын татвар, НӨАТ зэрэг орлогын урсгалын бүтэц хэсгүүдийн зөрүүтэй байдал.

2013 оны ОУИТБС-ын тайлангийн 8 саналыг хэрэгжүүлэх зорилгоор ажилласан талаар:

1. “ОУИТБС-ын тайланд тусгах мэдээлэл өгөх үндсэн Яамдыг хамруулан, Засгийн Газраас

мэдээлэл цуглуулж авах явцыг шалгах хэрэгтэй.” Энэ саналыг авч хэлэлцсэн бөгөөд цахимтайлангийн системийн эхний үе шатанд шалгажээ.

2. “Тохируулах ажиллагаанд компаниудыг сонгон шалгаруулах процессыг сайжруулах нь зүйтэй.” Энэ саналыг тохируулах ажиллагаанд зориулан компаниудыг сонгон шалгаруулахдаа эрсдэлд суурилсан зарчимтайгаар 2014 оны ОҮИТБС-ын тайлангийн эхний шатанд KPMG-с тавьсан байсан.
3. “Санхүүгийн зардал болон оролцож байгаа компаниудын тоонд тулгуурлан материаллаг байдлыг дахин тодорхойлох нь зүйтэй.” 2014 оны ОҮИТБС-ын төслийн эхлэлийн тайланд нэг нь орон нутгийн удирдах байгууллагад төлөх, нөгөө нь Засгийн Газарт төлөх төлбөрт зориулан хоёр тусдаа материаллаг хэмжээг сонгох үед энэ саналыг тусгасан
4. “2014 оны ОҮИТБС-ын тайлан гаргах процессоос өмнө тандалтын судалгаа хийх нь зүйтэй.” 2014 оны ОҮИТБС-ын тайланд зориулсан тандалтын судалгааг KPMG-н төслийн эхлэлийн тайланд оруулав.
5. “Засгийн Газрын байгууллагуудын ОҮИТБС-ын тайланг албан ёсны ахлах ажилтнуудын гарын үсгээр баталгаажуулах, Засгийн газрын тайланг Үндэсний аудитын газар нягтлах нь зүйтэй.” Цахим системээр дамжуулан чанарын баталгааны сертификат олгох процесст энэ саналыг хэрэгжүүлэх юм. Гэхдээ, Засгийн Газрын хэд хэдэн байгууллага зөвхөн нэмэлт оруулсан сертификатын захидлууд олгосон бөгөөд аудит хийгдсэн санхүүгийн тайлангуудын тухай тодорхойлолт дутуу байгааг бид ойлгож байна.
6. “Компаниудын хувьд бол, тухайн хүргүүлсэн мэдээлэл найдвартай гэдэг талаар ахлах менежерийн өгсөн мэдүүлгийг ОҮИТБС-ын тайлангуудад давхар хавсаргах нь зүйтэй.” Цахим системээр дамжуулан чанарын баталгааны сертификат олгох процессод энэ саналыг хэрэгжүүлнэ. Гэхдээ, хэд хэдэн компани зөвхөн нэмэлт оруулсан сертификатын захидлууд олгосон бөгөөд аудит хийгдсэн санхүүгийн тайлангуудын тухай тодорхойлолт дутуу байгааг бид ойлгож байна.
